

МОНГОЛ НУТАГ ДАХЬ

# ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ

Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч  
нарт зориулсан гарын авлага





# МОНГОЛ НУТАГ ДАХЬ ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ :

Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч  
нарт зориулсан гарын авлага

Эрхэлсэн: Г.Анхсанаа

Улаанбаатар  
2020

ННА -  
ДАА -

## МОНГОЛ НУТАГ ДАХЬ ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ:

Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч  
нарт зориулсан гарын авлага

### Редакцийн зөвлөл:

Г.Энхбат  
Г.Эрэгзэн  
Г.Эрдэнэбат

### Зохиогч:

Ч.Амартүвшин  
Г.Анхсанаа  
Н.Батболд  
Ж.Гантулга  
С.Энхболд

### Зөвлөх:

Д.Батболд  
Г.Энхбат  
Г.Эрэгзэн

Тус бүтээлд монголчуудын соёлын өвийг хадгалж хамгаалж ирсэн түүхэн уламжлал болон чулуун соёлын өвийн шинжлэх ухааны тодорхойлолт, соёлын өвийн үнэ цэн, тухайн дурсгалд түгээмэл хэрэглэгддэг мэргэжлийн үг хэллэгийн англи орчуулга, гэрэл болон гар зураг, дурсгалын тархалтын газрын зураг, сүүлийн үеийн судалгааны үр дүн, тоо баримт зэргийг орууллаа.

©Allrightreserved

ISBN:



## ӨМНӨХ ҮГ

<b>Нэг. СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ (Г.Анхсанаа)</b>	11
Түүх, соёлын үл хөдлөх дурсгал ба Монгол нутаг дахь чулуун дурсгалын тухай	12
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын уламжлалт хадгалалт хамгаалалт, түүнтэй холбогдох зарим мэдээ баримт	14
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрх зүйн хамгаалалт	24
<b>Хоёр. ХАДНЫ ЗУРАГ (Н.Батболд)</b>	32
Хадны зургийн ерөнхий танилцуулга	33
Хадны зургийн дурсгалт газруудын байршил	38
Хадны зургийн ангилал	41
Хадны зургийн дүрслэлийн арга барил, хэв маяг	45
Хадны зургийн сэдэв зохиомж	49
Он цагийн хамаарал	59
Хадны зургийн зүй тогтол	68
<b>Гурав. МОНГОЛЫН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ СОЁЛ (Ж.Гантулга)</b>	76
Буган чулуун хөшөөний ерөнхий танилцуулга	77
Буган чулуун хөшөөний судалгааны тойм	80
Буган чулуун хөшөөний гарал үүсэл	85
Буган чулуун хөшөөний төрөл зүйл	90



Хөшөөний дүрслэл, түүний утга агуулга	95
Буган хөшөөний тахилгын байгууламж, түүний зан үйлийн учир холбогдол	113
Буган чулуун хөшөөний он цаг	116
<b>Дөрөв. ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД (Ч.Амартүвшин)</b>	124
Хүн чулуун хөшөөний танилцуулга	125
<i>Хүрлийн үеийн хүн чулуун хөшөөд</i>	128
<i>Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөд</i>	134
<i>Уйгурын үеийн хүн чулуун хөшөөд</i>	142
<i>Хятаны үеийн хүн чулуун хөшөөд</i>	146
<i>Монголын үеийн хүн чулуун хөшөөд</i>	152
Эртний хөшөө дурсгал ба Монгол нутаг дахь хүн чулуудын түүхэн хөгжил	159
<b>Тав. ЭРТНИЙ ТАХИЛ ТАЙЛГЫН ДУРСГАЛ БА ГЭРЭЛТ ХӨШӨӨД (Ч.Амартүвшин, С.Энхболд)</b>	170
Эртний тахил тайлгын дурсгалууд	171
Гэрэлт хөшөөд	172
Хад чулуунд сийлэгдсэн бичээс	176
<b>НОМ ЗҮЙ</b>	
ХАВСРАЛТ 1. Улсын хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт	
ХАВСРАЛТ 2. Улсын хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тархалтын зураг	
ХАВСРАЛТ 3. Мэргэжлийн үг хэллэгийн жагсаалт	

## ӨМНӨХ ҮГ

Соёлын өвийг хамгаалахад олон чиглэлийн салбар, байгууллага хамтран ажилладаг бөгөөд үүний нэг нь аялал жуулчлалын салбар юм. Аялал жуулчлал нь улс орны эдийн засгийг дэмжих, чадавхийг сайжруулахаас гадна тухайн улс, үндэстний өвөрмөц соёлыг бусдад танилцуулж, хүний оюун ухаан, мэдлэг, боловсролд эерэг нөлөө үзүүлж, өөрийн болон бусдын соёлыг хүндэтгэн үзэх, цаашлаад эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах төлөвшлийг бий болгодог.

Монголчуудын уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маяг, ардын язгуур урлаг, зан заншил, байгаль, сав шимийн ертөнцийг таних арга ухаан зэрэг нь дэлхийн аялагчдын анхаарал, сонирхолд илүүтэй өртөх болсон энэ цаг үед энэхүү ахуй соёл нь байгаль, газар дээр ил оршин байгаа дээрх түүх, соёлын өв дурсгалт газартай хослон өөрийн өвөрмөц соёлын орон зайг бий болгож байна. Энэхүү байгалийн болон соёлын өвийн өвөрмөц орон зай нь манай орны хувьд дэлхийн аялал жуулчлалыг өөртөө татах ирээдүйн хандлага юм.

Монгол Улсын Засгийн газар хээр хөдөө орших түүх, соёлын дурсгал, үүн дотроо байгалийн хад чулуун дээр зурсан хадны зураг, бичээс, түүхийн олон цаг үед хамаатах хүн чулуу, буган чулуун хөшөө зэргийг хамгаалах зорилгоор 2019 онд 69 дүгээр тогтоолоор “Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх,

жуулчдын хөтөч тайлбарлагч нарт зориулан чулуун соёлын өвийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх үүднээс хялбаршуулсан гарын авлагаар хангах ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнд тус тус даалгажээ.

Соёлын өв, түүн дотроо чулуун дээр мөнхрөн үлдсэн зураг, бичиг үсгийн дурсгал хийгээд хөшөө чулуун дурсгалаар Монгол орон нэн баялаг. Хадны зураг, буган хөшөө, хүн чулуун хөшөө зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалын шинжлэх ухааны судалгаа манай улсад амжилттай хийгдэн, тодорхой үр дүнд хүрч байгаа бөгөөд энэ чиглэлийн судалгааны бүтээл, ном зохиол цөөнгүй байна. Хэдий тийм боловч судалгааны тэдгээр бүтээлүүд нь энгийн хүмүүс уншиж ойлгоход хүнд, мөн шинжлэх ухааны нэр томъёо ихтэй байдаг. Тиймээс судалгааны эдгээр бүтээлүүдийг нэгтгэн хөтөч тайлбарлагчдын ажлын хэрэгцээнд тохируулан хялбаршуулж, тэдэнд тусгайлан зориулсан агуулгаар баяжуулан хөтчийн гарын авлага буюу ном болгон хэвлэн гаргах нь аялал жуулчлалын салбарт нэн чухал хэрэгцээтэй гэж бид үзлээ.

Энэхүү гарын авлагад монголчуудын соёлын өвийг хадгалж хамгаалж ирсэн түүхэн уламжлал, эртний хууль цаазад тусгагдсан зүйл заалтууд болон Монгол Улсын төр засгаас гаргаж байсан шийдвэр болон одоо мөрдөгдөж байгаа хууль, журам, чулуун соёлын өвийн төрөл тус бүрийн шинжлэх ухааны тодорхойлолт, соёлын өвийн үнэ цэн, тухайн дурсгалд түгээмэл хэрэглэгддэг мэргэжлийн үг хэллэгийн англи орчуулга, гэрэл болон гар зураг, газрын зураг, чулуун дурсгалын талаар гарсан сүүлийн үеийн судалгааны үр дүн, тоо баримт, зарим онцлог дурсгалт газрын дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг багтаав.




Ингэснээр соёлын өв, чулуун дурсгалын талаарх монголчуудын уламжлалт үзэл хийгээд шинжлэх ухааны бодит мэдээллийг хөтөч тайлбарлагчдаар дамжуулан жуулчдад түгээн дэлгэрүүлж, өөрсдийн түүх, уламжлалаа дэлхий нийтэд үнэн зөвөөр таниулан, сурталчлах чухал ач холбогдолтой болно.

Энэхүү бүтээлийн нэгдүгээр бүлгийг Г.Анхсанаа, хоёрдугаар бүлгийг Н.Батболд, гуравдугаар бүлгийг Ж.Гантулга, дөрөвдүгээр бүлгийг Ч.Амартүвшин, тавдугаар бүлгийг Ч.Амартүвшин, С.Энхболд нар бичсэн бөгөөд мэргэжлийн хэллэг, нэр томъёоны орчуулгыг Т.Түвшинжарал, зураг чимэглэлийг А.Мөнгөнцоож, аялал жуулчлалын зөвлөхөөр Д.Батболд, соёлын өвийн зөвлөхөөр Г.Энхбат, түүх, археологийн зөвлөхөөр Г.Эрэгзэн нар ажиллав. Мөн бүтээлийг хийхэд туслалцаа үзүүлсэн Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн багш Э.Мижиддорж, Б.Галбадрах нарт талархал илэрхийлье.

# НЭГ.

СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ  
ХАМГААЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ



## ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ БА МОНГОЛ НУТАГ ДАХЬ ЧУЛУУН ДУРСГАЛЫН ТУХАЙ

1972 онд НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц”-д “Соёлын өв” гэдэг ойлголтыг

- Хөшөө дурсгалууд: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдворууд, бичээс, агуй болон цогцолбор дурсгалууд,

- Уран барилгын чуулган: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж уран барилгуудын цогцолбор,

- Түүхийн дурсгалт газрууд: хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатан судлалын хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг хамаарна гэжээ.

Өдгөө нийт хүн төрөлхтний түүхэнд бүтээсэн эдийн болон оюуны соёлын өвийг уламжлагдаж ирсэн хэлбэрээр нь соёлын биет ба биет бус өв хэмээн ангилан авч үздэг. Соёлын биет бус өвд оюуны соёлын бүхий л өв хамаарах бол соёлын биет өвд материаллаг



түүхий эдээр бүтээгдсэн бүх дурсгал хамаарах ажээ.

Соёлын биет өвийг хадгалагдаж буй орчин нөхцөл, эх төрхөөр нь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл ба түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэж хоёр хэсэгт хуваадаг. Манай улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.3-д “түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг хэлнэ” хэмээн томъёолсон бөгөөд мөн хуулийн 5.1-д “Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

- 5.1.1. эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;
- 5.1.2. эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;
- 5.1.3. чулуун зэвсгийн олдворт газар;
- 5.1.4. хадны зураг, бичээс;
- 5.1.5. булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;
- 5.1.6. эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;
- 5.1.7. хөшөө дурсгал;
- 5.1.8. эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;
- 5.1.9. тахилгат газар;
- 5.1.10. түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;
- 5.1.11. бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал” хэмээн заасан байдаг.

Манай улсын нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг дотор нь ангилан авч үзвэл палеонтологи, археологи, архитектурын шинжлэх ухааны судлагдахуунуудаас бүрддэг. Эдгээр

судлагдахуунаас археологийн дурсгалыг голчлон чулуугаар болон чулуун дээр үйлдсэн байдаг онцлогтой. Хүн төрөлхтний анхны багаж, зэвсэг нь байгалийн чулуу байсан бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн түүхэн үе бол чулуун зэвсгийн үе юм.

Монголын археологийн дурсгалын үндсэн төрлийн нэг болох хадны зураг, тамга, тэмдэг, бичээс зэрэг эртний урлагийн үүсэл, түүхийн сурвалжийг өөр дээрээ хадгалсан дурсгалыг агуйн хана, тааз, байгалийн хад чулуун дээр сийлэх, зосоор будах зэргээр урлаж үлдээсэн байдаг бол өвөг дээдэс, баатар эрсээ дурсан босгосон олон үеийн хөшөө дурсгалыг мөн л бүгдийг чулуугаар урлан бүтээж үлдээжээ. Түүнчлэн нөгөө ертөнцөд одогсдоо оршуулсан булш бунхан, тахил тайлгын байгууламжийг тогтсон тусгай зан үйлийн дагуу чулуугаар үйлддэг байв. Ингэхдээ ямар төрлийн дурсгал үйлдэхээс хамааран тухайн орон нутагт элбэг тохиолдох хад чулууг оршин байгаа газар нь эсвэл зөөж ашигласан нь харагддаг. Түүгээр ч зогсохгүй эрт үед хөшөө дурсгалыг урлахдаа тохиромжтой чулууг олборлон авч байсан баримт мэдээ бий.

Тиймээс түүхийн аль нэг үед тухайн бүс нутагт аж төрж байсан хүмүүсийн нийгэм, соёлын түвшнийг илэрхийлэх бүх талын мэдээллийг зураг, бичиг болон хэлбэр дүрсээр дамжуулан өнөө үед тээж ирсэн хадны зураг, тамга тэмдэг, бичээс, хөшөө дурсгал (буган чулуун хөшөө, түрэгийн үеийн болон XIII-XIV зууны үеийн чулуун хөргүүд, олон төрлийн бичээст гэрэлт хөшөөд г.м), тахилын байгууламж зэргийг чулуун дурсгалд хамруулан тооцдог.

Энэ бүх зүйлс хүн төрөлхтний өнгөрсөн цаг үеийг таньж мэдэх гол судлагдахуун болж, түүхийн мэдлэг бүтээхэд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэж байдаг тул түүний гадаргуу дээр хадгалагдан үлдсэн үнэт зүйлсийг байгалийн болон нийгмийн сөрөг нөлөөллөөс хамгаалж оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь нэн чухал болно.

Сүүлийн жилүүдэд дээрх төрлийн чулуун дурсгалын судалгаа шинжилгээний ажил нэлээд эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд олон чухал үр дүнд хүрсээр байгаа. Тэрчлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2015 онд улс орон даяар зохион байгуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогоор нийт 9537 дурсгалт газрыг хамруулснаас 3500 орчим буюу 36%-ыг хадны зураг бичээс, хөшөө дурсгал, тахил тайлгын байгууламж бүхий дурсгалт газар эзэлж байна.

### **ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ХОЛБОГДОХ ЗАРИМ МЭДЭЭ БАРИМТ**

Монголчууд эртнээс өвөг дээдсийн бий болгож бүтээсэн түүх, соёлын аливаа дурсгалд хүндэтгэлтэй хандаж олон арга хэлбэрээр хамгаалж ирсэн баялаг уламжлалтай. Ингэхдээ зан заншил, шүтлэг бишрэлээр дамжуулан сургаал, номлол зэрэг уламжлалын хэлбэрээр болон эртний хууль цааздаа тусгайлан цаазлан хориглож байжээ.

Ялангуяа хүүхэд багачуудад бага балчраас нь эртний дурсгалт зүйлийг хөндвөөс “чөтгөр сэрнэ, чөтгөр дагана, сүнс нь хорогдоно, нүд чинь сохорно, гар чинь татна, муу зүйл тохиолдоно...” гэх мэтээр сургаж тэдгээрт аль болох хүндэтгэлтэй хандах сэтгэлтэй болгон хүмүүжүүлдэг байсан уламжлал эдүгээ ч хөдөө орон нутаг бий. Мөн зарим нутагт буган чулуун хөшөө, хүн чулуу болон тамга тэмдэг сийлсэн хөшөө болон цулгуй хөшөө чулууг янз бүрээр тахин шүтэж, хөшөөг хөдөлгөж, оролдож болохгүй, эсвэл унасан хөшөөг босгож болохгүй “ган гачиг, зуд турхан болж тэр нутгийн мал сүрэгт муу зүйл тохиолдоно, өвчин хууч гарч хүн ардыг гай тотгор дайрна” гэхчлэн цээрэлдэг байжээ. Түүнчлэн хадны зургийг дуурайлган



зурах, дээр нь сараачвал “лус савдагийн мал сүргийг оролдож байгаа хэрэг” хэмээн мөн цээрэлдэг бол заримдаа онцгой содон тогтоцтой уул, хад, мод, чулуу, хөшөө дурсгалыг ажил үйлс бүтээгч, үр хүүхэд заяагч, өвчин хууч эмнэгч хэмээн янз бүрийн дом үйлдэн сүсэглэх явдал ч бас бий.

Түүнчлэн нийт монголчуудын үнэт зүйл болсон их хааны нэр сүрээр дурсгалыг хамгаалах нэг хэлбэр бас байсан бөгөөд “Чингисийн суудал”, “Чингисийн тулга”, “Чингисийн морины уяа”, “Чингисийн гүүн зэл” гэх зэргээр зарим дурсгалыг домоглон нэрлэж, түүнд ойртох, хөндөхийг цээрэлсээр ирсэн байдаг.

XVI зууны сүүл үеэс Монголд маш богино хугацаанд эрчимтэй дэлгэрч ард олны сэтгэл санааг эзэмдэн, уламжлалт соёлын салшгүй хэсэг болсон шарын шашны сургаал, номлолд эртний түүх, соёлын дурсгалыг хамгаалах зарим үзэл санаа туссан байдаг. Үүний нэгэн жишээ нь хүн чулуун хөшөөг шашны зан үйлээр тахиж байсан явдал юм. Тодруулбал, Өвөрхангай аймгийн Уянга сумын Хадан хошуу хэмээх газарт буй нутгийн ардууд “Цагаан уушхай” гэж нэрлэсэн хүн чулууны дэргэд сүм барьж “уушхай”-д бомбо ёсны хувцас өмсгөн лам хүн ном уншин тахидаг байсан ба тахилын ламыг Сайн ноёны хошуу хүрээ Цэмпилэн хийдээс ээлжээр гаргаж ламын хэрэгсэл (3 хонь) зэргийг хошууны ард олноос алба болгон гаргуулдаг байсан баримт бий. Үүнтэй холбогдуулан Хөвсгөлийн “Даян дээрх”, Ингэт Толгойн “Далха вандад”, Өвөрхангайн Хан хөгшин уул хавийн олон “Уушхай”, Хэнтийн “Гэлэн чулуу”, Дорнодын “Ловх”, Баян-Өлгийн “Даян баатар” зэрэг олон хүн чулууг тусгайлан тахиж байсан мэдээ баримт байхын зэрэгцээ өдгөө ч зарим дурсгалыг зохих хэмжээгээр нутгийн ард иргэд тахин шүтсээр байна.

Энэ нь аливаа түүх, соёлын дурсгалыг зан заншил, шүтлэг бишрэл,

сургаал номлолын уламжлалт хэлбэрээр дамжуулан хамгаалах, хойч үедээ үлдээх нэгэн төрлийн хамгаалах арга болж байжээ.

Монголчууд эртний булш бунхан түүний оршуулгын зан үйлийг нь өөрсдийн аж ахуйн онцлог, ертөнцийг үзэх үзлийн төлөвшилтөөс хамааран байгальтайгаа салшгүй холбоотой байдаг соёлын чухал илэрхийлэл, соёлын өв хэмээн чухалчилсаар иржээ.

Харин өвөг дээдээс уламжлан ирсэн энэхүү чухал өв болох булш бунхныг сүйтгэх, тонох явдал эрт үед цөөнгүй байсан бололтой. Энэ бүхнийг мэддэг байсан учир монголчууд хаад ноёдынхоо шарилыг “Ихсийн газар”, “Их хориг” гэх газар нууцалж оршуулдаг байж. Мөн нууцалж оршуулахаас гадна тэдгээр булш бунхныг сэргийлэн хамгаалдаг, арчилж торддог, тахилга хийдэг үүрэг бүхий хүмүүс (тусгай отог) хүртэл байжээ. Үүнтэй холбоотойгоор булш бунхан ухах, тонох, сүйтгэхээс сэргийлсэн зүйл заалтыг тэр цагийн хууль цаазын бичигтээ мөн тусгаж байжээ. Тухайлбал, Чингис хааны «Их засаг» хуулиар бусдын булш бунхныг ухаж төнхөх, эвдэж сүйтгэхийг цаазлан хориглож байв. XIII зууны Монголын хууль цаазын нэгэн бичигт: “Бусдын гэр орон булш, бунхныг эвдэж тонохыг цаазалмой” гэж заасан байдаг бол «Алтан хааны цааз» -д “оршуулгын газраас гэртээ орвоос хүний тоогоор мориор торго, оршуулгын газраас эд юм авбаас амьд хүний эд юмыг авсан адил цаазтай, үхсэн хүний ясыг хөдөлгөж ясыг барьваас сан тавиул, тэр мэтэс сонсвоос есөн есөөр торго ...” гэх мэт заалтууд нь монголчуудын дунд буддын шашин дэлгэрч эхлэх үеийн үйл явдлыг тусгасан бололтой байдаг. XVIII зууны Монголын хууль цаазын үнэт дурсгал болсон «Халх журам» -д энэ талаар “...бас ер хэн хүн их яамт хүний булш эвдвээс нэг ест”, “энгийн хүний булш эвдвээс хөлт”, “засгийн онголсон газар хоёр хар цагааны газраас дотогш” хүн бууж мал нь

---

\* *Хоёр хар цагааны газар - малын зүс ялгарч харагдах газрын хэмжээ*

хөндвөөс малын эзний хөл морь ав", "хэн хүн их яамт хүний булш эвдвэл нэг ест, бага яамтыг болбоос тавт, энгийн хүнийг болбоос хөлт", "ихэсийн онголсон газар хоёр хар цагааны газраас дотогш хүн бууж мал нь хөндвөл малын эзний хөл морийг ав", "Хэн нэгэн этгээд дархалсан газар ихэс дээдсийг оршуулсан газар бууж, хөрс газрыг гэмтээхийг" цаазлан хориглож, зөрчигсдөд хүлээлгэх ял шийтгэхийг тодорхойлон заасан байна. Арай хожуу үеийн хууль цаазын бичиг буюу «Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засан явуулах хууль зүйлийн бичиг» -т уг заалт нарийсаж, торгох шийтгэл нь өөрчлөгдөж биеэр ял эдлүүлэх болсон байна.

Гэсэн хэдий ч өдгөө манай орны нутагт дэвсгэр дээр түүхийн олон үед хамаарах янз бүрийн дурсгал хадгалагдан үлдэж бидний үед уламжлагдсан бөгөөд он цагийн уртад бүтээгдсэн эдгээр дурсгал нь нүүдлийн иргэншлийн нөхцөлд ихэвчлэн хүн ам байнга оршин суудаггүй, хөдөө хээр, ил задгай газар орших учир байгаль, цаг уурын тааламжгүй нөлөөлөлд элэгдэн хуучирч унаган хэлбэр төрхөө алдах, эвдэрч гэмтэх, устаж үгүй болох явдал багагүй байжээ. Мөн үүний зэрэгцээгээр эртний олон овог, аймаг хямралдан тэмцэлдэж, өөр хоорондын атаа хорсол зэрэг шалтгаанаар өмнөх үеийнхээ буй болгосон түүхийн дурсгалт зүйлс, булш бунхан, хөшөө дурсгалыг дайсагнан халдаж, эвдэн сүйтгэж байсан тухай түүх сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн нь ч бий.

Энэ мэтээс үзвэл Монгол нутагт орших түүх, соёлын дурсгалууд нь байгаль, түүхийн өвөрмөц нөхцөлд он цагийн шалгуурыг давж хадгалагдан үлдсэн байна.

Ингэж түүхийн олон үеийг дамжин цаг хугацааны шалгуурыг даван үлдсэн дурсгалууд тэр дундаа чулуун дурсгалуудын ихэнх нь ямар нэг байдлаар элэгдэж мөлийхөөс эхлээд холторсон, хагарч хугарсан, унагааж хэвтүүлсэн, зөөгдсөн байдалтай байдаг. Ихэнх



хөшөө дурсгалд эрт үед эвдэрч гэмтээд байгалийн хатуу ширүүн нөхцөлд нэмж элэгдсээр байхын хажуугаар нутгийн оршин суугчид ч нэмж гэмтэл учруулж байдгийг судлаачид бас анхааруулсаар байжээ.

Эрт үеийн хөшөө дурсгалыг дараа үеийн хүмүүс ямар нэгэн байдлаар эвдэж гэмтээх, байрнаас нь зөөж өөр газарт аваачих, аж ахуйн буюу бусад ямарваа ямар нэг зорилгоор ашиглах зэрэг үзэгдэл хүн төрөлхтний бүх түүхийн туршид байсан нь манай орны хөшөө дурсгалыг ч тойроогүй нь тэдгээрийн одоо байгаа байдлаас тодорхой мэдэгдэнэ. Үүний жишээ нь хүрлийн үеийн буган чулуун хөшөөг дөрвөлжин булшны хана болгон ашиглах, хожим дахин засч янзлан хүн чулуу болгон хувиргах, дундад зууны бичээс бүхий хөшөөн дээр бурхан шашны маанийн үсэг сийлсэн зэргээс харж болно.

Энэ талаар нэрт археологич Д.Баяр “Монгол нутаг дахь хүн чулуун хөшөө [Улаанбаатар, 2001]” хэмээх нэгэн сэдэвт бүтээлдээ Түрэгийн үеийн хүн чулууны хадгалалт хамгаалалтын түүхэн уламжлалын талаар хөндөж, судалгааны олон сонирхолтой баримт мэдээг цуглуулсан байдаг. Түүний бүтээлд байгаа зарим сонирхолтой мэдээ баримтыг сийрүүлбэл, “...Зөвхөн хүн чулууны талаар авч ярихад л, тэдгээрийн ихэнх нь одоо хүртэл анхны байсан тэр л газар нутаг, буурин дээрээ байгаа нь эрдэмтэн, судлаачдын ажилд асар их тус нэмэр болж байгааг хэлэх юун. Дурсгалын анхны байршлаас гадна тэдгээр нь он жилийн уртыг хэрхэн туулж бүрэн бүтэн байдал, анхны хэв төрхөө аль зэрэг хадгалж чадсан тухай асуудал юм. Бүтнээрээ өнөөг хүртэл уламжлан ирсэн хүн чулуу нэлээд байх нь ихэвчлэн хамгийн болхи муу хийцтэй элдэв дүрслэл багатай хөшөөд байх ба Түрэгийн алдар цуутай хаад, жанжин нарын цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд байгаа хүн



*Оросын эрдэмтэн А.Д.Клеменц нар Орхоны хөндийд Билгэ хааны гэрэлт хөшөөг судлаж байгаа нь (Монголчууд: Харийн тамган доорх нүүдэлчид (XVII-XX зууны эхэн, 2016)*

чулуу, адгуус амьтны дүрсийг зориудаар зэвсэг багаж хэрэглэж, хэмх цохин, эвдэж устгасан байдал мэдэгддэг. Харин ганц хүн чулуутай багахан дурсгалуудын хувьд бол ихэнх нь бүтнээрээ байх ба эвдэж устлаа гэхэд толгойг нь хуга цохисон нь ойролцоо дэргэд нь байх тохиолдол их байна.

Энэ байдлаас үүдэн хөшөө чулуудыг чухам хэн хэдийд эвдэлсэн, энэ нь эрт үед үү, эсвэл хожуу цагт уу гэх асуулт аяндаа гарч ирэх бөгөөд Түрэгийн хөшөө дурсгалыг хэн хэдийд эвдэж устгасан талаар судлаачид янз бүрийн баримтад тулгуурлан хэд хэдэн янзаар тайлбарладаг байна. Тухайлбал, Хөшөө Цайдамын том онгонуудын хувьд Түрэгийн хаант улсыг мөхөөн дарсан уйгурууд эвдэлсэн гэж үздэг бөгөөд ерөөс Монголын төв нутагт буй томоохон дурсгалуудад нийтлэг хамаарах нь тодорхой ажээ. Тоньюкукын цогцолбор, Их хөшөөт, Шивээт улаан, Онгийн голын дурсгал зэрэг нь мөн л дээрхтэй төстэй байдлаар эвдэрсэн байна. Харин үүнтэй холбогдуулан лавтгаж тодруулуштай нэг зүйл буй нь эрдэмтэн Г.Е.Грум-Гржимайло “Баруун Монгол ба Урианхай хязгаар [Ленинград, 1926]” хэмээх номондоо Куль-Тегин ноёны хөрөг XIII зууны үед бүтнээрээ байсан хэмээн түрэг судлаач Девериа-гаас ишлэн өгүүлсэн нь үнэхээр сонирхолтой бөгөөд дахин сайтар нягтлууштайг сануулсан байна.

Мөн Францын нэрт аялагч Буияи до Лакат /1867-1937/ нь 1909 онд Монголд ирэхэд Хөшөө Цайдам дахь гэрэлт хөшөөдийг хамгаалж



*Хөшөө Цайдамын гэрэлт хөшөө дээр барьсан байшин*

тоосгоор барьсан байшин болон зарим хүн чулуу хөшөө босоогоор байсан нь түүний гэрэл зурагт хадгалагдаж үлдсэн байдаг.

Түүнээс гадна хүн чулуу нь ойр тойрон нутаглаж буй хүн малд муу нөлөө үзүүлнэ гэж хожмын монголчууд толгойг нь хугалж байсан тухай нэлээд судлаачид тэмдэглэсэн байна. Тодруулбал, Зөвлөлтийн судлаач Б.Я.Владимирцов “монголчууд хөшөө чулууг амьдрал ахуйдаа их л ойр дотноор тусгаж хөгтэй сонин түүх ярих дуртай атал, нөгөөтэйгүүр тэдгээрээс тун их айж биширдэг, хүн чулууг тахин шүтэж, маань тарний үсэг бүхий цаас хуучин булшинд өлгөж зүүх ба мал сүрэгт гай барцад учруулна хэмээн толгойг нь хуга цохих, бүрмөсөн устгаж үгүй хийх, газарт булах нь ч бий. Иймээс Монголд бүтнээрээ буй хүн чулуу олдох нь туйлын ховор байдаг” хэмээн бичсэн байна.

Мөн 1930-аад оны эхээр монголд судалгаа хийсэн Зөвлөлтийн судлаач В.А.Казакевич “Би өөрөө ч монголчуудын амнаас, хэрэв ойр орчимд буй мал сүрэг тарга тэвээрэг авахгүй бол хүн чулууны толгойг хуга цохидог тухай цөөнгүй сонсож байсан” гэж тэмдэглэсэн нь бий. Харин бид хээрийн шинжилгээний ажлаар явах үедээ хөдөөгийн хүмүүстэй уулзан ярьж байхад ийм зүйл огт дуулж байгаагүй бөгөөд гагцхүү аль нэгэн хүн чулуу босоо байвал тэнгэр агаар мууддаг хэмээн заавал хэвтүүлж орхидог заншил байдаг тухай сонсож байлаа. Нэгэнт эхэн үеийн судлаачид сонсож

тэмдэглэсэн болохоор хүн чулууны толгой хуга цохих заншил монголчуудын дунд аль нэгэн хэмжээгээр байсан бололтой. Тэгэхлээр иймэрхүү сүсэг бишрэлийн холбоотой зан үйл нь хэдийгээр өргөн хэмжээтэй бус ч гэсэн хүн чулуу эвдрэхийн бас нэгэн шалтгаан болж байсныг үгүйсгэх аргагүй.

Түүнчлэн, Монгол оронд бурханы шашин дэлгэрч, эртнээс шүтэж ирсэн бөө мөргөлийн онго шүтээнийг эвдлэн устгах болсноос үүдэн эрт үеийн шүтлэг тахилгын зүйл болох хүн чулуун хөшөөг эвдэн устгаж байжээ хэмээн археологич Н.Сэр-Оджав тайлбарласан нь бий. Хүн чулууны эвдрэл гэмтлийн шалтгааныг ийнхүү тайлбарлахдаа шарын шашин хүчтэй дэлгэрсэн Монголын төв нутгаар буй хүн чулууны ихэнхийн толгой салсан байхад баруун талын нутаг болон Тува, Алтайд буй дурсгалын ихэнх нь бүтэн байгаа гэдгийг гол болгожээ.

Мөн энэ талаар буюу Монгол нутагт оршиж байгаа чулуун дурсгалууд тэр дундаа түрэгийн үеийн хүн чулуудын толгой салж унасныг арай өөр талаас тайлбарласан судлаач бол М.Хурметхан юм. Тэрбээр “ер нь хүмүүс зөвхөн хүн чулуу, адгуусны баримлын толгойг хэмх цохиж байсан гэдэг нь үнэмшилгүй бөгөөд Билгэ хаан, Күльтегин, Тоньюкукийн сүрлэг хөшөө нь мөн тэнд байж, бараг муу үйлдэлд өртөлгүй бидэнд уламжлагдан ирсэн, харин цаг хугацаа, экологийн хүчин зүйл элээсэн нь үнэн билээ.

Түрэгийн хүн чулуун хөшөөд дотроос хамгийн их ур чадвар гарган бодит байдалд нэн дөхүү урласан 66 хөшөөний толгой хэмхэрч устсан байна. Энэ нь хүн чулуун хөшөөний толгойн хэсэг том, жин нь хүнд (Күльтегиний хөшөөний толгойн өндөр 41 см, өргөн 20 см, зузаан 21 см) бол хүзүүний хэсэг нарийхан байх тул цагийн уртад чулууны бүтэц гэмтэлд орж, улмаар байгалийн нөлөөгөөр (газар хөдлөлт г.м) тэдгээр нь нэгэн зэрэг юм уу дараалан хугаран унасан

бололтой. Харин хүзүүний хамгийн зузаан, хийц муутай (Чойр, Даян баатар г.м) урласан хөшөөнүүд бүрэн бүтэн байгаа нь үүнийг гэрчилж байна. Хэмжээгээр бага, өмнө нь хүний үйлдэлд өртсөн, газар унасан толгойн хэсэг нь чулууны чанар зэргээс шалтгаалан зарим нь устаж, зарим нь үлджээ” хэмээн бичсэн байна.



*Өнгөтийн цогцолборын хүн чулуун хөшөөд  
(Монгол орон Монголчууд 2017)*

## **ТҮҮХ, СОЁЛЫГ ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЭРХ ЗҮЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ**

Өмнө өгүүлсэнчлэн Монголчууд түүх, соёлын дурсгалыг олон төрлийн арга хэлбээр хамгаалж, хойч үедээ уламжлуулсаны нэг нь эртний хууль цаазын бичигтээ хуульчлан тусгаж байсан явдал юм. Төрт ёсоо сэргээн мандуулж, дахин тусгаар тогтносон Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсын төрийн таван яамны тэргүүлэх яам болох Дотоод хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны нэн чухал үүрэг нь улсын түүх, шаштир хууль зүйл, гэрээ бичиг, өрх амын данс, газар орны зургийг хадгалах, олон ван гүн, тайж, түшмэлийн зэрэг залгамжлах гэрийн үеийн бичмэлийг хадгалах явдал байжээ. Энэ нь чухамхүү улс орны дотоод амьдралыг удирдан жолоодох, түүх



соёлын өвийг хадгалан хамгаалж өвлүүлэх асуудлыг Богд хааны удирдсан Засгийн газар хууль эрхзүйн хүрээнд батлан мөрдүүлсэн хэрэг мөн хэмээн манай зарим судлаачид тэмдэглэдэг.

Харин Монгол Улсад соёлын өвийг хамгаалах талаар төрийн цэгцтэй бодлого Ардын хувьсгал ялсны дараагаас боловсорч эхэлсэн гэж үзэж болно. Монголын шинжлэх ухааны анхны байгууллага Судар бичгийн хүрээлэнг байгуулах тухай Засгийн Газрын тогтоол 1921 оны 11 сарын 9-нд гарч түүх, соёлын дурсгалыг бүртгэх, судлан боловсруулах ажлыг эхлүүлжээ. Судар бичгийн хүрээлэнгийн дүрэмд “дэлхий дахины улсын бичиг судрын сан ба музей үзмэрийн зүйлийг хураах ... монгол үндэстэнд холбогдох бичигтэй хөшөө, чулуун зураг зүйлүүдийг хамгаална” гэж заасан байдаг нь төрөөс соёлын өвийн талаар баримтлах анхны эрхзүйн баримт болсон байна.

Судар Бичгийн Хүрээлэнгээс 1924 оны 8 сарын 7-нд батлан гаргасан “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм” бол манай улсад эртний түүх, соёлын үнэт зүйлсийг үнэлэх, судлан шинжлэх, хадгалж хамгаалах талаар гаргасан үндсэн эхний баримт бичиг байв. Монгол Улсын хэмжээнд дагаж баримталж байсан төдийгүй гадаад оронтой байгуулсан эрдэм шинжилгээний гэрээ, хэлэлцээрт тусган мөрдөж байсан уг дүрмийн дотор, Монгол улсын хязгаар дотор буй хуучны дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө болох, хуучны дурсгал гэдэгт эх түүхэнд холбогдох бичиг зураг бүхий ба бичиг зураггүй булшны чулуу, хөрөг, жич зураг бичигтэй ба зураг бичиггүй хад, пайз, чулуун пайлуур, багана зэргийн зүйл, жич хуучин цагийн зоосны аймаг, чулуу шороо овоолох зэргээр үйлдсэн булшууд бүх хэрэгслийн хамт, эрт цагийн эвдэрхий хот балгас зэрэг зүйл, орон сав зэрэг эртний түүх ба онгон тахилга, холбогдох урлан үйлдсэн зэрэг зүйлийг ойлгох ба газрын

дээр буюу доороос археологийн дурсгалт зүйлийг ухаж авах, судлан шинжлэх явдлыг Судар Бичгийн Хүрээлэнгээс удирдаж, харгалзан хянах, зөвшөөрөл олгох, энэ дүрмийг зөрчигчид буй аваас шүүх цаазын зохих зүйлийн ёсоор яллан шийтгэж байх зэрэг шинэ цагийн соёлт олон улсын археологийн ухааны хууль ба ёс зүйн шинжтэй зарчмын заалтууд оржээ. Энэхүү 10 зүйл дүрэм нь хэмжээний хувьд бага боловч агуулгын хувьд анх удаа түүх соёлын дурсгалд ангилал хийж, дотоод гадаадын судлаачид сурвалжлах, судлах, сурталчлах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэрэг асуудлыг нэг бүрчлэн зааснаараа өдгөө ч үнэ цэнээ алдаагүй байна.

1941 оны Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын тогтоолоор “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг батлан гаргаж улс орон даяар мөрдүүлжээ. Уг дүрэмд “Монгол улсын хязгаар дотор буй хуучны бүх дурсгал болох зүйл цөм Монгол улсын өөрийн хөрөнгө мөн” хэмээн заасан байдаг. Энэхүү дүрмийн ихэнх зүйл заалт нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахад чиглэсэн байдгийг дурдууштай. Тус дүрэмд Улсын нэгдүгээр зэрэгт орох түүх, соёлын дурсгалуудыг анхлан бүртгэн жагсаалт гаргасан байна. Тус жагсаалтад нэр бүхий 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалтад, 16 дурсгалыг улсын хамгаалалтад байхаар шийдвэрлэжээ. Энэ жагсаалт бол Монгол Улс анх удаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалаа төрийн хамгаалалтад авсан түүхэн шийдвэр байсан юм.

Үүнээс хойш соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн сурталчилах талаар нэг биш тогтоол шийдвэрийг тэр үеийн засаг төрөөс гаргаж байв. Тухайлбал, 1956 оны 10-р сарын 23-нд Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос “Соёлын өвийг хамгаалах тухай” 346 дугаар тогтоолыг гаргаж байв. Уг

тогтоолд 1937 оноос хойш үндэсний соёлын өв болсон уран зохиол, түүхийн дурсгалт бичгүүдийг нийтлэх ажил зохиогдоогүйг дурдаад өвөг дээдсийнхээ үеэс хадгалж ирсэн хуучин ном судрыг харгис хуучны юм гэж буруушаан үзэж болохгүйг онцлон тэмдэглээд, “Түүх утга зохиол, ард түмний зан заншил, ёс суртахууныг судлах явдалтай холбогдсон хуучны ховор түүх, судар, ном бичгүүдийн нэрсийн жагсаалтыг гарган тодорхойлж улмаар орон нутгийг судлах кабинет, соёл гэгээрлийн бусад газруудаар дамжуулан нийтэд зарлаж цуглуулах, дурсгалын бусад газруудаар дамжуулан нийтэд зарлаж цуглуулах, түүх дурсгалын бусад материалыг үрэгдүүлэн сүйтгэх явдлыг зогсоож, тэрхүү өвийг хайрлан хамгаалах, арчлан хадгалах талаар сурталчилгаа хийх, маш ховор үлдсэн түүх, утга зохиол, бусад төрлийн зарим зохиолуудаас жил бүрийн хэвлэлийн төлөвлөгөөнд оруулж хэвлүүлж байхыг аймаг хотын нарийн бичгийн дарга нарт даалгажээ.

Мөн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1957 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаас “Түүх дурсгалын зарим уран барилгыг хайрлан хамгаалах ба сэлбэж засах тухай” 328 дугаар тогтоолыг гаргасан байна. Тогтоолд, “Тус улсын нутаг дэвсгэрт байгаа түүх дурсгалын зүйлүүд ба эртний уран барилгуудыг хайрлан хамгаалах талаар анхаарч, ойрын жилүүдэд Чойжин ламын сүм, Эрдэнэзуу, Богдын ордон, Амарбаясгалангийн дурсгалт барилгуудыг засварлах талаар арга хэмжээ авахыг Соёлын яаманд, соёлын өв болсон ном бичиг, түүх дурсгалд холбогдсон баримт материалуудыг цуглуулж, орон нутгийг судлах кабинет, музейнүүдийн үзмэрийг баяжуулах ажил зохиох, соёлын өвийг хайрлан хамгаалахын ач холбогдлыг хөдөлмөрчдийн дунд өргөнөөр сурталчлахыг аймаг, хотын намын хороодын нарийн бичгийн дарга нарт даалгажээ.

1970 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах тухай хууль” батлагдан гарчээ. Энэ хууль бол монголчуудын хэдэн зууны турш хадгалж ирсэн болон бүтээн туурвиж ирсэн түүх, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчлах зэрэг бүхий л харилцааг цогцоор нь зохицуулсан бие даасан анхны хууль байв. “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдан гарснаар урьд өмнө ард иргэдийн дунд үнэ цэнэ, ач холбогдол нь төдийлөн танигдаагүй байсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх ойлголтыг өөрчилж хүн бүрийг эдгээр дурсгалд хүндэтгэлтэй хандах, хадгалж хамгаалах үйл ажиллагаанд гар бие оролцох зэргээр үүрэг хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Түүнчлэн 1971 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 421 дүгээр тогтоолыг баталсан нь тус хуулийн хэрэгжүүлэлтэд ихээхэн түлхэц болсон байна.

1992 онд Монгол Улсын Их хурлаас баталсан шинэ Үндсэн хуульд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасан билээ.

Энэ үзэл баримтлалд нийцүүлэн 1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргаж улс орон даяар мөрдүүлж эхэлсэн байна. Энэ хууль нь зах зээлийн харилцаанд шилжиж байсан манай улсын хувьд түүх, соёлын дурсгалын талаарх харилцааг зохицуулах гол хууль болоод зогсохгүй түүнээс хойш батлагдан гарсан олон хуулийн түүх, соёлын дурсгалтай холбоотой заалтыг нөхөхөд чухал эрхзүйн баримт болж байжээ. 1994 оны “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-д хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийсний эцэст 2001 онд утга соёлын өвтэй холбоотой харилцааг

зохицуулсан заалтуудыг нэмж “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болгон батлан монголчуудын соёлын өвийг анх удаа цогц байдлаар нь хамгаалах хуулийн орчин бий болгосон байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2014 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан байна. Тус хуулийг 2014 оны 7 дугаар сараас эхлэн мөрдөж байгаа бөгөөд 13 бүлэг 61 зүйлтэйгээс 3 дугаар бүлэг Соёлын өвийн талаарх Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, 4 дүгээр бүлэг Соёлын өвийн бүртгэл, 8 дугаар бүлэг Дурсгалт газрыг хамгаалах, 11 дүгээр бүлэг Мерчандайзийн гэрээ зэрэг бүлгүүд шинээр орсон байна .


Үүний зэрэгцээ эдүгээ Монгол Улстүүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт, судалгаа, ашиглалттай холбогдолтой харилцааг “Соёлын өвийг хамгаалах тухай” болон “Соёлын тухай”, “Газрын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Эрүүгийн тухай” зэрэг хуулиудад тулгуурлан хэрэгжүүлэн зохицуулаж байна.

Өдгөө Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор Улсын хамгаалалтад байх дурсгалын жагсаалтад 182 дурсгал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх дурсгалын жагсаалтад 607 дурсгалыг тус тус хамруулан батлаад байна.



# ХОЁР.

ХАДНЫ ЗУРАГ



## ХАДНЫ ЗУРГИЙН ТАНИЛЦУУЛГА

Хадны зураг нь хүн төрөлхтний бүтээн бий болгосон соёлын түүхийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дэлхийд өргөн тархсан соёлын үзэгдэл юм. Ухаант хүн үүссэн цагаасаа эхлэн байгалиас хамааралтай байж амьдрахын төлөөх тэмцэлд байгалийн эрхшээлийн өмнө хүчин мөхөсдөхдөө байгаль дэлхийгээ аргадан дом шившлэгийн зүйл зохион хэрэглэж эхэлснээр үүссэн оюун сэтгэлгээний анхны бүтээлүүдийн нэг нь хад чулуун дээр зурсан зураг дүрслэл билээ. Үүний нотолгоо бол манай гаригийн өнцөг булан бүрт буй олон мянган жилийн өмнөөс эхлэн хүн төрөлхтөний өвөг дээдсийн үлдээсэн хадны зураг дүрслэлүүд юм. Одоогийн байдлаар манай дэлхийн 120 орчим орны нутаг дэвсгэрээс хадны зургийн дурсгал олноор байгаа ажээ. Энэ нь хүний хөгжлийн эхэн үеийн хүмүүсийн амьдрал ахуй болон шүтлэг бишрэл нийтлэг төстэй байсантай холбоотойгоор хадны зураг газар бүрт зэрэг шахам үүсэж хөгжснийг илтгэн харуулж байна.

Соёл гэдэг нь адилхан материаллаг шинжтэй хэдий ч түүнийг бүтээсэн хүнээсээ хамаараад өөр өөрийн онцлогтой байдаг тул тухайн газар оронд амьдарч байсан түүхэн үе, үеийн хүмүүсийн ертөнцийн юмс, үзэгдлийг хэр зэрэг танин мэдэж байсныг, хүний мэдлэгийн цар хэмжээ, мэдлэгээ хэр зэрэг ашиглаж чадаж байсныг тэдгээрийн бүтээн туурвиж үлдээсэн урлагийн бүтээл болох хадны зургууд илтгэн харуулдаг. Хадны зураг нь эртний хүн судлал, амьтан судлал зэрэг янз бүрийн шинжлэх ухааны





*Ховд аймгийн Манхан сум, Хойт Цэнхэрийн агуйн  
хадны зураг*

салбаруудад үнэтэй мэдээллийн эх сурвалж болдог. Тэрээр тухайн соёлт эртний нийгэм оршин тогтнож байсныг харуулж байгаа бөгөөд зурсан зураг, дүрслэлийн он цаг нь тухайн үеийн байгаль дэлхийн байдал, эртний хүмүүсийн амьдралын талаар олж мэдэх боломжийг олгодог.

Хамгийн анхны хадны зургийг агуйн хананд зурсан зосон зургууд гэж үздэг. Эхэндээ чулуун зэвсгийн үед баруун Европт голчлон Франц, Испанид амьдарч байсан хүмүүс хадны урлагийг анх бүтээсэн

хэмээн үзэж байсан боловч сүүлийн жилүүдэд энэ дүгнэлтийг эргэн харах боломжийг олгосон нээлтүүд хийгдсэн. Тухайлбал, Индонез, Хорватад шинээр олдсон хадны зургууд эртний хүний уран сэтгэмж, авъяас чадварыг илэрхийлнэ. Сүүлийн жилүүдэд агуйн хадны зургийн урлагийн тархалт Индонез, Австрали, Өмнөд Африк, Англи, Румын зэрэг орнуудыг хамарч өргөжиж байна.


Монгол орны хувьд Хойд Цэнхэрийн агуй, Ишгэн толгой, Чандмань хар үзүүр, Хад үзүүр, Рашаан хад зэрэг газраас олдсон хадны зургийг судалсан дотоод, гадаадын эрдэмтэд дэлхийд алдартай Франц, Испани, Португали, Итали зэрэг Баруун Европын төдийгүй дэлхий дахины хадны зураг анх үүсч хөгжсөн орнуудтай нэгэн цагт буюу дээд палеолитын үед Монгол оронд хадны зураг үүсчээ хэмээгээд “Монгол орон бол хүн төрөлхтөний урлаг үүсч хөгжсөн дэлхийн нэгэн голомт юм” гэсэн дүгнэлтэд хүрсэн билээ.

Эртний хүмүүсийн оюун санааны өвөрмөц дурсгал болох хадны зургийн дурсгалаар баялаг газрын нэг нь Монгол орон билээ.


Монгол орны байгаль, газарзүйн орчин нөхцлөөс шалтгаалан бий болсон эрхлэх аж ахуй, түүнд зохицон төлөвшсөн сэтгэлгээний соёл нь хадны зурагт нөлөөлсөн нь хадны зургийн дүр, дүрслэлүүдээс тодорхой харагддаг. Иймээс Монгол орны хадны зургийн агууламж, хэв загвар, зохиомж нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маяг, нийгмийн зохион байгуулалт болон тэдний амьдарч байсан байгалийн өвөрмөц нөхцөлөөс үүдэлтэй.

Монгол оронд хадны зургийн дурсгалыг илрүүлэн судлах болсоор багагүй хугацаа өнгөрчээ. Монгол оронд явуулсан археологийн судалгааны үр дүнд тус орны 500 гаруй газраас хадны зургийн дурсгал олддоод байгаа ч жил бүрийн хайгуулын явцад шинээр илрэн олдсоор байна. Монгол орны бараг бүх аймгийн нутгаас хадны зургийн дурсгал олддог.





*Хадны зургийн дурсгалт газрын тархалт*





## ХАДНЫ ЗУРГИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН БАЙРШИЛ

Хадны зураг судлалын хувьд хүрээлэн буй байгалийн болон соёлын орчныг тодорхойлж үзэх нь хадны зургийн утга санааг ойлгоход ихээхэн ач холбогдолтой билээ.

Монгол орны хадны зургийн дурсгалт газрын байрлалыг нягталж үзэхэд дараах үндсэн шинжүүд ажиглагддаг. Эдгээр нь:


- агуйн хананд;
- одоогийн малчдын өвөлжөө, хаваржааны арын хад чулуунд;
- хүн, мал, амьтан нутаглахад тохиромжтой үржил шимтэй бэлчээр бүхий газрын ойролцоох онцгой содон уул, толгойн орой, энгэр бэлийн хаданд;
- эртний голын сайр болон хадан хавцлын хоёр эргийн эгц цавчим хаданд;



*Эртний голын сайрын эрэг*



*Голын эрэг дагуух хадат эрэг*



*Сондгой уул*



*Намхан уул толгодын орой, энгэрийн хад*

- өндөр уулын болон хангайн бүсэд том жижиг гол мөрний хөндийд орших хадтай уул, толгодын орой, энгэр бэлийн хаданд;

- гол руу түрж орсон хадат хошуунд зэрэг онцгой сонин тогтоцтой газрууд -үргэлжлэн тогтсон намхан уул, толгодын хамгийн урд үзүүрийн энгэрийн хад зэрэг газруудад ихэвчлэн зураг дүрс сийлсэн байх ажээ.

Ийм нийтлэг байршлаас гадна зарим нэг онцлог байршлууд бас тохиолддог. Тухайлбал:

- гурван талаасаа эгц хад болон голоор хүрээлэгдсэн далд газар;

- ширүүн урсгалтай голд шахсан огцом эрэг;

- уул толгодын ар буюу сүүдэр талын хаданд зэрэг

онцгой сонин тогтоцтой газруудад зураг зурж сийлсэн нь бас бий.

Үүнээс харахад хадны зураг хүн удаан хугацаагаар суурьшин амьдрахад тохиромжтой газруудаас гадна тухайн нутаг орондоо онцгой сонин тогтоцтой сондгой ганц уул, голын сайрын огцом эгц хад чулуунд голчлон зурагдсан байдаг нь харагдаж байна.



Ийм ундны усанд ойр, өндөр биш уул, толгод, нар сайн тусдаг газар зэрэг нь Монголын хадны зургийн дурсгалт газрын нийтлэг шинж юм.

Монгол нутаг дахь цувран үргэлжилсэн уул, толгодод буй хадны зургуудыг ихэвчлэн уулын орой, дэл орчмоор ганц нэгээр нь дүрсэлсэн байх ба наран эзвэр энгэр талд нь нэг дор олон дүрсийг дүрсэлсэн байдаг онцлогтой байна.

Судалгаанаас үзэхэд 100-гаас дээш зохиомжтой буюу олон зурагтай дурсгалт газрууд нь ихэвчлэн хүн, мал, амьтан нутаглахад тохиромжтой үржил шимтэй бэлчээр бүхий газрын ойролцоох онцгой содон тогтоцтой ганц уул, толгой, эртний голын сайр болон хадан хавцлын хоёр талын эргийн эгц цавчим хад бүхий газруудад, 100 хүртэлх зохиомжтой газрууд нь одоогийн малчдын өвөлжөө, хаваржааны арын хад, үргэлжилсэн намхан уул, толгодын төгсгөл, үзүүрийн хэсэгт байгаа нь ихээхэн сонирхолтой юм. Энэ нь эртний хүмүүсийн шүтлэг бишрэлийн зан үйлийн талаар тодруулах боломж олгож байна.

Агуйн хана болон өвөлжөө, хаваржааны арын хадны зургууд нь эртний хүмүүс өөрсдийн амьдарч байсан газар орны дэргэдэх хад чулуунд зураг дүрс урлан ангын олз хишиг, сайн сайхан амьдралын төлөө бараг өдөр, сар тутмын гэж болох шүтлэг бишрэлийн зан үйл хийж байсныг харуулж буй бөгөөд эдгээр газрууд нь эртний хүмүүсийн ан амьтдын хөдөлгөөнийг даган нутаг сэлгэх, мал аж ахуйг дагасан нүүдэл амьдрал, цаг агаарын өөрчлөлт, тухайн үеийн нийгмийн амьдрал зэрэг хүчин зүйлээс шалтгаалан нутаг сэлгэн нүүдэллэсэнтэй холбоотой орхигдсон, харин 1-10 орчим зохиомж зурагтай газрууд нь нүүдэллэх явцад богино хугацаанд буудаллаж байсан газрууд, уулын оройгоор байх цөөн тооны зураг нь ан хийх явцад ангын олзыг урин дуудаж зурсан газрууд байсан

хэмээн үзэж болно.

Олон тооны хадны зураг бүхий онцгой сонин тогтоцтой сондгой ганц уул, толгой, голын эргийн эгц цавчим хад цохио зэрэг газруудыг урт хугацааны турш түүхийн өөр өөр үед үе уламжлан овог аймгаараа нийлэн тахиж ирсэн шүтлэгийн ариун дагшин газар байжээ.

Ийнхүү эртний хүмүүс ан агнуур, нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдрахад нэн тохиромжтой, нөмөр нөөлөг сайтай, ундны усанд ойрхон, өөрсдийн амьдарч байсан нутаг орныхоо ойр орчмын хад чулуутай газруудад хадны зургийн дурсгалыг ихэвчлэн үлдээсэн байдаг байна.

## ХАДНЫ ЗУРГИЙН АНГИЛАЛ

Монгол хадны зургийг ерөнхийд нь зосон зураг, сийлмэл зураг хэмээн 2 ангилан үзэж болно. Эдгээрээс манай орны нутагт хамгийн их тархсан нь хадыг хонхойлон цохиж сийлсэн зургууд юм.



*Зосон зураг*



*Сийлмэл зураг*

### **1. Зосон зураг.**

Зос бэхээр зурсан зурагт байгалийн тогтоцоороо байгаа хад чулууны гадаргуу дээр болон агуйн хананд хүн, мал, амьтан, тэмдэг зэргийг тусгай найрлага бүхий зос\*, бэх, шороон будаг

\* Улаан өнгийн байгалийн шороон будаг

ашиглан зурсан зургуудыг оруулан үзэж болно. Зосон зураг нь зохиомж, зурсан арга барилын ялгаанаас хамаарч бүтээгдсэн он цагийн хувьд харилцан адилгүй байдаг ба энэ нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэлийн талаарх мэдээллийг агуулдагаараа онцлогтой юм. Монгол орны зосон зургийг дотор нь үндсэн гурван бүлэгт хуваан үзэж болно.

- а. Амьтад, элдэв төрлийн дүрс тэмдэг дүрсэлсэн зосон зураг;
- б. Сөөлжир чагтан тэмдэг бүхий зосон зураг;
- в. Дөрвөлжин болон дугуй хүрээнд олон тооны цэг, түүний хажууд шувуу, хүн, амьтад, дүрсэлсэн зосон зураг.



б. хэлбэр



в. хэлбэр

## **2. Сийлмэл зураг.**

Хадны сийлмэл зурагт хаданд буюу булшны хашлага хавтан чулуунд ямарваа нэгэн тусгай багажийн (чулуу, төмөрлөг) тусламжтайгаар хүн, мал, амьтан, тамга тэмдгийн дүрсийг цоолборлон сийлж зурсан зургууд багтана. Монгол орны нутаг дэвсгэрээс илэрч олдсон сийлмэл зургууд нь ихэвчлэн хүрэл, төмрийн түрүү үед холбогддог. Бодит байдлаар ерөнхийлөн дүрсэлсэн хүн, ан амьтад, тэрэг болон бусад дүрслэлийг хүрлийн үед холбогдуулан үзэж болох бөгөөд харин амьтныг гоёмсог байдлаар болон загварчлан урласан нь хүрлийн сүүл төмөр зэвсгийн түрүү үед холбогдоно.



Мөн түүнчлэн хүннү, түрэг, монголын үед холбогдох хадны зураг харьцангуй цөөн тоотой тохиолдоно.

Хадны зураг нь гадаад хэлбэрээрээ дүрслэлийн хэв маяг, арга барилыг илэрхийлдэг бол сэдэв, зохиомжоороо зурах болсон шалтгаан, утга санааг өгүүлдэг. Иймээс Монгол нутаг дахь хадны зургийн судалгаанд тулгуурлан хадны зургийг дүрслэлийн арга барил, хэв маяг талаас нь “гадаад хэлбэр”-ийн, сэдэв зохиомж, уран сэтгэмж талаас нь “сэдэв зохиомж”-ийн хэмээн хоёр ерөнхий том бүлэгт хуваан ангилж үзэж болно.

Но	Гадаад хэлбэр	Сэдэв зохиомж	Дүрсэлсэн арга
1	Энгийн дүрслэл	-ан амьтдын -аж ахуйн	-хонхойлон сийлсэн -хөвөөлөн цохисон -нарийн зураасан
2	Загварчилсан	-ан амьтан, буга	-хонхойлон сийлсэн -хөвөөлөн цохисон -нарийн зураасан
3	Бэлгэдлийн	-ан амьтад -тамга тэмдэг -шүтлэг бишрэл, оршуулга -тодорхойгүй	-хонхойлон сийлсэн -хөвөөлөн цохисон

1. Гадаад хэлбэрийн ангилал. Хадны зураг нь түүхийн маш урт хугацааны туршид бүтээгдсэн дурсгал тул олон янзын хэв маяг, арга барилаар дүрсэлснийг харж болно. Үүнийг хэн ч харсан тодорхой байх учир гадаад хэлбэрийн хэмээн тодорхойлж байгаа юм. Хадны зургийг дүрсэлсэн хэв маягийн хувьд дараах хэсгүүдэд хуваан үзэж болно.

Үүнд:

а) Энгийн дүрслэлтэй хадны зураг. Дүрсэлж буй зүйлийнхээ хэлбэр төрхийг нь бүрэн бодитой илэрхийлэхийн тулд цоолборлож



сийлсэн энгийн дүрслэл бүхий зургууд багтана. Энэ төрөлд ан амьтдын, аж ахуйн сэдэвтэй болон тамга тэмдгийг бодитойгоор дүрсэлсэн хадны зургуудыг оруулан үзэж болно.



*а. энгийн*



*б. загварчилсан*

б) Загварчилсан дүрслэлтэй хадны зураг. Аливаа амьтан, бодис бүр өөрийн гэсэн онцлог шинжтэй байдаг. Энэхүү онцлог шинжийг тусган авч, уран сайхны сэтгэлгээ оруулан боловсруулж зурсныг археологийн ном зохиолд амьтны загварт урлагийн маягаар цолборлон сийлсэн хадны зураг хэмээн нэрлэдэг.



*в. бэлгэдлийн*

в) Бэлгэдлийн дүрслэлтэй хадны зураг. Энэ нь эд зүйлс, амьтдын хэлбэр дүрсийг домог зүйн сэдэлтэйгээр бэлгэшсэн гаргаж буй санаа, сэдвийн онцлогийг хийсвэржүүлж бэлгэдсэн зургууд юм. Үүнд шүтлэг бишрэлтэй холбоотой зургууд, тамга тэмдэг, геометрийн дүрслэл, үл ойлгогдох бэлгэдлийн шинжтэй дүрслэл бүхий зургууд болон зосон зургийг багтаан үзэж байна.

### **ХАДНЫ ЗУРГИЙН ДҮРСЛЭЛИЙН АРГА БАРИЛ, ХЭВ МАЯГ**




Хүн төрөлхтөний хэрэглэж буй олон хэлнүүдийн нэг, хамгийн өвөрмөц нь зураг дүрслэлийн “хэл” юм. Ямар ч хэлээр ярьдаг, бичдэг хүмүүс зураг дүрслэлийн хэлийг нэг л утгаар хүлээн авдаг. Энэ гайхамшигт “хэл”-ний эхлэл нь эртний хүмүүсийн үлдээсэн дурсгал болох хадны зургийн янз бүрийн дүрс, тэмдэглэгээтэй холбоотой.

Ямарваа нэгэн зүйлийг зурахын тулд эхлээд тэр зүйлийнхээ хэлбэр, бүтэц, хэмжээ, үзэмж ямар байхыг урьдчилан бодож сэтгэдэг байна. Ингэж “хийсвэр дүр” болгож сэтгэсэн төсөөллөө дүрслэн үзүүлж, дамжуулж байсны илрэл нь хадны зураг билээ. Эртний хүмүүс хаданд зураг дүрс сийлж дүрслэхдээ янз бүрийн арга барил, хэв маягаар урласан нь тодорхой харагддаг. Иймээс хадны зураг дахь амьтдын дүрийг тусгайлан авч үзсэнээр тэдгээрийг ямар шалтгааны улмаас дүрслэх болсон, дүрслэлийн ямар арга барил, хэв маягаар урласан болохыг тодруулах боломжтой юм.

#### ***Хадны зургийн дүрслэлийн арга барил***

Эртний хүмүүс хаданд зураг урлахдаа тодорхой тогтсон арга барилуудыг ашигласан байдаг. Энэ нь зураг зурахдаа ямарваа нэгэн дүрсийг *бух талбайгаар нь хонхойлон цохисон, эх биеийг нь хөвөөлөн цохисон, нарийн үзүүртэй багажаар сийлсэн* зэрэг

судлаачдын нэгэнт тогтоон тодорхойлсон арга барилууд юм.

		
<i>Бүх талбайгаар нь хонхойлон цохисон</i>	<i>Эх биеийг нь хөвөөлсөн</i>	Нарийн зураасаар сийлсэн

Монголын хадны зурагт амьтдыг дүрсэлсэн байдлыг ажиглахад энгийн хялбарчлан тоймлох арга зонхилох хандлагатай боловч ерөнхийдөө бодит байдлаар дүрсэлжээ. Зургийг ихэвчлэн хадны гадаргууд бүх талбайгаар нь хонхойлон цохиж цоолборлосон байх ба цөөхөн тохиолдолд эх биеийн хүрээг тойруулан хөвөөлөн цохих, нарийн зураасаар сийлэх аргыг хэрэглэсэн байна

Сийлмэл зураг нь тухайн зургийн удаан сайн хадгалагдах чанартай холбоотойгоос гадна хаданд зураг сийлж цоолборлоход гарын дор бэлэн байдаг чулуу, тусгайлан бэлдсэн төмөрлөг багаж” ашиглах нь байгалийн зосон будаг, бэхийг найруулан гаргаж авахаас илүү хялбар, авч явахад амар байснаас гадна гүйцэтгэж буй зан үйлээ тод томруунаар илэрхийлэх, тэгснээр гарах үр дагаварт илүү ач холбогдолтой хэмээн үзэж байснаас үүдэлтэй бололтой. Эртний хүмүүс хад чулууг амьтай, цаанаа эзэнтэй хэмээн үзэж байсан гэж болох тул хад чулуунд аливаа хүн, амьтан, эд зүйлсийн зургийг бүх талбайгаар нь цоолборлож сийлснээр тухайн дүрсэлж буй зүйлдээ

*“Хадны зураг урлаачид хад чулууны хатуулагт тохируулан багаж зэвсгээ тусгайлан бэлтгэдэг байсан хэмээн үзэж болох тул найруулсан шингэн зос, будаг зэргийг зөвөөрлөхөөс хялбар байсан бололтой.*

бодол санаагаа уусган шингээж, түүгээрээ дамжуулан өөрсдийн хэрэгцээ, илэрхийлж буй хүсэл зорилгоо тусгай зан үйлийн тусламжтай олж авна гэж үздэг байсантай холбоотой юм.

Харин эртний хүмүүс төмөрлөгийг ашиглаж эхэлснээр зэвсэг багаж нь сайжирч дээрх аргаас үүсэлтэйгээр нарийн үзүүртэй багажаар амьтан, хүний биеийг хөвөөлөн сийлэх болсон нь хүрлийн сүүл, төмрийн түрүү үеэс эхлэн Түрэгийн үед нэлээд дэлгэрчээ. Ингэж зурсан зургийг хадны зургийн судалгаанд нарийн зураасан зураг хэмээн нэрлэдэг. Эртний нүүдэлчид төмөрлөг зэвсэг багажийг амьдрал ахуйдаа өргөн хэрэглэх болсон, мөн энэ үеэс нүүдлийн мал аж ахуй сонгодог хэлбэрт аажмаар шилжин орж эхэлснээр тэдний оюун санааны хөгжилд ч ахиц дэвшил гарчээ.

Хүрлийн үеийн амьтны биеийг хөвөөлөн цохиж сийлэх аргаар зурсан зургийн утга санаа цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж хадны зургийн дүрслэх арга барилд нөлөөлж нарийн үзүүртэй багажийн тусламжтай зураасан зураг зурж шүтлэгийн зан үйл гүйцэтгэх болсноос гадна ямарваа нэгэн баатар эр, дайн тулааны ялалтыг алдаршуулж мөнхжүүлэн үлдээх зорилгоор зурж байжээ. Энэ нь хүний оюун санаа хөгжихийн хирээр аливаа амьтан, хүн, эд зүйлс, тэдгээрийн дүрс хоёрын хоорондын дом шившлэгийн төсөөлөл арилахын хамтаар уран сайхны дүрст төсөөлөл орлон эзэлсэнтэй холбоотой юм.

### ***Хадны зургийн дүрслэлийн хэв маяг***

Хадны зургийн дүрслэлийн хэв маягийг тодруулан судлахад амьтны дүр чухал ач холбогдолтой.

Монголын хадны зургийн дүрслэл дотор голлох байрыг ганц нэгээр нь ба хэд хэдээр нь нэг дор, янз бүрийн арга барилаар дүрслэсэн ан амьтдын дүрс эзэлнэ. Тэдгээрийг амьтдын төрөл зүйлээр нь

ангилж үзвэл янгир, буга, аргаль, адуу, тэмээ, үхэр, араатан амьтад, гахай, могой, бусад амьтад зэрэг болно.

Хадны зургийн дүрслэлийн хэв маягийг манай орны бүх аймгийн нутгаас илэрч олдсон хадны зураг бүрт түгээмэл байдаг янгирын дүрээр төлөөлүүлэн тодруулж үзье.

		
<i>Бодит</i>	<i>Гоёмсог чимэглэлийн</i>	<i>Схемчилсэн</i>

Бодит байдлаар ерөнхийлөн урласан янгирын дүрслэл ихэнхи хувийг эзлэж байгаа бөгөөд ямар нэгэн эрхтнийг нь онцлон тодотгосон болон гоёмсог байдал оруулж дүрслэсэн нь харьцангуй цөөхөн байна. Үүнийг аливаа нэгэн зүйлийн дүрслэл бүхий зургийн утга санаа нь хийж гүйцэтгэж буй тухайн зан үйлтэй нягт уялдсан байдагтай холбон үзэж болно. Учир нь ан агнуурын зан үйлийн улмаас хаданд зураг зурахад гоёмсог байдал шаардагдахгүй зөвхөн тухайн зүйлээ л тодорхой зурах нь чухал байдагтай холбоотой. Тодруулбал, янгирыг бодит байдлаар цоолборлон урласан зургууд ихэвчлэн ганц нэгээр болон сүргээрээ тайван бэлчиж яваа байдалтай зурагдсан байгаа нь тэдгээрийг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нутаг сэлгэн дайжсан болон ган зудын улмаас хорогдож цөөрсөн янгирыг уугуул нутаг орондоо эргэн өсөн үржиж улам олшрохыг бэлэгдэн зурсан бололтой. Харин эврийг нь ердийн байдлаас өөрөөр, олон янзын хэв маягаар гоёмсог болгон

дүрсэлсэн янгируудыг ганц нэгээр нь, зарим тохиолдолд хэд хэдээр нь зурсан нь газар, усны эзэд болон өвөг дээдэстээ өргөл болгон өгч буйг илэрхийлж буй ажээ. Ан агнуурын болон мал аж ахуйн сэдэвт зохиомжид дүрслэгдсэн янгир нь гоёмсог хэлбэр оруулаагүй ихэвчлэн ердийн бодит байдлаар зурагдсан байгаа нь ч өөрсдийн хоол хүнсэнд зориулагдсан гэсэн утгыг илэрхийлж байна.

### **ХАДНЫ ЗУРГИЙН СЭДЭВ ЗОХИОМЖ**

Монгол орны бараг бүх газрын хадны зурагт тухайн үеийн амьтны аймгийн хамгийн гол төлөөлөгчид, эртний овог аймгуудын өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болох мал хариулах, ан ав хийх зэрэг үзэгдлүүд тусгалаа олсон байдаг. Бараг хадны зургийн дурсгалт газар бүр нөхөн үржихүй, хүч чадлыг бэлгэдсэн эр бэлэг бүхий амьтан, хүний дүрс байна. Үр удмаа үлдээх, үржихийг бэлэгдсэн хүмүүсийн хурьцаж буй, мал амьтны нийллэгийн дүрслэл, янз бүрийн тамга тэмдэг, домгийн амьтад, шүтлэг бишрэлтэй холбоотой зураг ч бас цөөнгүй тохиолдоно. Иймээс хадны зургийг төрөл зүйлээр нь сэдэвчлэн ангилах нь эртний хүмүүсийн үлдээсэн хадны зургийн утга санаа, эрхэлж байсан аж ахуйн талаар сэргээн тодруулахад чухал ач холбогдолтой тул сэдэв зохиомжийн хувьд доорх хэлбэрээр ангилан үзлээ.


Үүнд:

1. ан амьтдын сэдэвт
2. аж ахуйн сэдэвт  
(хүний үйл ажиллагаатай холбоотой зургууд)
3. шүтлэг бишрэлийн сэдэвт
4. тамга тэмдэг
5. тодорхой бус дүрслэлүүд зэрэг болно.

Дээрх сэдэв зохиомжуудаас ан амьтан, аж ахуйн сэдэвтэй, тамга

тэмдэг, бусад үл

ойлгогдох дүрслэлүүд нь бараг бүх хадны зургийн дурсгалт газар нийтлэг, тогтвортой дүрслэгдсэн байдаг. Харин шүтлэг бишрэл, оршуулгын зан үйлийн сэдэвт зургууд нь тэр бүр тохиолддоггүй дүрслэлүүд юм. Энэнь хадны зургийн дурсгалт газруудын онцлогийг харуулж байж болох талтай. Иймээс шүтлэг бишрэлийн болон оршуулгын зан үйлтэй холбоотой зураг дүрслэлийг тусгай сэдэв болгон авч үзэв. Тамга тэмдгийн хувьд эртний хүмүүсийн оюуны



соёлын онцлогийг илэрхийлсэн археологи, түүх, угсаатны зүйн чухал ач холбогдолтой сэдэв юм.

**Ан амьтдын сэдэвт зохиомж.** Манай орны хадны зургийн дийлэнх хувь нь ан амьтны зураг юм. Иймээс эртний хүмүүсийн амьдрал, оюун санааны хөгжилд хадны зурагт дүрслэгдсэн амьтад ямар үүрэг гүйцэтгэж байсныг тодорхой харж болно. Тухайлбал, янгир хоол тэжээлийг хангагч гол эх үүсвэр нь болж байсан, адуу эртний нүүдэлчдэд чухал үүрэгтэй байсан

(уналга, ачилганд ашиглах, тэргэнд хөллөх гэх мэт), гаршуулж гэршүүлсэн амьтад хүний амьдрал ахуйд онцгой ач холбогдолтой болж ирсэн, буга, хандгай, чоно, баавгай зэрэг амьтад тухайн овог аймгийн тотем бэлэгдэл байсны зэрэгцээ бөө нарын онгод тэнгэрийн унаа хэмээн үздэг байсан, араатан амьтдын хувьд хүний амьдралд ямар нэгэн байдлаар учруулдаг хор хохирлоос хамгаалах гэсэн санааг илэрхийлж байжээ гэж үздэг.

Буга нь Төв Азийн нутагт өргөн тархсан арьс, мах, эвэр зэрэг ихээхэн бүтээгдэхүүн өгдөг чухал ан төдийгүй, байгалиас заяасан үнэхээр гоо үзэмжтэй, хүнд ямар ч хор хөнөөлгүй амьтан учраас түүнийг



эрт цагаас эрхэмлэн хүндэтгэж, шүтэж бишрэн тахиж хад чулуунаа олноор нь урлан сийлж иржээ.

**Аж ахуйн сэдэвт зохиомж** нь хүний үйл ажиллагааны бүх талыг харуулсан зургууд юм. Үүнд хүн, хүмүүс хоорондын харилцаа, тэмцэл, эрхэлж байсан аж ахуй (ан агнуур, мал аж ахуй)-тай холбоотой зохиомжууд, хүний гараар бүтсэн багаж хэрэгсэл, эд зүйлсийг хамруулан үзэж болно. Ийм дүрслэлүүд нь эртний хүний оюун санааны хөгжлийн бодит түүхийг илтгэн харуулдаг учир хадны зургийн судалгааны нэгэн чухал сэдэв билээ. Хүн өөрөө нийгмийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлийн нэг тул хүний дүрслэл бүхий хадны зургийн дурсгал нь хүн төрөлхтөний олон талт үйл амьдрал хийгээд түүхэн хөгжлийн үйл явцыг шууд тусган харуулдаг баримт юм.

**Ан агнуур.** Энэ нь ан амьтан, агнах багаж хэрэгсэл, анчин хүнийг хэрэглэгдэхүүнээ болгосон ан агнуурын сэдэвт зураг юм. Ан агнуурын утга санааг харуулсан зурагт ганцаараа болон олуулаа нийлж явганаар эсвэл морь унаж нум сумаар зэвсэглэн янгир, гөрөөс, үхэр, араатан амьтдыг агнаж буйг дүрсэлжээ. Энэ нь тухайн үеийн хүмүүсийн эрхэлдэг амь зуулгын нэг хэсэг нь ан агнуур байсныг харуулж буй хэрэг юм.

Түүнчлэн одоогийн “залуу анчид үнэг, хэрэм, үен, солонго, чандага зэрэг жижиг үслэг амьтдыг агнаад эхлэн алсан амьтныхаа арьсыг бөөгийн өмсгөлд өглөг бэлэг болгон өргөдөг явдал нь ирээдүйд улам их олзтой сайн анчин болгож өгөхийг асар тэнгэр нараас гуйж хүссэний илэрхийлэл болдог” нь ан амьтад болон ан агнуурын сэдэвт зургийн утга санааг тайлан унших нэгэн сэжиг болж болохоор байна. Ан агнуурын гол шинж төрхийг нум сумтай анчдаар харуулсан байх нь Монголын хадны зургийн онцлог шинж юм. Мөн цана хөлөглөн ан хийж буй өвөрмөц дүрслэлтэй зураг бас бий.



*Нум сумаар зэвсэглэсэн анчид*



*Морьтой анчин*




*Цанатай анчин*



**Мал аж ахуй.** Одоогийн Монгол орны нутаг нь эрт үеэс мал аж ахуй эрхлэн ирсэн нүүдэлчдийн өлгий нутаг бөгөөд “барагцаалбал одоогоос 8-3 мянган жилийн хооронд таван хошуу малын өвгийг гэршүүлсэн байна”.

Ийнхүү Монгол оронд неолитын үед малыг гэршүүлэн улмаар хүрлийн үеэс буюу одоогоос 6-5 мянган жилийн тэртээгээс Төв Азийн нүүдэлчид мал аж ахуйг өөрсдийн амьдрал, ахуйн гол хэрэгсэл болгон хувиргаж “эртний хүн ан гөрөөгөөр амьдрах хэлбэрээс мал маллагаанд шилжсэн явдлыг неолитын үеийн

хувьсгал гэж нэрлэдэг” ажээ. Сүүлийн үеийн судалгааны үр дүнд Төв Ази, тэр тусмаа Монгол нутаг нь зарим төрлийн малыг бие даан гаршуулсан анхны голомт нутгуудын нэг байх магадлал нэмэгдсээр байна. Тухайлбал, Д.Цэвээндорж Увс



*Можоогийн хадны зураг.*

аймгийн Сагил сумын Можоогийн хадны үхэр болон үхэр хөтөлсөн хүний дүрслэлийг мезолитын үед холбогдуулан үзэж “Монгол оронд 15000-8000 жилийн тэртээ мал аж ахуй үүсэн бий болжээ. Монгол орон бол мал аж ахуй бие дааж үүссэн дэлхийн цөөн тооны голомтуудын нэг” хэмээх дүгнэлтэнд хүрчээ.

Судлаачдын дээрх дүгнэлтүүд нь зэрлэг амьтдыг гэрийн нөхцөлд дасгаж эхэлсэн анхны голомтууд мезолитын үед бий болж неолитын үеэс үйлдвэрлэх аж ахуйн эхлэл тавигдан хөгжиж ирснийг харуулж байна. Ийнхүү мезолитын үед хүн адгуусан амьтныг өөртөө дасгаж эхэлсэн бөгөөд одоогоос 8 000 жилийн тэртээгээс Төв Азид амьтныг идэвхтэй гэршүүлж эхэлжээ. Энэ нь цаг агаар хуурайшин эх газрын эрс тэс уур амьсгалтай болсноор том амьтад үгүй болж ангын нөөц хомсдон эртний хүмүүс амьтдын хөдөлгөөнийг даган унд устай, нөмөр нөөлөг газрыг даган нүүдэллэн амьдрах болсонтой холбоотой бололтой. Ийнхүү эртний монгол овог аймгууд Евразийн тал хээрийн бүсийн овог аймгуудын нэгэн адилаар нүүдлийн мал аж ахуйд шилжсэн агаад энэ нь тэдний аж ахуй, соёлыг тодорхойлогч үндсэн аж ахуй болж олон зуун жилийн туршид хөгжиж иржээ.



*Сүхбаатар аймгийн Онгон сум,  
Бударын чулууны хадны зураг*



*Говь-Алтай аймгийн Баян-Уул сум,  
Ловонгийн нурууны хадны зураг*

Хадны зураг дахь мал аж ахуйн сэдэвт дүрслэлийг хэд хэдэн үечлэлээр авч үзэж болох юм. Тухайлбал, адуу, ямаа зэргийг хашин хоргоож буй дүрслэл нь амьтанг гаршуулж эхэлж байсан үед, хөтөлж яваа нь мал аж ахуй үүсэн бүрэлдэж эхэлж байсан цаг үед холбогдох бололтой. Учир нь амьтныг гаршуулан гэршүүлэх үйл явц урт удаан хугацааны туршид алгуур үргэлжлэн явагдсан нь тодорхой бөгөөд энэ үед малыг гэрийн болгох явц тэр бүр амжилтанд хүрч байгаагүй тул тухайн амьтдыг өөртөө ойр байлган дасгах, улмаар эдэлж ашиглах нь маш их хэрэгцээтэй байсан нь ойлгомжтой. Иймээс энэ санаагаа амжилттай болгон хэрэгжүүлэхийн тулд амьтанг хашин хоргоох, урхи тороор барьж буйгаар илэрхийлж байжээ гэж үзэж болох юм. Морь мал унасан эсвэл амьтан хөтөлж яваагаас өөр адуу, үхэр, тэмээ дүрсэлсэн зурагт хүний дүрслэл байхгүй байгаа нь малыг дүрсэлсэн үү эсвэл гаршуулж гэршүүлээгүй зэрлэгээр байгаа юмуу гэдэг нь тодорхой биш байна. Иймээс амьтанг хөтөлсөн, тэргэнд хөллөсөн зэргээр хүнтэй холбогдсон тодорхой дүрслэлүүдийг гэрийн болгосон мал хэмээн үзэж болно.

**Тэрэгний дүрслэл.** Тэрэгний зураг нь хүрэл зэвсгийн үеийн хадны зургийн дүрслэлд онцгой байр суурь эзэлдэг. Тэрэгний дүрслэл бүхий хадны зураг Монголоос Кавказын уулс, хойшоо

Скандинавын хойг, урагшаа Ойрхи Дорнод хүртэлх бүс нутагт тааралддаг Монголын хадны зураг дахь тэрэгний дүрслэлийн ихэнх нь хэгээс бүхий хоёр дугуйт хөнгөн тэрэг юм. Хэгээс бүхий тэнхлэг голтойгоо хамт эргэх бус дангаар эргэх мөөрт дугуй сэдсэн явдал нь хүрэл зэвсэгтний зохион бүтээсэн гайхамшигт ололт, дэвшил хэмээн үзэж болно.

Хөнгөн тэргийг дангаар, моринд хөллөсөн байдлаар болон хүн жолоодож буй байдлаар тус тус сийлсэн байдаг.

Тэргийг ямарваа амьтанд хөллөөгүй байгаа байдалтай дангаар харуулах явдал түгээмэл байдаг нь тэрэгний эд ангийн бүтэц зохион байгуулалтыг тандах бололцоог олгодог юм.



*Тэрэгний дүрслэл*



*Тэрэгний дүрслэл*

Морин тэрэгний дүрслэл жолоодож буй хүнтэйгээ цогцлоож төгс дүрслэл болно. Хүнийг дүрслэхдээ урдаас харсан байдлаар дүрсэлдэг онцлогтой.

Хад чулуунаа тэрэг дүрслэх уламжлал хүрлийн үеэс хойш Хүннүгийн үед ч хадгалагдан байсан бөгөөд энэ үед голчлон сүйх тэргийг дүрслэх явдал нийтлэг байв.


***Шүтлэг бишрэлийн сэдэвт зохиомж.*** Монголын хадны зураг дахь хүний нүүрний багийг дүрсэлсэн зураг шүтлэг бишрэлийн сэдэвтэй өвөрмөц дүрслэлийн нэгэнд зүй ёсоор тооцогдоно.



Хад чулуунаа хүний нүүр дүрслэх явдал нь эртний хүмүүсийн үзсэн бишрэл, ертөнцийг үзэх үзэл, тодорхой төрлийн зан үйлтэй



*Ховд аймгийн Үөнч сум,  
Ямаан усны хавцал*



*Ямаан усны тэрэгний гар зураг*

салшгүй холбоотой. Юуны түрүүнд эдгээр нь бөөгийн шашинтай нягт уялдаатай нь тодорхой юм.

Монголын хадны зураг дахь хүний нүүрний дүрслэлүүд нь зарим талаараа Төв Азийн бусад бүс нутгийн хадны зургаас тод ялгарч байгаа ч Хятадын хойд бүс нутгийн хадны зураг дахь хүний нүүрний дүрслэлтэй ихэд төстэй байдал ажиглагдаж байна.

Тухайлбал, хүний амыг хэрээсээр тэмдэглэсэн нь их өвөрмөц



*Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум,  
Жаргалантын адгийн ширээ*



*Өмнөговь аймгийн Ханбогд сум,  
Зүүн хацавч*

бөгөөд Хятадын Иншань (Муна) уулын хадны зураг дахь нүүрийг нь тэр чигээр нь хэрээсээр тэмдэглэсэн багтай утгын хувьд ижилсэж

байна. Хүний нүүрний дүрслэлийн утга санааны хувьд хятадын судлаачид энэ нь балар эртний хүний сахиусан буюу сэтгэшгүй ад чөтгөрийг дүрсэлсэн төдий биш, харин тэнгэрийн сахиусан наран саран ба од эрхэс зэрэг шүтээний дүр, тэдний хүншүүлсэн хэлбэрийн тусгал хэмээн тайлбарласан байдаг ажээ [Эрдэнэбат, 2008: 33].

Хүний нүүрний дүрслэлүүд ихэвчлэн Монголын говийн бүсээс олддог бөгөөд

бусад газрын зурагтай харьцуулахад олон байгаа нь чулуун зэвсгийн сүүл энеолит, хүрлийн эхэн үед энэ бүс нутаг өөрийн гэсэн өвөрмөц онцлог соёлтой байсныг харуулж байна гэж үзэж болно.

**Тамга тэмдэг.** Монголын хадны зураг дүрсийн дотор тамганы дүрс багагүй хувийг эзлэнэ. Тамгыг хаднаа дүрсэлсэн байрлал зүйг ажиглахад овог аймгаараа тахиж шүтдэг байсан бололтой газруудад (түүхийн өөр өөр үед хамаарах олон зурагтай сондгой ганц уул, толгой, эсвэл голын эгц цавчим эрэг гэх мэт онцгой содон газруудад) ихэвчлэн нэг дор тусад нь сийлсэн байгаа нь тухайн тахилгад оролцсон овог аймгууд өөрсдийн тамгадыг нэг дор сийлдэг байсан байх магадлалтайг харуулж байна.

Ингэж нэг дор бөөнөөр нь сийлсэн тамганууд нь Түрэгийн үеийн тахилын байгууламжийн зэл чулуудтай\*\*\* адил утга санааг агуулж буй бололтой. Энэ нь эртний нүүдэлчид хүрэл, төмрийн түрүү үед хаднаа зураг зуран тахил тайлгын ёслол хийдэг байсан нь



Өмнөговь аймгийн Ханбогд сум,  
Жавхлант хайрхан

\*\*\* Зэл чулууны утга санааны талаарх судлаачдын тахилгын ёслолд хүндэтгэн ирж оролцсон овог аймгуудын төлөөлөл гэсэн тайлбарыг [Руденко, 1960: 49-51; Шинэхүү, 1980: 17; Баяр, 1997: 37; Батсүх, 2004: 165] дэмжин баримтлав.






Булгаан аймгийн Бүрээхангай сум,  
Өвгөнт уул



Говь-Алтай аймгийн Халиун сум,  
Цагаан гол



*Хад чулуунаа дүрсэлсэн тамга тэмдгийн хувилбарууд*

яваандаа буган хөшөө, хүн чулуун хөшөө хийж адуу малаар тахил өргөх болсноор энэ заншил хэлбэрийн хувьд хувьсан өөрчлөгдөж ирснийг харуулж буй баримт гэж үзэж байна. Харин тодорхой нэгэн зохиомж, эсвэл амьтдын дунд дүрсэлсэн тамга нь тухайн зургийг зурсан хүний овгийн тамга бололтой.

## ОН ЦАГИЙН ХАМААРАЛ

Монголын хадны зургийг 100 гаруй жилийн өмнөөс судалж байгаа ч Монголын археологийн судалгааны тулгамдсан асуудлуудын нэг нь уг дурсгалын он цагийг тодорхой тогтоох явдал хэвээр байгаа билээ.

Ихэнх судлаачдын үзэж байгаагаар хадны зураг нь он цагийг нарийвчлан тогтооход хамгийн хэцүү дурсгал бөгөөд адил төстэй маш олон зүйлийг нэг арга барилаар дүрслэсэн байдаг нь хадны зургийг он цагийн хувьд ангилах явдлыг мэдэгдэхүйц хүндрүүлж байдаг. Гэвч он цаг нь тодорхой болсон зураг дүрслэлүүд, булшнаас илэрч олдсон биет дурсгалуудтай харьцуулан он цагийг харьцангуйгаар тогтоох боломжтой юм.

Монголын хадны зургийн дурсгалууд нь чулуун зэвсгийн үеэс дундад зууны үед холбогдоно.


### ***Чулуун зэвсгийн үе (80000-аас 5000 жилийн өмнө)***

Монгол нутгаас илэрч олдсон чулуун зэвсгийн үед холбогдох хадны зургуудын дийлэнх нь Алтайн нуруунд байна. Үүнд, Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуй, Ишгэн толгой, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Цагаан салаа, Бага Ойгор, Цэнгэл сумын Арал толгой, Шивээт хайрхан зэрэг газруудыг дурдаж болно.

Монгол орны Хойд Цэнхэрийн агуй, Рашаан хад зэрэг газраас олдсон хадны зургийг судалсан дотоод, гадаадын эрдэмтэд дэлхийд алдартай Франц, Испани, Португали, Итали зэрэг Баруун Европын төдийгүй дэлхий дахины хадны зураг анх үүсч хөгжсөн орнуудтай нэгэн цагт буюу дээд палеолитын үед Монгол оронд хадны зураг үүсчээ хэмээгээд “Монгол орон бол хүн төрөлхтөний урлаг үүсч хөгжсөн дэлхийн нэгэн голомт юм” гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм.



*Баян-Өлгий аймгийн Улаанхус сум,  
Бага Ойгөр*



*Ховд аймгийн Манхан сум,  
Ишгэн толгой*



*Ховд аймгийн Манхан сум, Хойд  
Цэнхэрийн агуй*



*Хэнтий аймгийн Батширээт сум,  
Рашаан хад*

Монголын хадны зосон зургийн ихэнхийг эртний хүмүүсийн гал тахих зан үйлтэй холбоотой тухайн үеийн хүмүүсийн оюун санааны хөгжлийг тод харуулсан дурсгал эзэлдэг. Эртний хүмүүс агуйн хана, байгалийн хад чулуунаа сөөлжир чагтан тэмдэг зурж галыг тахиж шүтэх ёслол үйлддэг байсан бөгөөд энэ нь анх дээд палеолитын үед үүсэж улмаар мезолит, неолитын үеийг дамжин хүрлийн үеийг хүртэл үргэлжилсэн хэмээн үзэж болохоор байна. Харин хүрлийн үеэс амьжиргааны хэлбэрийн өөрчлөлттэй (ан агнуур, түүвэрлэх аж ахуйгаас мал аж ахуйд шилжсэн) уялдан хүний оюун санаа хөгжихийн хирээр шүтлэг бишрэлд ч өөрчлөлт орж галыг тахин шүтэх зан үйл хувьсан өөрчлөгдсөөр одоог хүртэл уламжилж иржээ.

### ***Хүрэл, түрүү төмрийн үе (4500-аас 2500 жилийн өмнө)***

Монголын хадны сийлмэл зураг дахь олон тооны амьтан, хүний зураг нь он цагийн хамаарлын хувьд янз бүрийн үед холбогдох нь тэднийг дүрсэлсэн арга барил зэргээс тод харагдаж байна. Хадны сийлмэл зураг нь чулуун зэвсгийн үеэс дундад зууны үеийг хүртэл зурагдаж байсны дотор хүрэл төмрийн түрүү үед холбогдох дурсгал ихэнх хувийг нь эзэлж байна.

Монгол орны хүрлийн үеийн хадны зургийн хамгийн түгээмэл голлох дүрслэл бол төрөл бүрийн амьтад юм. Ан амьтдын дүрслэлийг олон янзын арга барилаар урласан байгаа нь он цагийн ялгааг тодруулах үзүүлэлт болох юм. Бодит байдлаар дүрсэлсэн сийлмэл зургууд хүрэл зэвсгийн эхэн үеэс эхлэн зурагдаж байсан гэж үзэж болох бөгөөд харин загварчилсан, гоёл чимэглэлийн дүрслэлүүд хүрлийн сүүл, төмрийн түрүү үед гарч ирсэн хэмээн үзэж болно.



*Хүрлийн үеийн хадны зургаас*

Мөн голлох дүрслэлийн нэг нь хүний дүрслэл болно. Нум сумаар зэвсэглэсэн хийгээд ан хийж буй, мал аж ахуй эрхэлж буй, хоорондоо тэмцэлдэж буй хүмүүсийг бодит байдлаар ерөнхийлөн дүрсэлсэн болон нөхөн үржихүйг бэлэгдсэн зургууд, мөн мөөгөн хэлбэрийн малгай өмссөн хүний дүрслэл зэрэг нь НТӨ II мянган жилээс I мянган жилийн эхний хагаст холбогдох ажээ.

Ийнхүү амьтдыг чулуун зэвсгийн үеэс эхлэн хүрэл, төмрийн түрүү үе, Хүннү, Түрэгийн үе хүртэл маш олон хэлбэр маягтайгаар дүрсэлж ирсэн тул тодорхой нэгэн дүрсний он цагийг тогтооход

бэрхшээлтэй байдаг. Ер нь хадны зураг дахь бодит болон загварчилсан дүрслэл нь үүссэн үеэсээ хойш дараа дараагийн үеүдэд уламжлагдан дүрслэгдсээр ирснийг тэмдэглэх хэрэгтэй.



*Түрүү төмөр зэвсгийн үеийн хадны зургаас*



*Дорноговь аймгийн Сайхандулаан сум,  
Монголын хад*



*Архангай аймгийн Тариат сум,  
Чулуутын гол*


### **Хүннүгийн үе (2200-аас 2000 жилийн өмнө)**

Нүүдэлчдийн анхны төрт улсыг байгуулсан хүннү нарын түүхэнд холбогдох хадны зургийн дурсгал манай орны нутагт цөөн тоотой тархсан байдаг.

Хүннүгийн үеийн хадны зургийн онцлог нь дүрслэлийн бодит чанар, хөдөлгөөнт шинж бөгөөд амьтдын давхих хөдөлгөөнийг дүрслэхдээ урд хөлийн нэгийг нугалсан байдалтай, нөгөөг урагш тэнийлгэсэнээр үзүүлсэн байдаг явдал юм.

Мөн амьтдыг урт нарийн биетэй, шавхнуун буюу тасрах шахам гурайтсан гэдэстэй зурдаг нь Монгол, ОХУ-ын Уулын Алтай, Тувагийн хүннүгийн үеийн хадны зургийн нийтлэг шинж хэмээн

үзэж болно. Үүний нэг жишээ бол Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Цагаан элэгийн хадны зураг юм.



Баянхонгор аймгийн Шинэжинст сум,  
Сонгинотын хадны зургийн хэсгээс



Хэнтий аймгийн Баян-Адарга сум, Дуурлиг нарсны хүннү булшнаас олдсон морины дүрст алт шармал хүрэл чимэглэл



Үхрийн дүрстэй хүрэл ялтас. БНХАУ.  
Сичагоугийн хүннү булш.



1



2

1- Өвөрхангай аймгийн Богд сум, Тэвш уул  
2 - Өмнөговь аймгийн Булган сум, Хавцгайт

Түүнчлэн Монгол, Тува, Ордос, Шинжаанд малтсан хүннүгийн булшнуудаас гарсан бүсний хүрэл чимэглэлүүдийн дүрслэл нь уран сайхны талаасаа Монголын зарим хадны зурагтай ихэд төстэй юм. Тэдгээрийн онцлог бол буга, тэмээ, үхэр, адуу, янгир, чоно, нохой, муурын төрлийн амьтдыг эсрэг юмуу өөд өөдөөс нь харуулан хос хосоор нь зурдагт оршино. Ийм төрлийн хосмолжин\*\*\*\* зургуудыг

\*\*\*\* Хосмолжин – хос болгосон юм, тэгш хэм (тэг дундаасаа хоёр тийш адил хэмжээтэй байх) [Монгол хэлний, 2008: 2578] буюу аливаа нэгэн юмны дүрсийг толины тусгал мэт голоор нь нийлүүлэн хоёр тийш, эсвэл өөд өөдөөс нь харуулан зурсныг хэлнэ.





*Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум,  
Цагаан элэгийн хадны зураг*

төмрийн түрүү үе болон хүннүгийн үед холбогдуулан үзэх боломжтой байна. Ямарваа нэгэн юмыг хосмолжин (симметрийн) аргаар зурдаг нь амьтны загварт урлагийн нэг онцлог бөгөөд Монгол, Ордос, Сибирийн төмрийн түрүү үе, Хүннүгийн үеийн бүсний арал болон бусад чимэглэлд өргөн ашиглагдаж байжээ.

### ***Түрэг угсааны улсуудын үе (1500-аас 1000 жилийн өмнө)***


Хүннүгийн үеэс эхлэн нүүдлийн мал аж ахуй сонгодог хэлбэрт орсонтой уялдан хүмүүсийн шүтлэг бишрэлийн зан үйлд өөрчлөлт орж ямарваа нэгэн баатар эр, дайн тулааны ялалт, ан авын олз омгийг алдаршуулж мөнхжүүлэн үлдээх зорилгоор хаднаа зураг зурж байсан гэж үзэж болохоор байна. Иймээс Түрэгийн үеийн хадны зураг нь олныг хамарсан ан ав, баатарлаг тулалдаан, дайчин эрийн алдар гавъяаг мөнхлөн дуурсгах, ялалтын бэлгэдэлтэй холбоотой зурагдаж байсан хэмээн үзэж болно.

Түрэгийн үеийн хадны зургийн гол онцлог нь дүрслэлийн бодит шинж, зарим нэг бүрдэл хэсгүүдийн нийтлэг тал, зарим тохиолдолд руни бичигтэй нэг дор нарийн үзүүртэй багажаар зурсан зэрэг

байдаг ажээ. Тодруулбал, том гуалиг биетэй адууны дэлийг гурван сойлготой дүрсэлдэг, зарим морьтон эртний Түрэгийн үеийн Алтайн оршин суугчдын үс засалттай ижил хэлбэрийн үстэй, нум сумаар харваж буй хүнийг үргэлж хөдөлгөөнтэй байдлаар үзүүлдэг зэрэг нийтлэг шинжүүдтэй байна. Түрэгийн үед хамгийн их тархсан зургийн сэдэв зохиомж нь ан агнуурыг харуулсан байх ажээ.



*Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум,  
Шивээт хайрхан (Түрэгийн үе)*



*Дундговь аймгийн Өлзийт сум,  
Дэл уул (Уйгурын үе)*

Дундговь аймгийн Дэл уулын Зүүн Билүүний амны морьт унасан найман хүн, ачаатай нэг тэмээ дүрсэлсэн нарийн зураасан зургийг судлаачид Түрэг болон тэдний мэдэлд жагсдаг аймгууд цэргээ хэд хэдэн бүлэг болгодог, цагдан сэргийлэх харуул гаргадаг, бас ачаа хөсгөө тодорхой зайд авч явж хамгаалдаг гэсэн цэргийн хэргийн үндсэн зарчмуудыг тусгасан сурвалжийн мэдээг үндэслэн VI-IX зууны үеийн Төв Азийн нүүдэлчдийн цэргийн хэргийн сэдвийг тод дүрсэлсэн гээд VII зууны хоёрдугаар хагаст Төв Азид нөлөөгөө тогтоосон Тэлэ буюу түүний нэг том салбар аймаг болох уйгурууд бүтээсэн байх боломжтой хэмээн үзжээ.

### ***Дундад зууны үе (1000-аас 650 жилийн өмнө)***

Монголын хадны зураг дотор дундад зууны үед холбогдох хадны зураг цөөн тоотой тохиолдоно. Тухайлбал, Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Хавцгайтын амны хадны зурагт буй Монгол гүрний үеийн язгууртнуудын аж байдлыг харуулсан өвөрмөц зохиомж бүхий зураг.

Энэхүү зурагт дүрслэгдсэн сандал дээр сууж буй ноёд, хатад, тэдэнд үйлчилж байгаа бараа бологсдын өмссөн малгай, дээл хувцас, исэр сандал зэрэг нь Монгол гүрний үед холбогдох хүн чулуудад дүрслэгдсэн болон хил залгаа бүс нутгийн агуй, бунханы хана, бусад оронд хадгалагдаж буй хөрөг зургууд, номын чимэглэл зургуудад дүрслэгдсэнтэй ижил төстэй юм.



*Өмнөговь аймгийн Булган сум, Хавцгайтын хадны зураг*

Улаанбаатар хотын өмнө Богд уулын Их тэнгэрийн амны хадны зураг дахь хар бэхээр бичсэн "Мөнх хөх тэнгэр" гэсэн үг бүхий монгол бичээс, түүний хажууд буй монгол дээлтэй, богтаг малгай өмссөн эмэгтэй хүн, цоохор толботой согооны зураг мөн дундад зууны үед холбогдоно.



*Улаанбаатар хот, Их тэнгэрийн амны хадны зураг*



## ХАДНЫ ЗУРГИЙН ХӨГЖЛИЙН ЗҮЙ ТОГТОЛ

Агуйн хана болон байгалийн хаданд ан амьтад, олон янзын дүрс тэмдгийн зүйлсийг зурах болсон нь дээд палеолитын үед үүссэн гэдгийг эрдэмтэд олон жилийн судалгааны дүнд тогтоожээ. Амьтдын дүрслэлийг зурган дүрсээр бидэнд үлдээсэн эртний хүмүүс бусдад үзүүлэн хэн нэгний таашаалыг хангах гэж зураагүй харин дом шившлэг хийх, мөргөн гуйсан утгаар дүрсэлсэн бололтой байдаг. Энэ үеийн зураг нь ихэвчлэн агуйн хана, таазнаас илэрч олддог, гэхдээ агуйн харанхуй мухарт буюу хүрч очиход төвөгтэй газруудад байгаа, тэдгээрт аймшигт махчин араатнуудыг дүрслээгүй байгаа явдал, мөн нэг газарт давхардуулан зурсан зэрэг нь үүний илэрхийлэл юм.

Тухайн үеийн хүний үйл ажиллагааны аливаа хэрэг нь зөн совин, сүсэг бишрэл, үйл хөдлөл, хэл яриа зэрэг хамтын ухамсрын харилцаагаар шийдэгдэх хорио цээрт суурилж байсан ажээ. Иймээс хүй нэгдлийн байгууллын хүмүүс зөвхөн анчин гөрөөчин, ургамлын үр үндэс түүгчид байсангүй, ан гөрөө, идэш тэжээлийн олз омогтой байх явдлыг урьдчилан шинжих, улмаар аливаа саад тотгорыг засахыг оролдож байсныг үгүйсгэх аргагүй юм. Ингэхдээ уул, ус, ургамал амьтан зэрэг байгалийн юмс үзэгдлийг дотооддоо нууцлаг хүч чадал, ид шидтэй хэмээн ойлгох болж цалигчлан (фетишизм\*\*\*\*) шүтэж эхэлжээ. Ялангуяа хад чулууг амьтай, шидтэй хэмээн үзэх болсон нь эрдэс чулуулаг бүр ургамал, амьтан, хүнд янз бүрээр нөлөөлдөгийг хүмүүс анзааран ухаарах болсонтой холбоотой. Ийнхүү эртний хүмүүс байгалийн элдэв аюулт үзэгдлээс өөрсдийгөө хамгаалах болон ан авын шаардлагаас үүдэн дом шившлэгийг зохион хэрэглэж байгаль дэлхийг аргадах, тайтгаруулах үүднээс мөргөн гуйж, ертөнцийг

\*\*\*\* Амьд биш юмс үзэгдлийн ид шид, хүчин чадалд итгэх үзэл, цалигчлах үзэл

танин мэдэхийг эрмэлзэж эхэлсний үр дүнд тэр нь зураг дүрсээр биеллээ олж хаднаа анх зурагдаж эхэлжээ. Ер нь эртний хүмүүс ан агнуур эрхлэн амьдрах явцдаа хөдөлмөрийн багаж зэвсгээ хийж чаддаг болсноор зураг дүрс урлан сийлэх нөхцөл бүрдсэн байна. Ингэхдээ байгалийн хад чулуун дээр нарны гэрлээс туссан ямарваа нэгэн амьтны сүүдрээс санаа авч зурж эхэлсэн бололтой. Сүүдэр нь нарны тусгалын өнцгөөс хамаарч том жижиг, урт, богино янз бүрийн хэлбэр дүрстэй үзэгдэх тул ямар нэгэн зүйлийн сүүдэрт тухайн зүйлийн нууцлаг хүч чадал, ид иш нь оршдог хэмээн сэтгэж сүүдрийг тойруулан зурж эхэлснээр агуйн хана болон хад чулуунд зураг дүрс урлаж эхэлсэн байж болох юм. Ийнхүү хад чулууг дотооддоо нуугдмал хүч чадалтай хэмээн сэтгэж түүн дээр ямарваа нэгэн амьтныг байгаа байдлаар нь зурснаар өөрсдийн хэрэгцээ, хүсэл зорилгоо тусгай шүтлэг бишрэлийн зан үйлийн тусламжтай олж авна гэж үздэг байжээ.

Хүрэл, төмөр зэвсгийн түрүү үед хад чулуунаа зураг дүрс сийлэх нь шүтлэг бишрэлийн зан үйлийн салшгүй нэгэн хэсэг болж ирсэн бололтой. Монгол орны хадны зургийн дурсгалт газруудад хийсэн судалгаанаас харахад эртний хүмүүс хаа дайралдсан хад чулуунаа зураг дүрс урладаггүй байсан бөгөөд үүнийг хадны зурагтай газруудын ойр орчмын яг ижил хад чулуунаа зураг зурагдаагүй, харин нэг дор төвлөрсөн байдалтай, түүхийн өөр өөр үед холбогдох зургууд нэг газар, зарим тохиолдолд давхарлан зурагдсан\*\*\*\*\* байдгаар тайлбарлаж болно. Учир нь агуй, хад асга, бул чулуу болгон эрчим хүчний эерэг цөм бүрдсэн цэг байдаггүй

\*\*\*\*\* Зарим агуйн хана, байгалийн хад чулуунд давхарлан зурагдсан буюу он цагийн хувьд түүхийн олон үед хамаарах зургууд нэг дор байрласан байдаг нь түүнийг бодит амьдралыг харуулж хойч үедээ дурсгал болгон үлдээх гэсэн урлагийн дурсгал юмуу эсвэл хүн нэгэн хүний уйдсандаа зурсан хэрэг хараахан биш харин тухайн газрыг ямар нэгэн эерэг энерги, эрчим хүч хуралдсан газар хэмээн сонгож өөрсдөд нь сайнаар нөлөөлнө гэсэн итгэл үнэмшлийн улмаас түүхийн өөр өөр үед үе уламжлан тахиж ирсний илрэл юм.



хэмээн үзэж бөө удган нар эрдэс чулуулагтай харьцах явцдаа хүний оюун санааны тэнцвэрт хамгийн сайнаар нөлөөлж чадах тийм хад чулуу бүхий газар оронг сонгодог байсан хэмээн үзэж болно. Иймээс хадны зургийн дурсгалт газрууд нь зориуд сонгож авсан, эртний хүмүүсийн байгаль дэлхийгээ аргадах, ангын олз омог, дайн тулааны амжилт ялалтыг урин дуудах, мал сүрэг болон өөрсдийн овог аймгийн өсөн үржихийг бэлгэдэх, өвөг дээдсийнхээ сүнсэнд тахил өргөхтэй холбогдсон зураг дүрс сийлэн урласан тусгай газрууд байсныг харуулж байна. Тодруулбал, байгалийн элдэв үзэгдэл болох ган, зудын улмаас нутаг сэлгэн дайжсан янгир, аргаль мэтийн ан амьтад болон хорогдож цөөрсөн мал сүргээ эргэн өсөж үржин олшрохыг бэлгэдэх, ан авын үйлийг амжилттай болгож өгөхийг гуйн урьдаас ховсдох, амжилттай болсон ан авын үйлийг баяр ёслолын байдлаар тэмдэглэн цаашид улам илүү олз омогтой байлгахыг хүсэн байгаль дэлхийдээ талархснаа уламжилж агнасан ангынхаа дээжийг өргөж буй санаагаа илэрхийлэх, дайн тулааныг өөрсдийн амжилтаар дуусгахыг бэлгэдэн хүмүүс хоорондын тулааныг дүрслэх гэх зэргээр ямарваа нэгэн үйл явдалд холбогдох зураг дүрсийг хад чулуунаа урлан сийлж шүтлэгийн зан үйл гүйцэтгэдэг байжээ. Энэ нь тусгай увдист бөө нарын тусламжтайгаар өвөг дээдсийнхээ сүнс, онгодын ертөнцөд нэвтэрч, тэднээр дамжуулан байгаль дэлхийн эзэн сахиуснуудад өргөл өргөж амьдрал, ахуйгаа даатгаж буй хэрэг хэмээн ойлгож болохоор байна.

Ийнхүү хадны зураг нь анх дээд палеолитын үед бодит амьдралаас урган гарсан эртний дом шившлэг, хад чулуу, мод ургамал шүтэх фетишизм, анимизм, амьтан шүтэх тотемизм, нар сар, од гаригийг шүтэх жирийн шүтлэг бишрэлтэй холбоотой үүсэж неолитын үед бөө мөргөл үүссэнээр уламжлагдан улам боловсронгуй болж

хүрэл, төмрийн түрүү үед хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн гэж үзэж байна. Харин хүрэл зэвсгийн сүүл, төмрийн эхэн үеэс эхлэн эртний нүүдэлчид хүн төрөлхтөний сүсэг бишрэлийн анхны хэлбэр болох ан амьтан, байгалийн юмс үзэгдлийг дотоод нууцлаг хүч чадалтай хэмээн шүтэх явдлаас эрхлэх аж ахуйтай холбоотойгоор тэнгэр, газар, өвөг дээдсийнхээ сүнсийг тайж тахих шүтлэгийн хэлбэрт аажмаар дэвшин орсон, улмаар бичиг үсэг үүсгэн хэрэглэх болсон зэрэг нь хад чулуунаа зураг зурж тахилга үйлддэг зан үйл аажмаар хумигдан багасахад нөлөөлжээ.

Үүнээс хойш хад чулуунд зураг дүрс сийлэх нь аажмаар багасаж улмаар энэ уламжлал бараг устажгүй болсныг эртний нүүдэлчдийн дунд эрхлэх аж ахуйн нөлөөгөөр малтай холбоотой шүтлэг үүсэж оршуулга, тахил тайлгын зан үйлд малыг ашиглах болсон, мөн өвөг дээдсийн болон тэнгэр шүтлэг зонхилох болж буган хөшөө, хүн чулуу урлан өвөг дээдсээ шүтэх, тэнгэр, нар саранд мөргөн тахил тайлгын ёслол үйлдэх болсон, бичиг үсэг үүсгэн хэрэглэж эхэлсэн, улмаар дундад зууны үеэс бөө мөргөлийн зан үйлийн дагуу овог аймаг, айл өрх болгон өвөг дээдсийг шүтэх хоймрын онгод бүтээн гэр орондоо эрхэмлэн залж түүндээ өдөр тутмын амьдралаа даатган мөргөх болсон зэрэгтэй холбон үзэж болно. Иймээс хадны зургийн хөгжлийн зүй тогтлын асуудлыг байгальтай харьцах явцад үүссэн эртний хүмүүсийн жирийн шүтлэг бишрэлээс эхлээд амьжиргааны хэлбэр (ан агнуур, мал аж ахуй) өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бөө мөргөл, улмаар тэнгэр шүтлэг, өвөг дээдсийн сүнсийг шүтэх болсноор буюу хүний оюун санаа хөгжихийн хэрээр шүтлэгийн хэлбэр өөрчлөгдөж ирснээр тайлбарлаж байна.

\* \* \*

Хүн төрөлхтөний өвөг дээдэс өөр өөрсдийн соёл иргэншлийг бүтээж тэрхүү соёлоос үеийн үед загвар авч уламжлан хөгжүүлсээр ирсэн

билээ. Тэр соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь хадны зураг юм. Хадны зураг нь тухайн үеийн хүмүүсийн үлдээсэн шүтлэг бишрэл, урлаг соёлын бүтээл, хэл болон бичгийн дүрсжсэн дурсгал болох тул тэдний ахуй амьдралын талаарх үнэтэй мэдээллийг агуулж байгаа түүхийн эх сурвалж болно. Учир нь хадны зурагт шүтлэг, бэлэгдэл зүй, домог зүйн сэтгэлгээнээс гадна тэдгээр хүмүүсийн бүхий л мэдлэг шингэсэн байдаг гэж хэлж болно.

Монгол орны хадны зурагт хийсэн судалгаанаас үзэхэд хүрлийн үеэс төмрийн түрүү үеийг дуустал хадны зургийн сэдэв бараг өөрчлөгдөөгүй, харин дүр дүрслэл, утга агуулга, дүрслэлийн арга барилын хувьд баяжин нэмэгдэж ирсэн байна. Тухайлбал, цаг хугацааны явцад ан амьтдын дотроос бугыг загварчлан дүрслэх болсон, хүнийг үйл хөдөлгөөнд оруулан морь унаж буй, нум сумаар харваж буй, хоорондоо тэмцэлдэж буй, бүжиглэж буй, ямар нэгэн зан үйлийн ёслол гүйцэтгэж буй зэргээр нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу эрхлэх аж ахуйтай холбоотойгоор үйл хөдлөлийг тодорхой дүрслэх болсон байна. Ийнхүү хадны зургийн сэдэв баяжин нэмэгдэж ирсэн нь он цаг, хүний оюун санааны хөгжилтэй нягт хамааралтай юм. Үүнээс үндэслэн хадны зураг нь хүн төрөлхтөний нийгэм, аж ахуй, соёл урлагийн хөгжлийг бодвол удаан хувьсан хөгжиж ирсэн гэж үзэж болно. Учир нь хадны зургийг урлахад уран дүрслэл гол биш илэрхийлж буй утга санаагаа тодорхой гаргахыг эрмэлзэж өмнөх үеүдээс бараг ялгарах зүйлгүй дүрсэлдэг байсанд оршино.

Хадны зураг нь зөвхөн бодит байдлын тусгал биш, харин эртний хүмүүсийн байгалийн эрхшээлийг даван гарахын тулд өөрсдөө аливааг бүтээх, зохицуулах гэсэн үйл ажиллагаа буюу хүн байгалийн хоорондын харилцаа, эрхэлж байсан аж ахуйтай холбоотой үүссэн хүний оюуны сэтгэлгээ, шүтлэг бишрэлийн гүн

агуулгатай зан үйлийн салшгүй хэсэг болох нь тодорхой байна. Ийнхүү шүтлэг бишрэлтэй холбоотой үүсэж хөгжсөн хадны зураг хүний оюун санааны өөрчлөлт хувьсалтай уялдан бодит байдлыг тусган харуулсан дүрслэх урлагийн нэгэн төрөл болон хөгжих эх үүсвэрийг тавьжээ.

Хүн төрөлхтөний өвөг дээдсийн үлдээсэн соёлын дурсгалыг судлах ажил өнөөг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд илэрч мэдэгдсэн хадны зургууд олон нууцыг хадгалсаар байна.

# ГУРАВ.

МОНГОЛЫН БУГАН ЧУЛУУН  
ХӨШӨӨНИЙ СОЁЛ



## **БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол болон Төв Азийн нутагт буй хүрэл, түрүү төмрийн үед холбогдох гайхамшигт сүрлэг дурсгал бол буган хөшөө юм. Буган хөшөөнд ихэнхдээ бугыг уран гоёмсогоор загварчлан дүрсэлдэг учраас “Буган хөшөө” хэмээн нэрлэх болжээ.


Суурьшмал соёл иргэншлүүдээс алс холд Төв Азийн гүнд үүсэн хөгжсөн энэхүү гайхамшигт соёлын ололт нь нүүдэлчид дан ганц эвдрэл сүйрэл авчирдаг биш харин ч өөрсдийн бие даасан өндөр түвшиний соёлыг бүтээж байсныг харуулдаг маш үнэмшилтэй нотолгоо юм. Буган хөшөөд бол зүй ёсоор хүн төрөлхтний соёлын үнэт сан хөмрөгт багтах учиртай урлаг-соёлын хосгүй үзэгдэл мөн болно. Буган хөшөө нь хүрлийн үеийн оршуулга, тахилгын зан үйл, ертөнцийг үзэх үзлийг илэрхийлэхээс гадна хүрэл зэвсгийн үеийн эртний нүүдэлчдийн соёлд өргөн дэлгэрсэн амьтны загварт урлагийн гарамгай төлөөлөл юм. Буган хөшөөнд “Амьтны загварт урлаг” бүрэн төгс байдлаараа илэрхийлэгдэж байгаагийн хувьд нүүдэлчдийн соёл-урлагийн нэвтэрхий толь гэж нэрлэж болно. Энд амьтны загварт урлагийн гол дүрүүд бүгд дүрслэгдсэн байдаг.

Буган хөшөөг нас барсан хүнд зориулан хүнийг төлөөлүүлэн үйлдсэн гэдэг нь нэгэнт тодорхой бөгөөд хөшөөнд дайчин эрийн зэвсэг болох чичлүүр хутга, билүү, байлдааны зээтүү, нум, хоромсого, жад, бамбай, толь, дуулга дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бугын дүрсний оронд буюу завсар зайд адуу, ирвэс, янгир, зээр, зэрлэг гахай, үхэр зэрэг амьтад, тэрэг дүрсэлсэн нь тохиолдоно.



Буган хөшөөг боржин, элсэн, хүрмэн зэрэг чулуу ашиглан дунджаар 1-4 м гаруй өндөр, 20-40 см зузаан, 30-80 см өргөн хэмжээтэй хийх ба түүнийг үйлдэхэд уран зураг, сийлбэр, уран баримлын аргуудыг хослуулан ашигласан байдаг.

Монголын буган хөшөөний дийлэнх нь хүрлийн үеийн хиргисүүрийн дэргэд мөн түрүү төмрийн үеийн дөрвөлжин булшинд ашигласан байх бөгөөд цөөн тохиолдолд түрүү төмрийн үеийн Пазырык булш, эртний Түрэгийн үеийн тахилын онгоны дэргэдээс илэрдэг. Гэхдээ дээрх дурсгалуудад үргэлж барилгын материал хэлбэрээр ашигласан байх бөгөөд ямар нэгэн онцгой хүндэтгэл үгүй, зөвхөн таатай хэлбэр хэмжээтэй бэлэн чулуу болохын хувьд хэрэглэсэн шинжтэй байдаг. Түүнчлэн өөр газраас зөөгдөж ирсэн шинжтэй, ойр орчимд ямар нэг дурсгалгүй цор ганц буган хөшөө ч таардаг. Харин хилийн чанадад Евразийн баруун хэсэгт хиргисүүрээс өөр төрлийн оршуулга-тахилгын байгууламжтай хамт нэгэн бүхэл цогцолбор болон байрлах нь тохиолддог билээ.



*а. Шивэртийн амны буган хөшөө,  
б. Баянцагааны хөндийн адагийн буган хөшөө, Ихтамир, Архангай.  
© Ж.Гантулга*

Мөн буган хөшөөг тойруулан чулуун байгууламжуудыг байгуулан дотор нь тахилгын зан үйл үйлдэж байсан нь Монголын төв хэсгийн олон цогцолбор дурсгалаар нотлогддог.



*Буган хөшөөний тахилгын цогцолбор, Өндөр-Улаан, Архангай.  
© Ц.Төрбат*



*Буган хөшөөний тахилгын цогцолбор, Шилүүстэй, Завхан.  
© Ж.Баярсайхан*

## **БУГАН ХӨШӨӨНИЙ СУДАЛГААНЫ ТОЙМ**

Евразийн хээр талын бүс нутагт өргөн тархсан түүх соёлын гайхамшигт дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд 130 гаруй жилийн тэртээгээс судалж эхэлсэн ба энэхүү түүхийг дөрвөн үед хуваан хураангуйлан авч үзэж болно.



*Хиргисүүрийн дэргэдэх буган хөшөөд, Сагсай, Баян-Өлгий,  
© Н.Баярхүү*



*Буган хөшөөг дөрвөлжин булшинд ашигласан байдал, Дунд Жаргалантын ам,  
Өмнөдэлгэр, Хэнтий*

*Эхэн үе буюу XIX зууны 80-иад оноос XX зууны 30-иад он.*

Энэ үед Г.Н. Потанин, Н. Ядринцев, В.В. Радлов, А. Позднеев, А.Н. Казнаков, Г. Гране, Х. Аппельгрэн-Кивало, Г.И. Боровка, Б.Э. Петри нарын судлаачид Монгол орон болон Саян-Алтайгаас анх буган хөшөөд илрүүлэн олж, түүн дээрх дүрслэлийн утга санаа, холбогдох он цагийг тогтоох оролдлогыг хийж эхэлжээ. Тухайлбал, Финийн судлаач Х. Аппельгрэн-Кивало буган хөшөөн дээрх дүрслэлүүдийг

Хятадын Хангийн үеийн булшны чулуун дээрх зурагтай харьцуулан НТӨ ба НТ зааг үед холбогдуулан үзсэн байна.

Энэ үеийн судалгаа ерөнхийдөө бугын дүрслэл бүхий хөшөө чулуудыг илрүүлэн олж, судалгааны эргэлтэнд оруулахын зэрэгцээ тэдгээрийн холбогдох он цагийг тогтоох оролдлого хийж эхэлсэн үе юм.

*Хоёрдугаар үе буюу XX зууны 40-60-аад оны сүүл үе.*

Г.П. Сосновский, А.П. Окладников, С.И. Вайнштейн, Л.Р. Кызласов, Ц. Доржсүрэн, Н.Н. Диков, Н.Л. Членова, П.П. Хороших, В.В. Волков, Н. Сэр-Оджав, М.Х. Маннай-Оол, Н. Аварзэд, Д. Наваан нарын судлаачид Төв Азийн буган хөшөөдийн ангилал, зориулалт, дүрслэлийн утга санаа, холбогдох он цагийг тогтоох тал дээр судалгааны ажлаа чиглүүлж байв. Тухайлбал, Монголын ууган археологичдын нэг Ц.Доржсүрэн 1955 онд баруун аймгуудад археологийн хайгуул хийхээр явах замдаа Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Алтансандал уулын шилд буландаа адууны зурагтай хөшөө чулуу бүхий дөрвөлжин булшийг малтан шинжилж, тэрхүү хөшөө чулууг цаашид “Адуун чулуу хөшөө” хэмээн нэрлэх санал дэвшүүлжээ. Н.Н. Диков 1958 онд нийтэлсэн “Өвөр Байгалын хүрэл зэвсгийн үе” номондоо 20 орчим буган хөшөөг бугын бодит дүрстэй, бугын загварчилсан дүрстэй, хүн төрхтэй гэж гурав ангилан үзсэнийг хожмын судлаачид хүлээн зөвшөөрөх болжээ.

Мөн Н.Л. Членова буган хөшөөг гадаад хэлбэр төрхөөр нь дараах хоёр төрөл болгон ангилжээ. Үүнд: 1. Гурав заагласан бүслүүртэй ба дээд хэсэгтээ хүзүүний сондор зүүлттэй буган хөшөөд, 2. Хүнтэй төстэй боловч эмх замбараагүй дүрслэлтэй бусад төрлийн буган хөшөөд болно. Мөн дээрх хэлбэр төрхийн буган хөшөөд нь он цагийн хувьд НТӨ V зуунаас хэтрэхгүй хэмээн үзсэн байна.

Ерөнхийд нь энэ үеийн судалгааг дүгнэн хэлбэл, судалгааны ажил

эрчимжихийн хэрээр илрүүлэн олж буй буган хөшөөдийн тоо нэмэгдэж, сонин хачин дүрслэл бүхий хөшөөд ч олонтоо олдох болж. Ийнхүү судалгааны эх хэрэглэгдэхүүн баяжснаар тэдгээрийг нарийвчлан ангилах, зориулалт, утга санааг тайлбарлах, холбогдох он цагийг тогтоох тал дээр ихээхэн ахиц гарсан үе юм. Тухайлбал, Н.Н. Диковын хийсэн ангилал дээр үндэслэн цааш цаашдын ангиллууд хийгдэх болсон.

*Гуравдугаар үе буюу XX зууны 70-90-ээд оны үе.*

1970-аад оноос буган хөшөөний талаарх судалгаа нэлээд эрчимжин А.П. Окладников, М.Х. Маннай-Оол, П.П. Хороших, С.Н. Вайнштейн, И. Эрдэли, Д. Цэвээндорж, Д. Наваан, Ю.С. Гришин, М.А. Дэвлэт, Л.Р. Кызласов, М.П. Грязнов, В.Д. Кубарев, Я.А. Шер, А.Д. Грач, В.В. Волков, Н.Л. Членова, Т. Санжмятав, Р.Б. Исмагилов, Ю.С. Худяков, Б.Н. Пяткин, В.Н. Добжанский, А.А. Ковалев, Э.А. Новгородова, Д. Баяр, В.В. Бобров, В.С. Ольховский нарын судлаачид өөрсдийн зохиол бүтээлдээ буган хөшөөний гарал үүсэл, үүрэг зориулалт, ангилал, дүрслэлийн утга санаа, он цаг, бусад төрлийн дурсгалтай хэрхэн холбогдох зэрэг асуудлаар олон санал, таамаглал дэвшүүлж байв. Тухайлбал, Д. Цэвээндорж Архангай, Хөвсгөл, Булган, Баянхонгор, Хэнтий аймгийн нутагт буй 90 гаруй буган хөшөөг нэгтгэн судалж, он цагийг нь НТӨ II-I мянган жилд холбогдуулан улмаар хөшөөн дээр сийлсэн таван талт дүрсийг “бамбай” хэмээн тайлбарлах санал гаргажээ.

Мөн В.Д. Кубарев Оросын Алтайгаас олдсон дөч гаруй буган хөшөөг хадны зураг, археологийн малтлагаас гарсан олдвор хэрэглэгдэхүүнтэй харьцуулан буган хөшөөн дээрх дүрсийг тайлбарлахын зэрэгцээ хөшөөний зориулалт, утга санааг тайлбарлах, хөшөөг хийх арга барилыг тодруулах талаар нэлээд сонирхолтой санаа, дүгнэлт хийжээ. Түүнээс гадна В.В. Волков хорь

гаруй жилийн турш буган хөшөөний талаар хийсэн судалгааныхаа үр дүнг нэгтгэн 1981 онд “Монголын буган чулуу” гэдэг томоохон бүтээлээ нийтэлжээ. Тэрээр БНМАУ-ын нутгаас өөрийн болон бусад судлаачдын тухайн үед олж илрүүлээд байсан 500 орчим буган хөшөөний 250 гаруйг нийтэлж, нийт хөшөөг 3 ангилан дээрх зураг дүрсийг төрөл бүрээр нь нарийвчлан судалсны үндсэн дээр хөшөөний он цагийг өөрийн урьд үзэж байснаас урагшлуулан НТӨ I мянган жилийн эхэнд, хүрэл зэвсгийн сүүл үед холбогдуулан үзсэн байна.

Өөрөөр хэлбэл, энэ үеийн судалгааны ажлыг ерөнхийд нь дүгнэвэл, илрүүлэн олсон буган хөшөөний тоо даруй 500 орчим болсон. Мөн хэд хэдэн газарт малтлага судалгаа хийсний үр дүнд буган хөшөөний гарал үүсэл, үүрэг зориулалт, ангилал, дүрслэлийн утга санаа, он цаг, бусад төрлийн дурсгалтай хэрхэн холбогдох, хөшөөг хийх арга барилыг тодруулах зэрэг асуудлаар олон шинэ санал, таамаглал дэвшүүлж байсан үе юм.

*Дөрөвдүгээр үе буюу 1990-ээд оноос өнөөдрийг хүртэл.*

Энэ үеэс судалгааны эрч нэлээд сулраад 2000 оны үеэс дахин сэргэж эхэлсэн нь нийгэм эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлттэй шууд холбоотой байв. Монгол орон зах зээлийн нийгэмд шилжиж, дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцах болсноор буган хөшөөний судалгаанд нэлээд амжилт олсон юм. Жишээ нь, буган хөшөөний тархалт, бүтэц, хэлбэр төрх түүний бүс нутгийн онцлог шинжүүд, он цагийн хүрээ гэх мэт нэлээд зүйлс тодорхой болсоор байна.

Ийнхүү буган хөшөөний судалгаа өнөөдрийн хүртэл тасралтгүй үргэлжилж ирсэн бөгөөд энэ судалгаанд Зөвлөлт-Оросын эрдэмтэд чухал хувь нэмэр оруулсныг үнэлж баршгүй юм. Тухайлбал, уг сэдвээр гарсан анхны томхон бүтээлийн тоонд Оросын судлаач



В.Д. Кубаревын “Алтайн эртний хөшөөд. Буган чулуу” (Новосибирск 1979) хэмээх ном орно. Харин Монголын буган хөшөөдийн талаарх буурьтай бүтээлийн анхных нь Оросын археологч В.В. Волковын “Монгол буган хөшөөд” хэмээх ном юм. Энэ бүтээл 1981 онд анх Улаанбаатарт хэвлэгдсэн бөгөөд хожим 2002 онд бага хэмжээний нэмэлт хийгдэн хоёрдахь удаагаа Москвад хэвлэгджээ. Түүнчлэн Н.Л. Членовагийн “Буган чулууд түүхийн сурвалж болох нь (Умард Кавказын буган чулуудын жишээн дээр)” (Новосибирск 1984), Д.Г. Савиновын “Евразийн нүүдэлчдийн соёл дахь буган хөшөөд” (Санкт-Петербург 1994), В.С. Ольховскийн “Түрүү төмрийн үеийн Евразийн баруун хэсгийн оршин суугчдын монументаль сийлбэр” (Москва 2005) зэрэг номнууд Евразийн буган хөшөө судлалын суурь бүтээлүүдэд тооцогддог.

Сүүлийн хэдэн жилд манайд буган хөшөөний судалгаа идэвхжин өргөжиж олон арван бүтээл хэвлэгдсэний дотор хоёр ч өнгөт каталоги ба судалгааны бүтээл гарчээ. Эдгээр нь Ц.Төрбат, Ж.Баярсайхан нарын хэвлүүлсэн “Жаргалантын амны буган хөшөөд”, Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Магай нарын хэвлүүлсэн “Хойд Тамирын буган хөшөө” (УБ., 2016), “Монголын буган хөшөө” (УБ., 2016) зурагт цомог зэрэг болно.

Мөн онцлон тэмдэглэх нэг зүйл бол 2014 онд ЮНЕСКО Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтанд Хойд Тамирын хөндий, Жаргалантын ам, Уушигийн өвөрийн буган хөшөө бүхий цогцолбор дурсгалт газруудыг бүртгэн авчээ.

Ийнхүү энэхүү 130 гаруй жилийн судалгааны үр дүнд буган хөшөөний судалгааны үндсэн асуудлууд бараг бүгдээрээ шийдэгдсэн гэж үзэж болно. Үүнд: утга агуулга буюу семантик, тархалт ба ангилал зүй, хиргисүүр ба буган хөшөөний холбоо, эдгээрийн тахилгын байгууламжууд, он цаг ба соёлын хамаарал зэргийг нэрлэж болно.

Харин гарал үүслийн тухай суурь асуудал бүрэн шийдэгдээгүй гэж үзэж болно. Цаашдын судалгааны чиглэл энэхүү гарал үүслийн асуудалд төвлөрөх нь гарцаагүй юм.



*Буган хөшөөний чулуу олборлож байсан газар, Шивэртийн ам, Баянцагааны хөндий, Ихтамир, Архангай*

## БУГАН ХӨШӨӨНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ

Буган хөшөө чухам хаана анх үүссэн бэ? гэдэг талаар судлаачид санал зөрөөтэй байдаг. Тухайлбал, Оросын судлаач Н.Л. Членова бугын “дүрс өргөн тархсаныг сак болон түүний төрөл аймгууд эдгээр нутагт нэвтэрч” орж ирсний үр дүн мэтээр, В.В. Волков буган чулуун хөшөөг үйлдэх зарим арга барил Скифчүүдээс Монголд, М.Х. Маннай-Оол Монголоос Тува, улмаар цааш тархсан гэж үздэг ба харин бид М.Х. Маннай-Оолтой санал нийцэж байна. Эрдэмтэд буган хөшөөг ямар ч гэсэн зөөж явдаг зүйл бус, түүнийг өөрийн орны билэгдлийг хатуу санадаг дайчид ирж газар дээр нь бүтээсэн хэмээн үздэг. Үнэхээр ч төрөлх нутагтаа буган хөшөөг хэдэн зуугаар бүтээж үлдээсэн Төв Азийн нүүдэлчин овог аймгуудын зарим хэсэг Евразийн хээр талын бүс нутгийг туулж Дорнод Европт хүрч очихдоо төрөлх нутгийнхаа буган хөшөөнд дүрсэлж байсантай ижил төстэй

зарим тэмдэг, зэр зэвсгийг энгийн хөшөөнөө сийлж байсан бөгөөд харин бугыг олноор нь дүрсэлдэг заншил орхигдсон байна.

Түүнчлэн буган хөшөөний эртний дурсгалууд зөвхөн Монгол орны төв нутгаас олдож байгаа нь энэхүү гайхамшигт дурсгал анх Монголын төв нутагт хожуу хүрлийн үед үүсч төмөр зэвсгийн түрүү гэхэд Монгол нутаг даяар түгэн дэлгэрч цаашдаа одоогийн Тува, Байгал нуурын наад бие хүртэл өргөн тархсан ба улмаар Казакстан, Дундад Ази, Оренбургийн муж, Умарт Кавказ, Эльба мөрний сав хүртэл цөөн тоогоор нэвтэрсэн суурьшмал иргэдийн дунд олон арваар бүтээгдэж байгаагүй нүүдэлчдийн дурсгал юм.

Өөрөөр хэлбэл, буган хөшөө зүй ёсоор хүн төрөлхтний соёлын үнэт сан хөмрөгт багтах учиртай урлаг-соёлын хосгүй үзэгдэл мөн бөгөөд Монгол орон, түүнтэй хил залгаа нутагт НТӨ II мянганд цэцэглэн хөгжиж байгаад аажмаар үгүй болсон Төв Азийн хүрлийн үеийн нүүдэлчдийн тахилга шүтлэг, оршуулгын зан үйл, соёлын их баялаг өвөрмөц тод, үнэн бодит гэрч нотолгоо болон сүндэрлэж байна.

## **БУГАН ХӨШӨӨНИЙ ТАРХАЛТ**

Буган хөшөө Ази, Европ хоёр тивийг дамнан тархжээ. Одоогийн байдлаар Монголоос Герман, Уралаас Байгал далай хүртэлх өргөн уудам нутагт 1600 гаруй буган хөшөөг илрүүлэн судлаад байна. Буган хөшөөний нийт тоог 1990-ээд оны дунд үеэр 700 орчим гэж тогтоосноос хойш огт шинэчлэлгүй явж иржээ. Тэр үед Монгол улсын нутгаас 550 орчим, Өвөр Байгалын нутгаас 20 гаруй, Саян Алтайгаас 20 орчим, Уулын Алтайгаас 60 орчим, Казакстан, Дундад Азиас 20 орчим, баруун тийш Оренбург муж, Кавказ, Украин, Эльба гол хүртэл нийт 10 гаруй олдсон хэмээж байсан.


Харин одоо энэхүү тоо шинэчлэгдэж дараах байдалтай болоод байгаа ба үүнийг дэлгэрүүлэн харвал: Монголд 1277, Өвөр

Байгалд 6, Тувад 116, Орос Алтайд 72, Дундад Азид 13, Европод 32, Шинжаанд 105 хөшөө тус тус байна. Энэхүү тоон үзүүлэлтээс харахад буган хөшөөний тархалтын төв болоод үүслийн цөм нь Монгол орон мөн болохын дээр нийт бүртгэгдсэн дурсгалын 80 орчим хувь буюу 1277 хөшөө манай улсын нутагт байна. Монголын буган хөшөөдийн олонх нь нутгийн төв ба баруун хэсэгт тархсан байна.

Хамгийн нягт тархалт Архангай, Хөвсгөл, Завхан, Баянхонгор, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт бий. Харин зүүн тийшээ тархалт нь Хэнтийн нуруу, урагшаа Говь-Алтайн нуруугаар хязгаарлагддаг. Одоо мэдэгдэж байгаа хамгийн зүүн талын буган хөшөө Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Хажуу нуур, хамгийн баруун талын буган хөшөө Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Арал толгой, хамгийн урд талын хөшөө Говь-Алтай аймгийн Алтай сумын Хөртийн урд ам, хамгийн хойд талын хөшөө Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутаг Тарган нуур зэрэг газруудад бий. Мөн Хойд Тамирын голын хөндийд 110 гаруй буган хөшөө байгаа нь нэг голын сав нутагт хамгийн олон тоотой байгаа тохиолдол юм. Энэ нь Хойд Тамирын голын хөндий буган хөшөөний соёлын нэгэн том төв байсныг харуулж байгаагийн зэрэгцээ эндээс буган хөшөө хийх чулууг олборлож байсан газрыг илрүүлсэн нь үүнийг давхар батлаж байгаа хэрэг юм.

## **БУГАН ХӨШӨӨНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛ**

Эрдэмтэд буган хөшөөний хэлбэр төрх, түүн дээрх дүр, дүрслэлийн онцлог, тархсан газар нутгийн хүрээ зэрэгт тулгуурлан ангилах оролдлогууд хийсээр иржээ. Энэ бүх оролдлогуудыг нэгтгэн авч үзвэл үндсэндээ гадаад хэлбэр болон дүр, дүрслэлээр нь ихэвчлэн ангилж ирсэн байна. Ингэхдээ судлаачид эхлээд гадаад хэлбэр



*Монголын буган хөшөөний  
тархалтын тойм зураг*





төрхөөр ангилах оролдлогуудыг хийж, дараа нь дүр, дүрслэлээр нь ангилах, улмаар гадаад хэлбэр төрх болон дүр, дүрслэл, тархсан бүс нутаг зэргийг харгалзан үзэж улам нарийвчилсан ангиллуудыг хийж иржээ.

Олонх судлаачид дараах үндсэн гурван төрөлд хуваан үзэх саналтай байдаг. Үүнд:

I төрөл: Монгол-Өвөр Байгалын хэлбэр буюу бугын загварчилсан дүрст буган хөшөө

II төрөл: Саян-Алтайн хэлбэр буюу амьтдын бодит дүрст буган хөшөө

III төрөл: Ази-Европын хэлбэр буюу амьтны дүрсгүй буган хөшөө хэмээн үздэг.



*Буган хөшөөний гурван хэлбэр төрх*

- 1. Монгол-Өвөр Байгалын хэлбэр буюу бугын загварчилсан дүрст хөшөө*
- 2. Саян-Алтайн хэлбэр буюу амьтны бодит дүрст хөшөө*
- 3. Евразийн хэлбэр буюу амьтны дүрслэлгүй хөшөө*

Төрөл зүйлүүдийн адил ба ялгаатай тал. Дээрх дөрвөн ангилалд хамаарах хөшөөд нь дөрвөлжин болон хавтгай хэлбэртэй чулууны дээд хэсгийг хүзүүний зүүлтээр, доод хэсгийг бүсээр зааглан гурав хувааж, орой хэсэгт хүний нүүр болон ташуу зураас, ээмэг, хүзүүний зүүлт, дунд хэсэгт эд зүйл, доод хэсэгт бүс, түүнээс зүүсэн зэр зэвсэг, эдлэл хэрэглэл дүрсэлснээрээ нийтлэг юм.

Харин эдгээр нь бусдаасаа дараах зүйлсээр ялгардаг. Өөрөөр хэлбэл, Монгол-Өвөр Байгалын төрлийн хөшөөд загварчилсан бугын дүрслэлээрээ, Саян-Алтай төрлийн хөшөөд буга, адуу, гахай, янгир, шувуу зэрэг амьтдыг бодит байдлаар дүрсэлснээрээ, Еврази төрлийн хөшөөд нь ямар ч амьтны дүрслэлгүйгээрээ, Холимог дүрслэлтэй хөшөөд нь загварчилсан бугын дүрслэлийн хажуугаар амьтдыг бодит байдлаар дүрсэлснээрээ ялгардаг.


**Монгол-Өвөр Байгалын хэлбэр.** Энэхүү ангилалд багтах буган хөшөөд Монгол орны төв, умард хэсэгт голлон тархсан байдаг бол Баруун Монголд харьцангуй цөөн таардаг. Гэхдээ Баян-Өлгийн Цагаан Асга, Ховдын Бодончийн голын цогцолборууд загварчилсан бугын дүрстэй олон хөшөөтэй. Өөрөөр хэлбэл, ихэвчлэн Хангайн нуруу болон Хөвсгөлийн уулсаар, цөөн тохиолдолд Монгол Алтайн нуруугаар тархсан нь ажиглагдаж байна. Үүнээс гадна ОХУ-ын Буриадын нутаг Байгал нуурын өмнөд хэсгээр, мөн түүнчлэн Казакстаны нутагт цөөн хөшөө бий.

Монгол-Өвөр Байгалын буган хөшөө нөгөө хоёр төрлийн хөшөөнөөсөө илүү уран нарийн сийлбэртэй, хамгийн олон төрөл зүйлийн дүр, дүрслэлтэй нь юм.

Энэ төрлийн хөшөөний дүрслэлийг дараах байдлаар тоймлон ангилж болно.

1. Хүнтэй холбоотой дүрслэл (хүн, хүний нүүр, ташуу зураас)
2. Загварчилсан буга

3. Эд зүйлс (цагариг ээмэг, хүзүүний зүүлт, сондор, толь, ороомог болон дөрвөлжин дүрс)
4. Зэр зэвсэг (чичлүүр хутга, хутга, зээтүү, сүх, илд, нум сум, жад, бамбай, бүс, дэгээ, билүү, туг)
5. Модны мөчир



*Буган хөшөөний дүр, дүрслэл*

Энэ төрлийн хөшөөг гадаргууг нь маш сайн зассан ба засаагүй гэсэн 2 төрлийн чулуугаар хийсэн байдаг. Гадаргууг засаж янзалсан хөшөөний чулуу дөрвөлжин болон хавтгай гэсэн хоёр янз байна. Харин гадаргууг засаж янзлаагүй хөшөөний чулуу олон янз хэлбэр, хэмжээтэй байдаг. Чулууны төрөл зүйлийн хувьд ихэвчлэн боржин зонхилох боловч гантиг, элсэн чулуу, занар, хүрмэн зэрэг чулуугаар хийсэн нь тохиолддог.

Энэ төрлийн хөшөөний дээд хэсгийн хоёр хажуу талд ихэвчлэн том жижиг дугуй цагариг, ээмэг сийлсэн байдаг. Үүний доогуур хөшөөг бүхэлд нь тойруулан цувраа жижиг хонхоруудаар хүзүүний зүүлтийг илэрхийлдэг. Цөөн тохиолдолд хүзүүний зүүлтийг шулуун ховил зураасаар дүрслэнэ. Хүзүүний зүүлтнээс зарим тохиолдолд гахай зэрэг амьтны соёо болон амьтны дүрст сондор зүүснээр дүрсэлдэг юм. Харин хөшөөний доод хэсгээр янз бүрийн хээ чимэг бүхий бүс дүрсэлж, бүснээс дээш хүзүүний зүүлт хүртэлх зайд сүрэг бугыг ихэд уран гоёмсогоор загварчлан дүрсэлсэн байдаг. Зарим тохиолдолд бугыг бүснээс дооших зайд дүрсэлсэн нь ч бий. Загварчилсан бугын дүрсний онцлог нь уртлаг нарийн их биетэй, гурвалжин шовх сэрвээтэй, шувуу мэт урт хошуутай, нуруун дээгүүрээ угалзран хөвөрсөн олон салаа эвэртэй, тэнгэрт дүүлж яваа мэтээр дүрсэлдэг. Үүнээс гадна бугын дүрсний хамт адуу, янгир, гахай болон бар, ирвэс зэрэг махчин амьтан дүрсэлсэн тохиолдлууд бий. Дээр өгүүлсэн сүрэг бугын дүрсний завсраар дугуй хэлбэртэй дүрс буюу толь, нум сум, саадаг, тагнай хээтэй таван талт дүрс буюу бамбай зэргийг тогтсон талбай хэсгүүдэд сийлсэн байдаг. Тухайлбал бамбайг ихэвчлэн буган хөшөөний ар талд бүсний дээхэн талд дүрслэдэг ажээ. Хөшөөний бүснээс төрөл бүрийн хутга, сүх, дэгээ, билүү зэрэг байлдааны болон аж ахуйн багаж зэвсгийг зүүж дүрслэх бөгөөд зарим буган хөшөөнд эдгээр зүйлсийг бүснээс дээш дүрсэлсэн тохиолдлууд ч цөөнгүй бий.

Монгол-Өвөр Байгалын хэлбэрийн буган хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт ихэнхдээ ямар нэгэн дүрслэлгүй, толийлгон зассан цулгүй хоосон зай байх боловч Төв Азид арав орчим буган хөшөөнд хүний нүүрийг бодитоор сийлэн гаргасан байдаг.

**Саян-Алтайн хэлбэр.** Энэхүү төрөлд хамаарах буган хөшөөний тоо харьцангуй цөөн бөгөөд Хангайн нурууны зүүн урд болон зүүн

хэсэг, Монгол Алтайн нурууны зүүн хэсэг, Их нууруудын хотгороор ихэвчлэн тархаж, харин Монголын төвийн бүс нутгаар цөөн тоотой тохиолдож байна.

Энэ төрлийн хөшөөний дүр дүрслэлийг ерөнхийд нь цацраг бүхий цагариг, хүний нүүр ба ташуу зураас, ан амьтан, эд зүйлс, зэр зэвсэг, морин тэрэг хэмээн ангилан авч үзэж болно.

Саян-Алтай төрлийн буган хөшөөний гол онцлог нь эдгээр хөшөөнд амьтдыг дүрслэхдээ ямагт “бодит байдлаар” буюу скифийн хэлбэрийн босоо бугыг дүрсэлдэгт оршино. Эдгээр хөшөөнд гахай, адуу, буга, загас, янгир болон бар, ирвэсийн төрлийн амьтдыг сийлсэн байдаг. Хэдийгээр эдгээр амьтдыг дүрслэхдээ нүүдэлчдийн “Амьтны загварт урлаг”-ийн үндсэн арга барилыг ашиглах боловч дээрх төрөлд хамаарах загварчлан гаж хэлбэрт оруулаагүй тул харьцангуйгаар “бодит” дүрслэлтэй гэж үздэг.

Үүнээс гадна энэ төрлийн буган хөшөөний нүүрэн талд маш цөөн тооны хүний нүүрний дүрслэл тохиолдох боловч ихэнхдээ хүний нүүрний оронд хоёроос гурван ташуу зураас дүрсэлсэн байдаг. Мөн эдгээр хөшөөдөд хүзүүний зүүлтнээс дээш, хөшөөний орой хэсгийг тойруулан дан эсвэл давхар ховил татаж гаргасан байдгийг судлаачид малгай, толгойн боолт болов уу гэж үздэг. Түүнээс гадна эдгээр хөшөөдийн цөөн хэдэд л “тагнай хээт таван талт дүрс” буюу бамбай дүрсэлсэн байна. Ер нь энэ ангилалд багтах буган хөшөөний тоо цөөн бөгөөд тэдний ихэнх нь Саян, Алтайн нурууны сав газраар тархсан байна. Мөн Монголын төв нутгаар цөөн тоогоор буй.

**Евразийн хэлбэр.** Еврази буюу амьтны дүрсгүй буган хөшөө харьцангуй цөөн ба Зүүн, Баруун Саяны нуруу орчим, Дундад Ази, Хойд Кавказ, Дорнод Европт цөөн тоотой бий. Европын зарим буган хөшөөд дээр эд өлгийн зүйлс буюу титэм, ээмэг, хүзүүний зүүлт, бүс зэргийг нэлээд бодитой тодорхой дүрсэлсэн байдаг.

Энэ төрлийн буган хөшөөний гол онцлог нь ямар нэгэн амьтны дүрслэлгүй байдагт орших бөгөөд хөшөөний дүр, дүрслэлийг хүний толгой, нүүр, ташуу зураас ба гээг үс, эд зүйлс, зэр зэвсэг, бусад дүрслэл хэмээн ангилан үзэж болно. Ерөнхий хэлбэр болон бусад эд өлгийн дүрслэлээрээ бусад буган хөшөөдтэй ижил юм.

Өнөөг хүртэлх судалгааны үр дүнд олдоод байгаа дээрх гурван ангилалд багтах 1277 буган хөшөөний 80 гаруй хувь нь Монгол-Өвөр Байгалын ангилалд багтана. Харин үлдсэн 20 хувь нь нөгөө хоёр ангилалд хамаарна.

### **ХӨШӨӨНИЙ ДҮРСЛЭЛ, ТҮҮНИЙ УТГА АГУУЛГА**


Буган хөшөөн дээрх дүрслэлийн талаархи судалгаа чамгүй хийгдсэн хэдий ч тэдгээрийн учир холбогдол, бэлгэдлийн талаар судлаачид харилцан адилгүй байр суурьтай байдаг. Хөшөөн дээрх сийлбэр нь оройн хэсэг, дунд хэсэг, доод хэсэг гэсэн үндсэн гурван бүлэг дүрслэлээс бүрдэнэ.

Буган хөшөөг олонх судлаачид нас барсан хүнд зориулсан дурсгал хэмээн үздэг төдийгүй бугын дүрсийг тухайн овог аймгийн шүтлэг бишрэлтэй холбон тайлбарладаг. Хөшөөний дунд хэсэгт бугыг онцгойлон дүрсэлсэн байдгаараа онцлог юм.

Буган хөшөө нь нас барсан хүнд зориулсан дурсгал гэдэг нь нэгэнт тодорхой ч хөшөөний эздийнх нь оршуулга хаана байна вэ? гэсэн асуудал хөндөгддөг. Гэвч үүнийг тодруулахад хангалттай баримт, хэрэглэгдэхүүн хараахан цугларч амжаагүй ч буган хөшөөний хажууд орших хиргисүүрт уг хөшөөний эзнийг оршуулсан байх магадлалтай хэмээн таамаглаж болно. Нүүдэлчид үхэгсдийн сүнс тэнгэрт очдог гэдэгт итгэж түүний дараагийн амьдралдаа хэрэглэх зүйлсийг булш, оршуулганд дагалдуулсан байдаг. Одоогоор Монгол нутгаас илэрсэн эртний булш, оршуулгын нийтлэг нь өөд болоочийг газарт



булж оршуулах зан үйл юм. Гэвч булш, оршуулгын дурсгалыг тухайн үеийн хүн амын талаархи судалгаатай харьцуулахад маш цөөн тоотой байгаа нь зарим талаар эргэлзээ төрүүлдэг. Эндээс харахад магадгүй зарим тохиолдолд нас барагчийг газарт булалгүй, түүний оронд хөшөө босгох уламжлал байсан хэмээн таамаглаж болох бөгөөд үүний нэг жишээ нь буган хөшөө байж болох юм.



Буган хөшөө, түүний дүр, дүрслэл

Нүүдэлчдийн булш оршуулганд ихэвчлэн нас барсан эрэгтэй хүнд зэр зэвсгийн зүйлс дагалдуулсан байдаг тул буган хөшөө нь эр хүнд

зориулсан дурсгал байж болох талтай. Оршуулганд дагалдуулсан зүйлсийг ихэвчлэн эвдэлж, зүсийг нь хувилгах буюу иж бүрдлээрээ байх зүйлсээс төлөөлөл болгож зарим хэсгийг нь дагалдуулсан байдаг. Ямар нэг эд зүйлийн дүрслэл (дүрс-зураг) нь мөн л тухайн зүйлийн төлөөлөл болдог. Иймээс буган хөшөөн дээрх дүрслэлийг дээрхтэй холбон таамаглаж болно. Хөшөөнөө дүрсэлсэн зүйлсийн дийлэнх нь хүрэл ба түрүү төмрийн үеийн булшнаас олдсон байдаг нь ийнхүү таамаглах нэгэн үндэслэл болж байна.

**Бугын дүрслэл.** Судлаачид буган хөшөөний бугын дүрслэлийг 1. Бодит байдалтай дүрсэлсэн, 2. Загварчлан дүрсэлсэн хэмээн 2 ангилан үзсэн байдгийн олонх нь загварчлан дүрсэлсэн байх бөгөөд цөөн тохиолдолд бодит байдлаар урласан байдаг.

Загварчилсан бугын дүрс бол буган хөшөөн дээрх хамгийн гол дүр ба дүрслэл юм. ХХ зууны эхэн хагасаас өнөөг хүртэл олон судлаачид буган хөшөөнөө дүрслэгдсэн буга болон бусад амьтдын дүрсний утга учрыг тайлах оролдлогуудыг хийсээр ирсэн. Гэвч өнөөдөр ч энэ асуудал нэг мөр шийдэгдээгүй гэж хэлж болно.

Монголын зарим эрдэмтэд буган хөшөөний бугын дүрсийг тайлбарлахдаа “Буга нь Төв Азийн нутагт өргөн тархсан арьс, мах, эвэр зэрэг ихээхэн бүтээгдэхүүн өгдөг, хүнд ямар нэгэн хор хөнөөлгүй амьтан учраас түүнийг эрт цагаас эрхэмлэн шүтэх болсон” хэмээн үзэж байхад зарим нь “эртний хүмүүс тухайн овгийнхоо шүтэж ирсэн тотемоос үүсэлтэй хэмээн үздэг байсан бол буган хөшөө нь түүнийг бүтээгчдийг сүлд буюу тэдгээр хүмүүс эрт цагт өөрсдийгөө бугаас гарсан гэж үзэж байсантай холбоотой” гэжээ. Түүнээс гадна буган хөшөөний буга болон бусад дүрслэлийг эртний хүмүүсийн бие дээрх шивээс хэмээн үзэх хандлага бас байдаг. Тэдгээр эрдэмтэд Алтайн мөнх цэвдэгт хадгалагдан үлдсэн Пазырыкийн булшнаас гарсан хүмүүсийн бие дээрх шивээстэй адилтган харьцуулан үздэг.



*Бугын дүрст хувцастай дайчны сэргээлт зураг*

Оросын судлаачдын хувьд буган хөшөөний буга болон бусад амьтдыг ихэнхдээ Индо-Иран овог, аймгуудын дунд байсан домгуудад үндэслэн буга, адуу зэрэг амьтдыг нарны шүтлэгтэй холбон тайлбарладаг. Түүнчлэн скифүүдийн дунд өргөн дэлгэр байсан амьтны загварт урлагийн нөлөө хэмээн үздэг судлаачид олон бий. Хэдий тийм боловч буган хөшөөний соёлын холбогдох он цаг нь Скифийн соёлоос даруй хэдэн зуун жилээр эрт үед хамаарах нь сүүлийн үеийн судалгаанаас илэрхий болж байна. Үүнээс үзэхэд скифийн амьтны загварт урлаг буган хөшөөний амьтны загварт урлагт нөлөөлсөн биш харин яг эсрэгээр буган хөшөөнийн соёлоос амьтны загварт урлаг үүссэн тухай ярих үндэслэлтэй болж байгаа юм.

Ер нь буган хөшөөний буга болон бусад амьтдын дүрсний утга агуулга нь эртний шүтлэг, зан үйлийн илэрхийлэл болох тул бөө мөргөлийн зарим ойлголттой холбоотой болох талаар зарим

судлаачид авч үзсэн байдаг. Бугыг хөлөө нугалан тэнгэрт дүүлэн нисэж буй мэтээр дүрсэлсэн нь тухайн нас барсан хүний сүнсийг тэнгэрт гаргаж байна гэсэн бэлгэдлийг агуулж байгаа бололтой. Энэ нь бөө мөргөлд бугыг онцгойлон авч үздэгтэй холбоотойгоор тайлбарлагдана. Тухайлбал, буга, согооны арьсаар хэнгэргээ хийж, түүний толион дээр тэдгээр амьтдаа дүрслэх нь бий бөгөөд буга нь их онгодын унаа болдог ажээ.

Буган хөшөөг нас барсан хүнд зориулсан дурсгал хэмээх тайлбарыг эш болгон төсөөлвөл хөшөөнөө дүрслэгдсэн буга нь сүнсний унаа бололтой. Хожмын хүннү нарын булш оршуулга, ялангуяа язгууртны булшнаас буга төдийгүй луу, бэлгэт гөрөөс, сарлаг мэт домог (тэнгэр)-ийн амьтны дүрслэл бүхий чимэглэл цөөнгүй олдсон байдаг. Тэдгээр нь оршуулганд дагалдуулсан тэрэгний худрага, хөмөлдрөгний чимэглэл болох ба тэнгэрт буйгаар дүрсэлсэн нь нас барсан язгууртныг эгэл хүнээс ангид, тэнгэр гаралтайн илэрхийлэл болохоос гадна түүний сүнсийг тэнгэрт гарахад хамгаалах бэлгэдэлтэй холбоотой байсан бололтой. Энэ нь буган хөшөөнөө бугыг шувуу мэт халин нисч буйгаар урладаг байсан шүтлэгийн уламжлал байж болох юм.

Буган хөшөөдөд бугыг 3 янзын байрлалаар дүрслэн үзүүлсэн байдаг.

- Үүнд: 1. Дээшээ тэмүүлж буй байдалтайгаар
2. Хөшөөг цагариглан ороосон байдалтайгаар
3. Доошоо чиглэсэн байдалтайгаар дүрслэн үзүүлсэн байдаг.


Энэхүү 3 янзын байрлалаар дүрслэн үзүүлсэн нь тухайн буган хөшөөний эзний сүнс очих газрыг төлөөлөн үзүүлсэн бололтой. Үүнийг тодруулбал, 1-р байрлал дахь буганууд нас барагчийн сүнсийг тэнгэр рүү авч явж байгаа, 2-р байрлал дахь буганууд тухайн нас барагчийн сүнс эргэн төрнө гэсэн санааг, харин 3-р байрлал

дахь буганууд тухайн нас барагчийн сүнсийг дээш дэгдээхгүй эх дэлхийн гүн рүү шингээж байгаа гэсэн байдлаар дүрсэлсэн байж болох юм.

Нүүдэлчдийн булш оршуулганд нас барагчийг ихэвчлэн тэнгэр өөд дээш харуулан тавих нь нийтлэг ба энэ нь түүний сүнсийг дээш дэгдээж буй бэлгэдэлтэй холбоотой юм. Мөн зарим нэг онцгой тохиолдолд түрүүлгэ нь харуулан оршуулах явдал байх бөгөөд энэ нь амьд ахуйдаа муу үйл хийсэн хүний сүнсийг дээш дэгдэхээс сэргийлж буй явдал хэмээн таамагладаг. Гэтэл зарим буган хөшөөнд дээрх бугын байрлалууд давхцан орсон тохиолдлууд бий. Үүнийг сүнс хэрхэн дэгдэж буй үйл явцыг дүрсэлсэн хэмээн таамаглаж болно.

**Амьтдын дүрслэл.** Буган хөшөөний хамгийн гол дүр, дүрслэлийн нэг нь бол ан амьтад юм. Тэдгээр амьтдыг төрөл зүйлээр нь туурайтан, араатан, жигүүртэн, загас ба мэлхий хэмээн ангилан авч үзэж болно.

Буган хөшөөнд хамгийн олон тоогоор дүрслэгдсэн амьтан бол буга, түүний дараа адуу орно. Адууны дараа гахай, янгир, муурын



Буган хөшөөнөө бугыг дүрслэн үзүүлсэн байдал

© J.Magaii

төрлийн араатан амьтад орохын зэрэгцээ нэлээд олон тохиолддог бол шувуу, мэлхий, загас, үхэр зэрэг амьтдын дүр маш ховор тохиолдоно. Үүнээс гадна үл танигдах домгийн амьтад цөөн тоотой ч тааралдана. Тодорхойлж болохуйц амьтдыг ихэнхдээ бодит байдалтай нь ойр дөхөм дүрсэлсэн байдаг.

Адуу. Адуу бол буган хөшөөнд бугын дараа хамгийн олон тоогоор дүрслэгдсэн амьтан бөгөөд нүүдэлчдийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд чухал үүрэг гүйцэтгэхийн сацуу нөгөө талаар тэдний оюун санаа, шүтлэгийн ухамсарт гүн ул мөрөө үлдээжээ. Тиймээс ч Төв Азийн ард түмнүүдийн үлгэр, туульс, бөө мөргөлийн үзэл санаанд адууны тухай арвин баялаг зүйлс уламжлагдан үлдсэн байдаг.

Адууг зогсож буй болон давхиж яваа байдалтайгаар хөшөөний дунд, доод хэсэгт дүрслэхдээ биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих болон бүх талбайгаар нь хонхойлон цохих гэсэн хоёр өөр арга ашигласан байдаг.

Оросын судлаач Н.Л.Членова “Олени, кони и копыта” хэмээх илтгэлдээ В.В.Волковын “Оленные камни Монголии” бүтээлд орсон буган хөшөөдөөс “Монгол-Өвөр Байгал”, “Саян-Алтай” болон холимог төрлийн 16 хөшөөнд 40 адууны дүрс байна. Тэдгээр хөшөөнд хоёр өөр үүлдрийн буюу нэг нь жижиг биетэй, богино хөл, бүдүүн хүзүүтэй адуу, нөгөө нь өндөр зэгзгэр биетэй, урт хөл, нарийн урт хүзүүтэй адуу дүрсэлжээ. Ингэхдээ тэдгээрийг нэг бол зогсож буй байдалтай, нэг бол хөлөө эвхсэн байдалтай сийлсэн байна. Хөлөө эвхсэн байдалтай дүрсэлсэн адуунууд Ордосын хүрэл эдлэлүүдтэй тун төстэй төдийгүй Монгол, Тува, Алтайн адууны дүрслэлүүдтэй адил төстэй юм. Харин өндөр зэгзгэр биетэй адуунууд Минусын хотгорын тагарын үед холбогдуулан үздэг адууны дүрслэлүүдтэй адил төстэй байна (2000: 90-106, рис. 4-7) хэмээжээ.



Харин бид буган хөшөөн дээрх адууг ингэж үүлдрээр нь ялгаж үзэхээсээ илүү тэдгээрийг дүрсэлсэн сийлбэрч нарын ур чадвар, дүрслэлийн арга барилтай шууд холбоотой болов уу хэмээн үзэж байна.

Адууг ихэвчлэн загварчилсан бугатай хамт дүрсэлсэн байх бөгөөд бугаас жижиг хэмжээтэй дүрсэлжээ. Харин том хэмжээтэй дүрсэлсэн нь Архангайн Ихтамир сумын Алтансандал уул, Хөвсгөлийн Галт сумын Зүүн Хөөнгө зэрэг газарт байна. Мөн адууг хамгийн олон тоотой буюу 24 адуу дүрсэлсэн хөшөө Хөвсгөлийн Цагаан-Уул сумын Хөшөөтийн гол, 17 адуу дүрсэлсэн хөшөө Галт сумын Зүүн Хөөнгө, 7 адуу дүрсэлсэн хөшөө Улаанбаатар хотын музейд тус тус бий.

*Гахай.* Буган хөшөөнөө дүрслэгдсэн өөр нэг амьтан бол зэрлэг гахай юм. Гахайг буган хөшөөнд дүрслэхдээ өргөн том цээжтэй, богинохон моодгор биетэй, зэтгэр хамартай, богинохон сүүлтэй, босоо соотон чихтэй, толгойгоо ихэнхдээ тонгойж газарт хүргэсэн, зогсоо байдалтай цөөн тохиолдолд давхиж буйгаар дүрсэлсэн байдаг бөгөөд түүний дүрслэлийн утга агуулгыг газрын шүтлэгтэй холбоотой хэмээн үзэхийн сацуу бөө мөргөлийн үзэлд уул, газар дэлхийн эзэн сахиус, түүний туслагч, хамгаалагч дүр хэмээн тайлбарладаг.

*Янгир.* Янгир бол буган хөшөө төдийгүй хүрлийн үеийн хадны зурагт үй олноороо дүрслэгдсэн амьтан юм. Янгир нь дүрслэх урлагийн нэгэн том төлөөлөл болохоос гадна хүмүүсийн оюун санаа, сүсэг бишрэлд тодорхой байр суурь эзэлж байсныг хөшөө чулуу, хадны зурагт дүрслэгдсэн янгирын дүрсээс тодорхой харж болно. Буган хөшөөнд янгирыг дүрслэхдээ ихэвчлэн бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн байхаас гадна цөөн тохиолдолд биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих аргыг хэрэглэсэн байдаг. Биеийн ерөнхий

төрх нь бодит байдалтайгаа дөхүү байхаас гадна адуу мэт биетэй, дүрлэгэр дугуй нүдтэй, босоо соотон чихтэй, богинохон босоо сүүлтэй, заримдаа бүр сүүл, чихийг огт дүрслээгүй зэрэг харилцан адилгүй төрх байдалтай дүрсэлсэн нь ч тохиолддог.

*Муурын овгийн амьтад.* Муурын овгийн эрээн алаг, эсвэл цоохор зүстэй, соотгор чихтэй, урт сүүлтэй амьтдын дүрс буган хөшөөнөө цөөнгүй дүрслэгдсэн байдаг. Эдгээр амьтдыг буган хөшөөнд дүрслэхдээ өөр хоорондоо харилцан адилгүй төрхтэй, ямар нэгэн тогтсон орон зайд бус бусад амьтдын завсар, аль эсвэл дээд хэсэгт, бугын эврийн салаан завсар, заримдаа бүсний дор дүрсэлсэн байдаг. Заримдаа эл амьтдыг хурц сарвуутай дүрсэлсэн байхад зарим тохиолдолд сарвууг тодотгон гаргалгүй дүрсэлсэн нь ч бий.

Тэдгээр амьтдын биеийн тэгийг ихэвчлэн хөвөөлөн гаргаж, эрээн зүсийг хэвтээ тагнай хэлбэрийн товгор зураасуудаар, цоохор зүсийг жижиг дугуй хонхоруудаар урлан сийлдэг бол цөөн тооны хөшөөнд бүх талбайгаар нь хонхойлгон цохиж гаргасан байдаг. Төв Азийн түрүү үеийн нүүдэлчдийн дунд муур шүтэх үзэл хомс бөгөөд харин муурын овгийн амьтад болох барс, ирвэс, шилүүсийг хүндэтгэн үзэх үзэл бий болсныг хүрлийн үеийн археологийн олдворуудаас харж болно. Буган хөшөөнд дүрсэлсэн муурын овгийн эдгээр амьтдын язгуур үзэл санаа чухам юу болохыг тодорхойлох баримт хэрэглэгдэхүүн ховор хэдий ч түүнийг хамгаалах бэлгэдэлтэй холбоотой хэмээн үздэг.

*Загасны дүрслэл.* Буган хөшөөнд загас дүрсэлсэн хоёр тохиолдол бий. Түүний нэг нь Завхан аймгийн Загастайн давааны урд талд Саадаг хайрханы орчимд буй хос загасны дүрслэл бүхий хөшөө, нөгөө нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Сөртийн дэнж хэмээх газарт байгаа нэг загасны дүрслэл бүхий хөшөө болно. Загасны тухай өрнө, дорнын эртний ард түмнүүдийн ухамсар

ойлголтыг тоймлон үзвэл ертөнцийн эх үүсэл, гол мөрөн, далай тэнгисын эзэн савдаг, үржил, эмэгтэй хүн, эрч хүч, энх амгалан, эв нэгдлийн бэлгэдэл, мөн бөөгийн туслагч онгон болох зэрэг өргөн утга агуулгатай ажээ.

**Бусад дүр, дүрслэл.** Буган хөшөөд дээр дүрслэгдсэн ан амьтдаас бусад зүйлсийг төрөл зүйлээр нь хүн, тэнгэр эрхэс, гоёл чимэглэл, эд зүйлс, зэр зэвсгийн зүйлс хэмээн ангилан үзэж болно.

*Тэнгэр эрхэс.* Буган хөшөөний дээд хэсэгт дүрслэгдсэн том, жижиг цагариганы дүрсийг зарим судлаачид нар, сар, нөгөө хэсэг нь ээмэгний дүрслэл хэмээн тайлбарладаг. Харин хөшөөний дунд хэсэгт дүрсэлсэн дугуйг хүрэл толь гэж үздэг. Цагаригийг нэг бол хүрээг нь нарийн зураасаар эсвэл бүх талбайгаар нь хонхойлон цохисон байдалтайгаар үзүүлсэн байхаас гадна хоёр янзаар дүрсэлсэн ч тохиолддог. Үүнд: 1. Дан цагариг, 2. Унжлагатай цагариг болно.

Буган хөшөөг нас барсан хүнд зориулсан дурсгал, дүүлэн нисэж буй мэт байдалтай урласан буга нь хүний сүнсийг тэнгэрт гаргах хөлөг хэмээн үзвэл хөшөөний оройд байх дугариг дүрс нь тэнгэрийг бэлгэдсэн зүйлс байж болох тухай таамаглалтай бид санал нэг байна. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушигийн өвөр хэмээх газраас илрүүлсэн хүний нүүрний дүрс бүхий буган хөшөөний чихэнд хоёр салаа унжлагатай цагариган хэлбэрийн ээмэг зүүлгэн дүрсэлсэн нь энэхүү цагаригийн дүрсийг ээмэг болохыг баталдаг. Гэвч гагц дээрх хөшөөнд дүрслэгдсэнийг эш болгон цагариг болгоныг ээмэг хэмээн тайлбарлах боломжгүй мэт санагдана. Харин хоёр салаа унжлагатай цагаригуудыг ээмэг хэмээн үзэж болно. Мөн түүний хажуу дахь том жижиг цагаригаар нар, сар (тэнгэр эрхэс)-ыг дүрсэлсэн бололтой.

*Ташуу зураас.* Буган хөшөөний нарийн талын дээд хэсэгт нэгээс тав

хүртэл ташуу зураас дүрслэгдсэн байдаг. Монгол-Өвөр Байгалын хэлбэр төрхийн буган хөшөөдөд ташуу зураас дүрслэгдсэн нь ховор тохиолддог ба Хиргисүүрийн дэнж, Хөшөөтийн буган хөшөөдөд дүрслэгдсэн нь бий. Харин хоёр ба гурван зэрэгцээ ташуу зураас ихэвчлэн Баруун Монгол, Тува, Алтай түүнээс цааш Европын бүс нутаг дахь Саян-Алтай болон Евразийн хэлбэр төрхийн хөшөөдөд нийтлэг дүрслэгддэг. Үүнээс гадна Алтай, Өмнөд Тува, Баруун Монголд дөрөв ба таван ташуу зураас бүхий буган хөшөөд ч олдсон байдаг.

Энэхүү ташуу зураасыг судлаачид оддын бэлгэдэл, хүний нүүрний эрхтнүүдийн бүдүүвч дүрс, шивээс буюу будаг хэмээн янз бүрээр тайлбарладаг. Судлаач Д.Анхбаярын "3 зураас шивээс нь 3 ертөнцийн тухай ойлголт ба өөрөөр хэлбэл муу сүнс чөтгөрүүд доод ертөнцөд байдаг бөгөөд биднийх нь дунд ертөнц, нас барж байгаа хүмүүс дээд ертөнцөд одож өвөг дээдсийн сүнстэй нийлдэг хэмээх ойлголт эртний хүмүүст байсан бөгөөд үүгээр дамжин төрөх, амьдрах, үхэх хэмээх 3 хэмжээсийн тухай ойлголтыг илэрхийлсэн байж болохоос гадна ерөөс гурвын тоог эрхэмлэх үзэл энэ үед хэлбэршсэн бололтой" хэмээх саналыг бид дэмжиж байна. Харин дөрөв, таван зэрэгцээ ташуу зураасыг зарим судлаачид бөө мөргөлтэй холбон үзэх санал дэвшүүлсэн нь бий.

*Гоёл чимэглэлийн зүйлс.* Буган хөшөөнд дүрслэгдсэн гоёл чимэглэлийн зүйлсийн тоонд хүзүүний зүүлт, ээмэг, толь зэргийг хамруулан авч үзэж болно.

*Зүүлт.* Буган хөшөөнд хүзүүний зүүлтийг хэд хэдэн янзаар дүрсэлсэн байдаг. Тухайлбал, Баруун Монголын "Еврази"-ийн хэлбэр төрхийн буган хөшөөдөд хоорондоо бага зэрэг зайтай дугуй, зууван дугуй хэлбэрийн хонхорууд, хонхоруудыг хооронд нь нарийн зураасаар холбосон, дугуй хонхороор эхлүүлээд үргэлжлүүлэн

шулуун өргөн зураасаар болон нарийн зураасаар холбосон, эсвэл тэр чигээр нь шулуун зураасаар гаргаж дүрсэлсэн байдаг. Хүзүүний чимэг сондорыг эрт үеэс хүмүүс гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглахаас гадна өөрсдийн биеийг ямар нэгэн муу зүйлээс хамгаалж байдаг шүтлэг бишрэл, бэлгэдэлтэй холбон үзэж иржээ.

*Толь.* Буган хөшөөнөө толийг хөшөөний дээд, дунд, доод хэсэгт дүрсэлдэг. Нүүдэлчид толийг гоёл чимэглэл болон зан үйлийн зориулалтаар эдлэж хэрэглэж иржээ. Тухайлбал, Хүннүгийн язгууртан болон жирийн иргэдийн булш оршуулгаас хүрэл толины хагархай элбэг олддог. Толийг ийнхүү булшинд хагалж хийх нь Хүннү нарын ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг бишрэл-хойд насны тухай ойлголттой холбоотой ба толь дагалдуулах ёс дундад зууны монголчуудад мөн уламжлагдахдаа гол төлөв эмэгтэй хүний оршуулгад дагалдуулдаг байжээ. Орчин цагийн монголчуудын дунд эмэгтэй хүний шарилыг дагалдуулж толь хийдэг ёс мөн бий. Тэгэхдээ уг толинд хайртай эд зүйлсийнх нь дүрсийг тусгаж хайрцаганд хийдэг ажээ. Үүнээс үзвэл толь бол дангаараа оршуулгын эд өлөг болохын зэрэгцээ бусад эд зүйлсийг төлөөлж агуулах нэгэн зүйлийн онцгой эд өлөг мөн юм.

*Зэр зэвсгийн дүрслэл.* Буган хөшөөнд нум сум, саадаг, байлдааны сүх, зээтүү, төрөл бүрийн чичлүүр хутга, хутга, билүү, “П” хэлбэрийн дэгээ, ооль, бамбай зэрэг дүрслэгдсэн байх бөгөөд тэдгээрийн ихэнхийг бүснээс зүүсэн байдалтайгаар сийлдэг боловч зарим тохиолдолд бүснээс дээш амьтдын дүрсний дунд, мөн бүснээс доош дүрсэлсэн ч бий.

Буган хөшөөн дээрх зэр зэвсгүүд тэдгээрийн төрлүүд нь Монгол болон хөрш зэргэлдээ бүс нутгийн археологийн дурсгалуудаас бодитоор олддог. Зэр зэвсгийн олонх нь Өмнөд Сибирийн Карасукын соёлын (НТӨ XIII-VII зуун) болон Умард Хятадын тухайн

үеийн соёлын олдворуудтай ижил төстэй болохыг судлаачид тогтоосон байдаг.

Буган хөшөөдөд дүрслэгдсэн зэр зэвсгийн зүйлсийг доорх байдлаар ангилан үзэж болно. Үүнд:

Довтолгооны зэвсэг

- Алсын тусгалтай зэвсэг – Нум сум
- Ойрын зайн зэвсэг
- Чичлүүр хутга, хутга, жад, зээтүү, сүх, ооль, гүйвэр\*

Хамгаалалтын хэрэгсэл

- Дуулга, хуяг, бамбай, бүс Бусад дагалдах хэрэгсэл
- Саадаг, дэгээ, билүү зэрэг зүйлс болно.

### **Өвөрмөц дүрслэлүүд**

Сүүлийн үеийн судалгаагаар өвөрмөц сонин дүрслэл бүхий буган хөшөөд хэд хэд олдож байгаа нь судлаачдын сонирхолыг нэлээд татаж байна. Тухайлбал, Хөвсгөлийн Төмөрбулаг сумын нутаг Зуны голын 6-7 төрлийн ан амьтан, зэр зэвсгийн дүрслэл бүхий хөшөө, Архангайн Ихтамир сумын нутаг Улаан толгойн баруун бэлийн хоёр хүн дүрсэлсэн хөшөө, мөн тус сумын нутаг Хавцалын амны гүйвэр зэвсгийг бодит хэмжээгээр нь дүрсэлсэн хөшөө, Увсын Зүүнхангай сумын нутаг Бүлцэнгийн үзүүрийн хөшөөнд морин тэрэг дүрсэлсэн зэргийг дурдаж болно.


*Шувуу, мэлхийн дүрслэл.* Энэхүү хөшөө нь гурван талдаа сийлбэртэй бөгөөд тэнд соёо бүхий зүүлт, буга, согоо, гахай, араатан, толь, чинжаал хутга, таван талт бамбай, бүс, сүх зэргийн дүрслэлтэй. Хөшөөн дээрх буга, араатнуудаас бусад нь их бодитой дүрслэгдсэн

---

\* *Тайлбар толиудад “Урт охор хоёр модны хооронд гархи хэлхэн шалам хадаж сажин жанчихуйг нь Гүйвэр (gyuibyr) хэмээмүй” (Сумъяабаатар 2005: 272) мөн “Чулуу зэрэг бөөрөнхийвтэр зүйлийг үсэргэн шидэх зэвсэг, дүүгүүр” (Монгол хэлний ... 2008: АВГ, 565) гэх зэргээр тайлбарлажээ. Иймээс бид дээрх тайлбаруудыг үндэслэн Гүйвэр хэмээх нэрийг хэрэглэв.*



бөгөөд согоо, мэлхий болон гахайн биеийн харьцаа, соёо, сүүл зэргийг тод томруун гаргаж өгсний сацуу өөр хоорондоо тэмцэлдэж буй байдлыг харуулжээ. Шувуу, мэлхийн дүрс анх удаа буган хөшөөн дээрээс олдож байгаагаараа онцлог ба эдгээр нь хөшөөний баруун болон зүүн хажуугийн хамгийн дээд талд ихэнх буган хөшөөний нар, сар, ээмэг сийлдэг хэсэгт дүрслэгдсэн байна. Энэхүү байрлалыг өрнө, дорнын эртний үзэл санаанд тулгуурлан үзвэл нар, сарны бэлгэдэл байж болох юм.



Монгол-Өвөр Байгалын хэлбэр төрхийн буган хөшөөн дээрх зарим зэр зэвсгийн дүрслэлийн харьцуулалт.  
© J. Magail

Өөрөөр хэлбэл наран ургах үүрээр шувуудын жиргээнээр өглөө, өдөр эхэлж, саран ургах бүрийгээр мэлхий дуугарч харанхуй шөнө болдог байгалийн үзэгдэл, түүгээр ч зогсохгүй үхэх, төрөх амьдралын жамыг ч давхар илэрхийлсэн сэтгэлгээний биежсэн хувилбар байж болно. Гэхдээ энэ үзэл санаа Төв Азийн өндөрлөгийн нүүдэлчдийн оюун сэтгэлгээнд эртнээс нааш уламжлагдан ирсэн үү аль эсвэл өрнө, дорнын их нүүдэл шилжилт хөдөлгөөний үр дүнд бий болсон уу гэдэг нь анхаарууштай асуулт юм.

**Хүний дүрслэл.** Хоёр хүний дүр бүхий энэхүү буган хөшөө нь Улаан толгойн баруун бэлд орших дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн баруун урд талд тахилгын байгууламжуудын хамт байрлана. Хөшөөн дээрх хүний дүрээс бусад нь буган хөшөөнд түгээмэл дүрслэгддэг буга, янгир, зэр зэвсгийн дүрслэлүүд юм. Хөшөөний өргөн талын зүүн доод хэсэгт тулалдаж буй хоёр хүнийг эсрэг (дээш, доош) харуулан урлажээ. Шил рүүгээ унжсан сэртгэр бүхий малгай (дуулга?)-тай, нэг гараа сул орхиж нөгөө гартаа үзүүр хэсэгтээ том бөмбөлөг бүхий бүдүүн иштэй зэвсэг барин довтолж буй хүнийг доош харуулан дүрсэлжээ. Түүний эсрэг талд толгойдоо бүрх мэт малгайтай (?), нуруундаа ямар нэг зүйл үүрч, хагас суусан дайчныг дүрсэлсэн ба тэрээр хоёр гараараа нөгөө хүний цохиж байгаа зүйлээс хамгаалж буй байдалтай ажээ.

Дээрх дайчны барьсан зэвсэг нь доор өгүүлэх буган хөшөөнөө бодит байдлаар дүрсэлсэн гүйвэр хэмээх зэвсэгтэй ихээхэн төстэй юм. Монгол нутгаас ийм төрлийн зэвсэг биетээр олдож байгаагүй боловч хүрэл, түрүү төмрийн үеийн хадны зурагт гүйвэрийн төрөл болох бялуу хэмээх зэвсэг цөөнгүй тохиолддог. Тухайлбал, Монгол Алтайн Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зургуудад нум сумтай анчин бүснээсээ зүүсэн, эсвэл гартаа бариад зогсож байгаа эсвэл ан амьтныг цохиж агнаж байгаагаар дүрсэлсэн байдаг.




*Шуеуу, мэлхий, араатан ан амьтад, зэр зэвсэг дүрсэлсэн хөшөө,  
Зуны гол, Төмөрбулаг, Хөвсгөл.*

© Ж.Баярсайхан

*Гүйвэр.* Хойд Тамирын голын хөндийн Хавцалын амны 41-р буган хөшөөнөө энэхүү зэвсгийг дүрсэлсэн байна. Уг зэвсэгтэй төстэй зэвсэг Уушгийн өврийн 8-р буган хөшөөнөө нэг дүрслэгджээ. Энэхүү зэвсэг нь урт иштэй, гурван шовх өргөстэй бөмбөлөг хэлбэрт цохилуур, тэдгээрийг холбосон холбоос зэргээс бүрдэнэ. Гүйвэр зэвсгийг Сяньби, Тоба болон Эртний Хятадын Хан улсын цэрэгт, мөн хожим VIII-X зууны үед Зүүн Европын нүүдэлчид, X-XIV зууны үед Монголын армид, XIII зууны үед Баруун Европт өргөнөөр хэрэглэж байв. Ийнхүү түүхийн урт удаан хугацааны турш олон газар оронд ашиглаж байсан гүйвэрийн ишийг мод, ясаар, харин цохилуурыг


олон янзын хэлбэр төрхтэйгээр, төрөл бүрийн материалаар хийж сур, олс, гинж зэргээр холбож бүтээдэг байжээ.



Хоёр хүн дүрсэлсэн буган хөшөө. Улаан толгойн баруун бэл, Ихтамир, Архангай.  
© Ж.Гантулга

Хүннүгийн зэр зэвсгийн зүйлс дотор ийм төрлийн зэвсэг тохиолдож байгаагүй боловч гүйвэрийн цохилуур бөмбөлөгтэй адил голыг нь нүхэлсэн хүрэл бөмбөлөг хэлбэртэй зэвсгийг Гол модны язгууртны 20-р булшнаас илрүүлэн олсон байна.

Харин буган хөшөөнөө гүйвэрийг бодитоор дүрсэлсэн байгаа нь өгүүлэн буй зэвсгийг Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүрэл зэвсгийн сүүл үеэс хэрэглэж байсны баримт болох юм.



*Буган хөшөөнөө дүрслэгдсэн гүйвэр зэвсэг*

*а. Хавцалын ам, Ихтамир, Архангай*

*б. Уушигийн өвөр, Бүрэнтогтох, Хөвсгөл*

*© Ж.Гантулга © В.В.Волков*

## **БУГАН ХӨШӨӨНИЙ ТАХИЛГЫН БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЗАН ҮЙЛИЙН УЧИР ХОЛБОГДОЛ**

Буган хөшөөний тахилгын цогцолбор үндсэндээ хоёр янзын байдалтай оршино. Үүнд: Нэгдүгээрт, буган хөшөө нь өргөн талбайг эзэлсэн дөрвөлжиндүү хэлбэртэй, овгор чулуун байгууламжийн дунд болон захад байрлах ба цагирган хэлбэрийн тахилгын байгууламжууд гадуур нь хүрээлсэн байдлаар оршино.

Хоёрдугаарт, буган хөшөө нь ганц нэгээс хэдэн арваараа цувран байрлах битүү чулуун дарааст, цагирган хэлбэрийн чулуун дарааст гэсэн хоёр төрлийн тахилгын байгууламжуудын голд.

Аливаа тахилгын зан үйл нь тухайн үеийн хүмүүсийн шүтлэг бишрэл, эрхлэх аж ахуй, ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой байдаг. Буган хөшөөний дээрх хоёр төрлийн тахилгын байгууламжид хоёр өөр хэлбэрээр тахилгын зан үйл гүйцэтгэсэн байдаг.

Буган хөшөөний тахилгын байгууламжийн гадаад хэлбэрийн ялгаа нь тэдгээрийн тахилгын зан үйлийн ялгааг давхар илтгэдэг. Тухайлбал, адууны толгой, хүзүү, туурайгаар тахилга өргөх нь: Нэгд, уг адууг хөшөөний эзний хойд насны хүлэг болгох, Хоёрт, хөшөөний




эзний “сүнс дэгдээх” зан үйлийн зориулалттай байж болох юм. Харин шатаасан яс бүхий тахилгын байгууламж нь хөшөөний эзэнд зориулан өргөсөн зоог шүүсийг агуулсан бололтой. Энэхүү яс, мах шатааж тахилга хийх зан үйл хожмын нүүдэлчдэд янз бүрийн хэлбэрээр уламжлагдан үлдсэнийг хэд хэдэн жишээнээс харж болно. Тухайлбал, хүннүчүүд язгууртнуудаа оршуулаад булшных нь хойд талд хэд хэдэн эгнээ хос чулуу байрлуулж, түүнийхээ дунд гал түлж, яс, мах шатаадаг байсан, мөн Юань Улсын үед “жил бүрийн 9 буюу 12-р сарын 26-наас хойш Шатаалгын сүмд ... их тахилга хийх ба Монголын нэг түшмэл хариуцан газар ухаж, нүх малтуулаад дотор нь гал түлж, мах шатааж, архи, айраг цацаж бөөлүүлж ёслол гүйцэтгэдэг” байжээ.



*Зураг 14. Жаргалантын амны буган хөшөөний тахилгын цогцолбор, Өндөр-Улаан, Архангай.*

© J. Magail






*Улаан толгойн буган хөшөөний тахилгын цогцолбор,  
Ихтамир, Архангай.*  
© Ж.Гантулга

Ер нь буган хөшөө, хиргисүүрийн тахилгын байгууламжид адууны толгой, хүзүү, туурай тавих зан үйл хожмын нүүдэлчдэд уламжлагдсаныг судалгааны хэрэглэгдэхүүнээс харж болно. Жишээ нь, Хүннүгийн жирийн иргэдийн булшинд эрэгтэй хүний булшнаас адууны яс хамгийн олон тоогоор олдсон ба ихэнх тохиолдолд толгой, эрүү, хүзүү, богино хавирга, сүүл, туурай тагалцагны яс, мөн арьс ширээр бүхэл адууг төлөөлүүлэн тавьсан байдаг. Мөн Түрэгийн булш оршуулгаас бүхэл бүтэн адуу, мөн түүний эдлэл хэрэглэл олон тоогоор олддог нь дээрх уламжлалын бас нэг жишээ юм.

## БУГАН ХӨШӨӨНИЙ ОН ЦАГ

Буган хөшөөний судалгаа эхэлсэн XX зууны эхэн үеэс 1970-аад оны эхэн хүртэл түүний он цагийг нэлээд хожуу үед тухайлбал скифийн үе (НТӨ VIII-III зуун) гэхчилэн баримжаалж байсан юм.



*Буган хөшөөний хоёр төрлийн тахилгын байгууламж,  
тэдгээрийн тахилгын зан үйл. © Ж.Гантулга*

- а. Битүү чулуун дарааст тахилгын улуун дарааст байгууламж*
- б. Цагирган хэлбэрийн ч тахилгын байгууламж*
- в. Адууны толгой*
- г. Шатсан ясны үлдэгдэл*

Буган хөшөөдийн он цагийг тогтоохыг оролдож, нэлээд зөрөөтэй саналууд гараад байсан 1970-аад онд Зөвлөлтийн археологч Л.Р. Кызласов үүссэн асуудлыг шийдэхийн тулд “Илүү их малтах хэрэгтэй” гэж товч тодорхой зорилт дэвшүүлж байсан билээ. Энэ зорилт дөнгөж саяханаас Монголд биелэгдэж их хэмжээний малтлагын үр дүнд, түүний он цагийг баттай тогтоох хэрэглэгдэхүүн

бий болсон нь судалгааны том амжилт мөн юм. Гэхдээ дан ганц хэрэглэгдэхүүн цуглах төдий бус арга зүй болон хандлагын томоохон дэвшил чухал нөлөө үзүүлснийг тэмдэглэх нь зүйтэй.

Буган хөшөөний үүссэн цаг хугацааг “харьцангуй он цаг”-аар буюу түүний дээр сийлж дүрсэлсэн эд зүйлсийг нь археологийн бодит олдвортой харьцуулах аргаар тогтоох аргыг нэлээд түгээмэл хэрэглэж байжээ. 1975 онд В.В. Волков, Э.А. Новгородова нар Уушигийн өвөрийн буган хөшөөдийг илрүүлэн судалж, түүний дээр дүрсэлсэн зэвсэг багажийг Минусийн хотгорын хожуу хүрлийн үеийн Карасукын соёлд хамаарах бодит зэвсэг багажтай харьцуулан он цаг нь төсөөлж байснаас хавьгүй эрт байж болох тухай санал дэвшүүлсэн байдаг. Мөн М.П.Грязнов, М.Х.Манай-Оол нар Аржаны булшны хэрэглэгдэхүүнд тулгуурлан буган хөшөөнд НТӨ XII-IX зууны зарим дүрслэл бий тухай дурдсан нь анх НТӨ II мянганы давуулсан явдал байв. Харин Д.Цэвээндорж Монголын судлаачдаас анх буган хөшөөг НТӨ II мянганаас эхлүүлэн он цагийг нь тогтоосон юм.

Буган хөшөөд скифийн үеэс өмнө ч холбогдож болох тухай энэхүү нэлээд үндэслэл сайтай санал нийт судлаачдын өчүүхэн бага дэмжлэг авч ирсэн нь харамсалтай. Оросын судлаачдын дунд өнөөг хүртэл буган хөшөөг скифийн үед хамааруулан үзэх онол хүчтэй хэвээр байна. Гэтэл харьцангуй он цагийн хүрээнд наад зах нь хожуу хүрлийн үед хамгийн анхны буган хөшөөд бүтээгдсэн болохыг тогтоогоод байгаа билээ. Ийм нөхцөлд буган хөшөөний он цагийн талаарх маргааныг эцэслэх шийдвэртэй хариуг “үнэмлэхүй он цаг” буюу он цаг тогтоох физикийн аргууд өгч чадах юм.

Өнөөгийн байдлаар буган хөшөөний тахилгын байгууламжид хийсэн радиокарбоны он цагууд үндсэндээ хиргисүүртэй адил буюу НТӨ XIII-VIII зуунд хамаарч байна. Энэ нь түүхэн үечлэлээр

бол хожуу хүрлийн үе болох юм. Энэ он цаг Төв Азийн нүүдэлчдийн “Амьтны загварт урлаг”-ийн үүслийн голомтыг Монгол нутгаас гарахгүй болохыг харуулж байгаагаар чухал ач холбогдолтой юм.

# ДӨРӨВ.

ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД



## ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

Одоогоос 50-40 мянган жилийн тэртээ орчин үеийн оюун ухаант хүний нийгэм бүрэлдэн бий болох үндэс сууриа тавьж хүй нэгдлийн байдалтай сүрэглэн амьдарч байсан гэдэг. Энэ үеэс л хүн гэгч амьтан өөрийнхөө тухай илүү танин мэдэх, ойлгоход анхаарч ирсэн хэмээн судлаачид үздэг хэдий ч энэ үеэс хэдэн зуун мянган жилийн өмнө буюу 300-500 мянган жилийн тэртээд холбогдуулан авч үздэг Мароккогийн Тан-Тан хотын орчмоос олдсон (Venus of Tan-Tan) хүн дүрст кварцит чулуун дүрс, мөн дунд палеолитын үед буюу 100 мянган жилийн тэртээд холбогдох Израилийн Голаны өндөрлөгөөс олдсон хүний дүрст болхи чулуун баримал (Venus of Berkhat Ram) хоёрыг хамгийн эртний хүн хэрэглэж байсан эсвэл магадгүй хүний гараар хийсэн хүн дүрст чулуун баримал хэмээн үздэг.

Харин үүний дараа буюу 35-40 мянган жилийн үед холбогдох Германы Хохленштейн- Стадель (Hohlenstein-Stadel) агуйгаас олдсон арслан зааны ясаар хийсэн “Арслан хүн”-ий баримал, мөн нэг он цагт хамаарагдах Германы Хөхл




*Германы Хөхл Фелсийн Шеллингений эмэгтэй хүний баримал*



Фелсийн Шеллингений (Venus of Hohle Fels) арслан зааны ясаар хийсэн эмэгтэй хүний баримал гэсэн хоёр ясан баримал нь оюун ухаант хүмүүсийн хийсэн анхны бүтээлүүд хэмээн тооцдог ажээ.

Дэлхий дээрх хамгийн эртний чулуугаар хийсэн хүн дүрс хөшөө бол НТӨ 9000 оны үед хамаарагдах Туркын зүүн өмнөд хэсэг, Балыклыгөлийн малтлагаас олдсон “Урфа хүн” юм. Энэхүү хөшөө нь 1,9 м орчим өндөртэй бөгөөд нүдний ухархайнд хар обсидиан суулгаж, хүзүүнд нь гурвалжин хэлбэрийн зүүлт эсвэл хувцасны энгэр дүрслээд хоёр гарын урдаа барьсан байдлаар бүтээжээ.

Одоогоос 35-11 мянган жилийн тэртээд холбогдох эмэгтэй хүний дүрст янз бүрийн хэлбэр, хэмжээ, дүрслэлтэй барималууд Австри, Чех, Франц, Словак, Орос, Швейцар зэрэг улсуудаас олдож байсан тухай археологийн эх хэрэглэгдэхүүнд байдаг бөгөөд тэдгээрийг эхийн эрхт ёсны улбааг харуулах баримт хэмээн судлаачид үздэг байна. Түүнээс хойш Египетийн Эртний Хаант улсаас Птолмейн хаант улс хүртэл (НТӨ XXV-I зуун) үргэлжилсэн уран барилга, Мезоамерикийн хамгийн эртний Олмекийн соёлд хамаарагдах чулуун хүний “том толгой” (НТӨ XVI-IV зуун), Энэтхэгийн буддын



*Германы арслан хүн*

түүхийн холбогдох чулуун баримал (НТӨ VII-VI зуун), Эртний Грекийн гантиг чулуун домогт барималууд (НТӨ XII-IX зуун), Ромын эзэнт гүрний биет хүнд зориулсан баримал (НТӨ VIII-НТV зуун), Хятадын Цин улсын Террасоттагийн армийн шавар баримал (НТӨ III зуун), Өмнөд Америкийн Сан Агустины хүн чулуун хөшөөд (НТ I-III зуун), Шинэ Зеаландын Полинезийн арал дахь аварга хүн чулууд (XII-XIV зуун) гээд дэлхийн өнцөг булан бүрт үе үеийн туршид гайхамшигт уран барималууд цэцэглэн хөгжиж байжээ.

Харин Монгол улсын нутаг дэвсгэр оршин тогтож байсан эртний овог аймаг, нүүдэлчид одоогоос ойролцоогоор 7000 жилийн тэртээ Дорнод аймгийн Норовлин ууланд талийгаачид хүний дүрст чулуун онго дагалдуулж байсан бол НТӨ III мянганд холбогдох Хэмцэгийн соёлынхон хүн чулуу босгож, НТӨ XIV-VIII зууны үед хиргисүүр-буган хөшөөний соёлынхон өөрсдийн оюун санаа, хийсвэр сэтгэлгээ, ур дүйгээ шингээсэн гайхамшигт чулуун баримлаа ихэс дээдэс,



*Дорнод аймгийн Норовлин уулын чулуун онго*

баатар эрсдээ зориулан босгохын зэрэгцээ тэд зарим тохиолдолд хүний царай нүүрний тэгийг цоолборлож байсан тухай хамгийн эртний баримтууд бидэнд бий. Энэ удаад бид эрт цагийн энэхүү хүнийг төлөөлсөн, хүнд зориулсан, хүнийг дүрсэлсэн эдгээр баримтууд хийгээд дараа дараагийн түүхэнд холбогдох гайхамшигт уран хийц бүхий хүн чулуун хөшөөдийн талаар он цагийн дарааллын дагуу эрдэмтэн судлаачдын ном бүтээлээс иш татан доор товч тайлбарлан өгүүлэхийг хичээе.

### **ХҮРЛИЙН ҮЕИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД**


Монгол орны нутаг дэвсгэрээс сүүлийн жилүүдэд хүрэл зэвсгийн үед холбогдох хүн чулуун хөшөө Ховд аймгийн Булган сумын нутгаас хоёр тоотой олдоод байна. Эдгээр хүн чулуун хөшөөд нь тухайн бүс нутагт элбэг орших Түрэг, Уйгурын хүн чулуудаас цогцолбор болон орших байгууламж, хийж бүтээсэн арга барил, дүр дүрслэлийн хувьд эрс ялгаатай бөгөөд харин БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны нутагт буюу Алтайн нуруунаас эх авсан уулын олон гол мөрний сав, хөндийд тархсан зарим хүн чулуудтай ижилсэнэ хэмээн судлаачид үздэг. Хятадын нутгаас одоогоор энэ он цагт хамаарагдах 70 орчим хүн чулуу бүртгэгджээ. Эдгээр хүн чулууд нь тэг дөрвөлжин, гонзгой дөрвөлжин чулуун хайрцагт болон дүгрэг хэлбэрийн чулуун овоолгот Хэмцэгийн соёлын хүрээнд хамаарагдах булшны дэргэд байрладаг ажээ.

Хэмцэгийн соёл нь Монгол Улс, БНХАУ, Казахстан, ОХУ-д тарсан байдаг бөгөөд манай улсын нутагт Ховд, Баян-Өлгий аймгийн Ягшийн хөдөө, Хэвийн ам, Авын хөх уул, Баян-Өндөр, Улаан худаг, Халзан үзүүр, Баян энгэр зэрэг арав гаруй газар 20 орчим булш оршуулга, тахилгын байгууламжийг илрүүлэн олж малтан судлаад байгаа юм. Хэмцэгийн булшнууд Алтайн нурууны ар, өврийн их

бага голуудын хэндийд тархсан бөгөөд тэд ихэвчлэн голын дэнж дээр ганц нэгээр, цөөн тоогоор бүлэглэн оршдог. Одоог хүртэл олон булштай оршуулгын газар илрүүлээгүй. Мөн энэхүү соёлын булш оршуулга нь Өмнөд Сибирийн Афанасьев, Каракол, Окунев, Елунины соёлуудтой холбоотой хэмээн судлаачид үздэг.



*Ховд аймгийн Булган сумын  
Авын Хөх уулын хүн чулуу*



*Ховд аймгийн Булган сумын  
Ягшийн хөдөөгийн хүн чулуу*

Ховд аймгийн Булган сумын нутаг Авын Хөх улын ар хормойд хиргисүүр, хөшөө чулуу, чулуун овоолгот булш зэрэг олон үед холбогдох дурсгалууд цогцолбор байдлаар орших бөгөөд тэдгээрийн төв хэсэгт зүүнээс баруун тийш цувран байрлах дугуй дараастай хоёр булшны зүүн талын булшны дараасны хойд талд нэгэн хүн чулуун хөшөө бий. Уг хүн чулуу нүүрээрээ зүүн өмнө зүгт хандсан байх бөгөөд түүнийг нарийн ширхэгтэй гөлгөр хөх өнгийн чулуугаар маш ур дүй гарган хийсэн байна. Хөшөөний нүүрэн талыг сайтар өнгөлж толийлгоод баруун гартаа нум барьж, зүүн гараа цээжин дээрээ тавин зогсож буй эр хүнийг дүрсэлжээ. Ингэхдээ хоёр гарыг



*Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өврийн буган хөшөөн дээр дүрсэлсэн хүний нүүрний дүрс*

тохойн үеэр нугалж, зүүн гарын эрхий хурууг гозойлгон бусад дөрвөн хурууг тэнийлгэн цээжин тус газарт буюу баруун гарын бугалга дээр тавьсан байна. Хүнийг дугуйрсан урт хөмсөг бүхий зууван дүрлэгэр том нүдтэй, унжуу урт хамартай, ооч сахалтай болов уу гэмээр, зузаан уруулаа жиммийсэн байдалтай өргөн гонзгой царайтай байгаа нь сүрлэг догшин дүртэй харагдуулна. Хамар, хөмсөг, ооч сахлыг нэгэн үргэлж товгор зураасаар гаргаад нүд, хацар, ам хоёр гар, нум зэргийг тус тусад нь товойлгон дүрсэлжээ. Толгойн орой бөөрөнхий бөгөөд духан дээгүүр малгайн хөвөө мэдэгдэхгүй байгаагаас малгайгүй бололтой. Биенд ямар нэгэн хувцас огт мэдэгдэхгүй. Хөшөөний өндөр 137 см.

Харин өмнөх булшнаас холгүй орших Ягшийн хөдөө хэмээх газарт буй

баруунаас зүүн тийш чиглэлтэй тэгш дөрвөлжин хэлбэрийн том чулуун хайрцаг бүхий булшны зүүн талд цайвар өнгийн цул боржин чулуугаар хөшөө босгосон байжээ. Уг хөшөөг цроолборлон хийсэн бөгөөд хөшөөнд магнай дээрээ хоёр гүвгэр шулуун зураа бүхий дугуй царайтай, хөмсөг, сахалтай хүнийг дүрслэхдээ булчинлаг цээж, баруун гартаа урт нарийн зүйл, зүүн гартаа нум барьж байгаагаар дүрсэлсэн байна. Монгол Алтайгаас шинээр илэрч олдсон эдгээр хүн чулууд нь дүрслэлийн арга барил, хэв загвар, дүрсэлж гаргасан эд юмсын төрөл зүйл хийгээд дэргэд орших

оршуулгын байгууламж, түүний чулуун авс ба хүн чулууг бүтээсэн чулууны сонголт зэрэг олон шинж тэмдгээрээ Евразийн өөр бүс нутгийн түрүү төмөрлөгийн үеийн хүн чулуудтай ижил төстэйгээс гадна энэ үеийн өөр ямар хүн чулуунд огт тохиолдож байгаагүй өвөрмөц онцлогийг өөртөө агуулж байгаа билээ.

Хүрэл зэвсгийн эхэн үед хамаарагдах Хэмцэгийн булш оршуулгын дурсгалтай нэгэн цогцолбор болон орших хүн чулуун хөшөө, тухайн үеийн дунд, төгсгөл үеийн сонгодог дурсгал болох буган хөшөөн дэх хүний нүүрний дүрслэл нь манай улсад одоогоор мэдэгдээд байгаа хүн дүрст чулуун хөшөөний хамгийн эртний дурсгал хэмээн үзэж болно.

Буган хөшөө нь баатар дайчин эрийн бэлгэдлийн дүрслэл мөн бөгөөд түүнийг илтгэх зэр зэвсэг, тусгай хэрэгсэл зэргийг нягт нямбай сийлбэрлэсэн байдаг юм. Хөшөөний дээд хэсэгт толгойн боолт, титэм юм уу малгай, хоёроос гурван ташуу зураас, хүний нүүр, ээмэг, хүзүүний зүүлт зэргийг дүрсэлсэн байдаг.


Одоогийн байдлаар манай улсын нутагт хүний нүүрний дүрстэй буган хөшөө 8 байдаг байна.

Зарим судлаачид хүний нүүр дүрсэлсэн хөшөөнүүд буган хөшөөний соёлын эхэн буюу эрт үед холбогдоно хэмээн үздэг. Мөн ийм дүрслэлтэй хөшөө Орос Алтайн Чуй гол, Кызыл-Джарынд, Өвөрбайгалд бүртгэгдсэн байна.

### ***Түрээгийн үеийн хүн чулуун хөшөөд***

Түрэгүүд нь Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм. Монгол болон зөрчид угсаатны нэгэн адил алтай язгуурын хэлний бүлэгт хамаарах түрэгүүд VI-VIII зууны үед нийт Төв Ази түүний дотор одоогийн Монгол нутгийг харьяандаа багтаасан хүчирхэг хаант улсыг байгуулж энэ бүс нутаг





Түрэгийн үеийн хүн чулуудын тархалт





*Чулуун сууринд бэхэлж суулгасан хүн чулуу. Архангай, Тариат, Дадга*

дахь түрэг угсаатны 400 орчим жилийн ноёрхлын эх үндсийг тавьжээ.

Түрэгийн өвөг дээдэс эхэн үедээ, эдүгээгийн Дорнод Туркестанд нутаглаж байгаад 460 оны үеэс Жужан улсын харьяанд даган орж Алтайн өмнөд биед шилжин суугаад төмрийн хүдэр хайлан алба барьж байжээ. Түрэгүүд улс төрийн уран нарийн бодлого явуулж хүчээ зузаатгасаар 552 онд Түрэгийн зонхилгоч Буман, Жужаны эсрэг босон тэмцэж бут цохисон байна. Ингээд өмнө нь Жужаны харьяанд байсан олон овог аймгийг газар нутагтай нь эзлэн Түрэгийн хаант улсыг байгуулжээ.

Түрэгүүд дорно зүг нутаг тэлэн суурьшаар удалгүй Монголын төв нутаг Орхон голын саваар төвлөх болж улам улмаар хүчирхэгжин газар нутгаа тэлж байв. Үүний үр дүнд Солонгосоос

Баруун тэнгис (Арал нуур), их элсэн цөлөөс умрын Байгал нуур хүртлэх нутгийг эзэлсэн хүчирхэг улсыг байгуулж, Хятад, Византи зэрэг тухайн үеийн том гүрнүүдтэй өрсөлдөх болжээ.

Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйл гэвэл, юуны өмнө хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдийг

оршуулсан булш зэрэг зүйлс ордог байна.

Харин Түрэгийн үеийн хүн чулуу нь гол мөрний сав хөндий, тэдгээрийн ойр орчим тэгш сайхан тал зэрэг олны хараанд өртөхүйц байгалийн үзэмжит газар нутагт байгуулсан тахил тайлгын байгууламжийн бүрэлдэхүүн хэсэгт багтан байдаг. Эдгээр нь нэг дор, нэг цогцолбор дурсгалд ганц нэгээрээ байхаас гадна хоёр ба түүнээс дээш тоотойгоор бүлэглэн байдаг. Заримдаа тухайн үеийн ихэс ноёдын тахилын байгууламжийн бүрэлдэхүүнд хэдэн арваараа хамт байх нь бий. Манай оронд хамгийн олон хүн чулуу бүхий цогцолбор дурсгал бол Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Өнгөтийн дурсгал бөгөөд тэнд нийтдээ 28 хүн чулуутай ажээ.

Эртний түрэг угсаатан ард түмний үлдээсэн хүн чулуун хөшөө нь Евразийн нутаг өргөн тархсан бөгөөд одоогоор Монгол, Өмнөд Сибирь, Уулын Алтай, Тува, Казахстан, Шинжаан зэрэг газарт илрүүлэн олоод байна. Монгол улсын нутаг дэвсгэр дээр нийт 21 аймгийн 114 сумын нутгаас нийт 628 хүн чулуу бүртгэгдээд байгаа билээ.

Хүн чулууг зориуд зассан хавтан чулууг дөрвөлжлүүлэн хийсэн хашлаганы зүүн өмнө талд нүүрээр нь нар мандах зүүн зүгт хандуулан босгосон байдаг. Энэхүү хүн чулууны өмнөөс урагш



*Суулгах хэсгийг засалгүй газрын хөрсөнд суулгасан хүн чулуу. Архангай, Эрдэнэмандал, Бүрдний адаг*



*Хавтгай суурь зассан хүн чулуу.  
Өвөрхангай, Уянга, Онгийн гол*

олон тоотой чулууг нэг эгнээгээр цэгцтэй цувуулан зоож тавьсныг балбал буюу зэл чулуу хэмээн нэрлэнэ. Хүн чулуу нь ганц нэгээрээ байх тохиолдолд хашлага чулуу болон зэл чулуутай байх бол ихэс язгууртанд зориулсан онгонд тахилын сүм, эзэн ноёны болон бараа бологч нарын чулуун хөрөг, чулуун хонь, арслан зэрэг адгуус амьтны дүрсийг тодорхой дэс дарааллын дагуу тавьдаг байна.

Энэ үеийн хүн чулууг суурилуулан тогтооходоо газар ухан нүхэнд суулгах, доод талд нь тусгай тавцан гаргаж суурийн доод талыг хавтгайлж засаад газрын хөрсөнд сул тавих, тусгай бэлдсэн голдоо нүхтэй хавтгай чулуун сууринд бэхэлж суулгах гэсэн үндсэн гурван арга байдаг бөгөөд Монгол орны хувьд хүн чулуудыг суурилуулахдаа эхний хоёр аргыг зонхилон ашиглаж байжээ.

Тухайн үеийн хүн чулууг чухам хэнд зориулан босгож байсан талаар судлаачдын дунд хоорондоо зөрүүтэй үзэл бодол байсаар байгаа юм. Зарим судлаачид эдгээр хөшөө нь нас барсан баатар



эрсийн хамгийн хүчит дайсан этгээдийг дүрсэлсэн гэдэг бол өөр хэсэг судлаачид нас барсан баатрын өөрийн дүрсэлсэн хөшөө хэмээн үздэг байна.

Түрэгийн үеийн хүн чулууг хийц загвараар нь бүрэн дүрслэлтэй, заримдаг дүрслэлтэй, тойм дүрслэлтэй хэмээн үндсэн хоёр хэсэгт хуваан авч үздэг. Тэдгээрийг дотор нь суугаа дүрстэй хөшөө, босоо хөшөө хэмээн хоёр ангилдаг.

Бүрэн дүрслэлтэй хөшөө нь хүний биеийг толгойгоос хөл хүртэл бүрэн бүтнээр нь дүрсэлсэн хөшөөг хэлэх бөгөөд дотроо суугаа дүрстэй хөшөө нь завилан суусан, сөхрөн суусан, нэг хөлөө нугалан цомцойн суусан гэж мөн дотроо гурав хуваагдана. Завилан суусан хүн чулууд нь тухайн тахил тайлгын онгоны эзэн байхад сөхөрсөн болон нэг хөлөө нугалан цомцойн суугаа хоёр хэлбэрийн хүн чулууд тухайн тахил тайлгын онгоны эзэнд үйлчлэх зарц, шивэгчдийн дүр хэмээн үзэж болно.

Харин босоо хөшөө нь хүний бүх биеийг маш тодорхой дүрсэлсэн, харин нөгөө нь хөл дүрслээгүй ч бусад биеийн хэсэг, хувцас хунарыг тодорхой дүрсэлсэн гэсэн хоёр хэсэгт хуваан авч үздэг байна. Энэ хоёр ялгаатай дүрслэл нь томоохон язгууртны онгоны бүрэлдэхүүнд багтсан чулуун баримлыг дээл хувцас, гутал, зэр



*Бүрэн дүрслэлтэй, босоо хөшөө.  
Архангай аймгийн Хашаат сумын  
Культегины онгон*





*Хөл болон гутал дүрслээгүй  
хүн чулуу хөшөө.  
Архангай аймгийн Хангай сумын  
Ноён хангайн хүн чулуу*

зэвсэг тэргүүтнийг уран тод гаргасан байдаг бол харин өмнөх зэрэг дэвээс арай бага тушаалтны тахил тайлгын онгонд хөшөөний ерөнхий хэлбэрээс тодорхой харагдахуйц буюу бүснээс зүүсэн зэр зэвсэг, эд хэрэгсэлийг тодорхой дүрсэлсэн хэдий ч гуталтай хөлийг ялган гаргаагүй ч зогсож буй утга санааг бүрэн илэрхийлэхүйц байдаг байна.

Заримдаг дүрслэлтэй хөшөө нь босоо, суугаа алин болох тодорхой мэдэгдэхгүй боловч хүний толгой, нүүрний дүрсийг тодорхой дүрслэн гаргаад харин биеийн бусад хэсэг, хувцас, эд хэрэглэл зэргийг хагас дутуу, ур муутай заримдаг

байдлаар дүрсэлсэн байдаг.

Тойм дүрслэлтэй хөшөө гэдэгт гонзгой хэлбэртэй чулуунд хүний толгой, их биеийн ерөнхий хэлбэр оруулж засаад нүүр, ам, нүд болон эд хэрэглэл дүрслээгүй хөшөөг хэлдэг. Энэ төрлийн хөшөө чулуу харьцангуй бага тохиолдоно.

Гэхдээ тухайн үеийн хүн чулуу нь ихэнхдээ хугарч эвдэрсэн байх бөгөөд хамгийн нийтлэг шинж нь уг дурсгалын бүрэлдэхүүнд байгаа чулуудын ихэнхийнх нь толгойг хуга цохин хагалж, буталсан байх ба түүний дотор хамгийн уран чамин хийцтэй хөшөөд, өөрөөр хэлбэл уг цогцолборын эзэн хүний хөрөг дүрсийг илүүтэй эвдэн сүйтгэсэн байдаг ажээ.

Харин болхи хийцтэй, зарц болон оршуулганд оролцож буй бусад хүмүүсийн гэхээр дүрсийг бага эвдэлсэн, бүр муу хийцтэйг нь

бүтнээр нь үлдээсэн байдаг. Энэ бүхнээс үндэслэн судлаачид хүн чулууудыг Түрэгийн хаант улсыг мөхөөн дарсан Уйгурууд эвдэн сүйтгэсэн бололтой хэмээн үздэг.

Түрэгийн үеийн цөөн хэдэн хүн чулуу нь харьцангуй сайн хадгалагдан үлдсэн бөгөөд тэдгээрийг ажиглахад хүний нүүр царайг бодит төрхөд нь аль болохоор ойртуулж товгор байдлаар цоолборлон хоёр хөмсгийг хооронд нь нийлүүлэн уулзвараасаа хамрын зураасыг доош үргэлжлүүлж нэгэн үргэлж товгор байдлаар дүрслэх нь элбэг байна. Бодитой урласан хүн чулууны шанаархан өргөн нүүртэй, жартгардуу урт нүдтэй, намхавтар хамартай жинхэнэ Умард Азийн хэв төрхийн хүний дүр төрхийг илтгэнэ хэмээн мөн судлаачид үздэг.

Хүн чулууг ийнхүү өөр өөр загвар зохиомжтой төдийгүй ур хийцийн хувьд ч мэдэгдэхүйц ялгаатай хийдгийн учир шалтгааныг манай нэрт археологич Д.Баяр агсан эртний түрэгийн тахил шүтлэгийн цогцолбор байгууламж бүтээх зан үйл, тэнд дүрслэн хийж тавьсан хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, зэрэг дэвийн ялгаа зэрэгтэй холбон тайлбарласан байдаг.



*Малгай, титэм дүрсэлсэн  
хүн чулуу.  
Архангай, Хашаат, Культөгийн  
хөшөөний толгойн хэсэг*



*Ээмэг дүрсэлсэн хүн чулуу.  
Завхан, Алдархаан,  
Хатавчийн ам*

*Хүснэгт 1: Түрэгийн хүн чулууны хийц загвар,  
 утга учир, дүрсэлвэрийн ангилал*

Хийц загвар		Утга учир	Дүрсэлвэр
Бүрэн дүрслэлтэй	Суугаа хөшөө	Завилж суусан хөшөө	Малгай
	Босоо хөшөө	Босоо дүрстэй хөшөө	Гээг үс
Заримдаг дүрслэлтэй	Толгой, нүүр, бусад эрхтэн, эд хэрэглэл бүрэн бус	Сөхөрч суусан дүрс	Дээл
	Толгой, нүүр тодорхой биеийн ерөнхий тэг, хувцас, эд хэрэглэлгүй	Цомцойн суусан дүрс	Бүс
Тойм дүрслэлтэй	Гонзгой хэлбэртэй чулуунд хүний толгой их биеийн ерөнхий дүрс	Зэл чулуу	Зэр зэвсэг
			Сав суулга
			Гоёл чимэглэл
			Гутал

Түрэгийн хүн чулууны дүрсэлвэрийг үүрэг зориулалтаар нь малгай, гээг үс, дээл, бүс, зэр зэвсэг, хавтага, билүү, сав суулга, гоёл чимэглэл, гутал гэсэн хэд хэдэн зүйлд хуваан авч үздэг. Эдгээр дүрсэлвэрийн зүйлс нь тухайн үеийн нийгмийн байдал, зэрэг зиндаа болон эдийн соёлын өвөрмөц байдлыг бүрэн илэрхийлэх бөгөөд тэдгээр нь археологийн эх хэрэглэгдэхүүн, эртний түүхийн сурвалжийн мэдээ, дүрслэх урлагийн бүтээлд тусгалаа олсон байдаг байна. Монголд буй түрэгийн үеийн хүн чулуун хөшөөдийн он цагийг тогтоох хамгийн найдвартай баталгаа нь зарим хүн чулуудын дэргэд буй руни бичигт гэрэлт хөшөөд юм. Бичиг үсгийн дурсгалын мэдээ баримтаар, үүсгэж байгуулсан он цаг нь ямар ч маргаангүй дурсгалуудын тоонд Билгэ хаан (735 он), Куль-Тегин (732 он), Тоньюкук (720 он), Их Хөшөөт (742-745 он), Онгийн гол (731-732 он)- ын дурсгалууд багтаж байгаа бөгөөд эдгээр нь бүгд

Монгол нутгаар төвлөн тогтож байсан Хөх Түрэгийн хаант улс Уйгурт цохиогдон задарч мөхөхийн өмнөхөн үед холбогдож байгаа билээ.




*Зүүлт, хувцас дүрсэлсэн хүн чулуу. Баян-Өлгий, Сагсай,  
Даян баатар*

## **Уйгурын үеийн хүн чулуун хөшөөд**

Түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний ор суурийг Уйгур улс эзэлж VIII-IX зууны үед Монгол нутагт ноёрхлоо тогтоожээ. Уйгур нь мөн алтайн хэлний бүлэгт багтах түрэг угсаатан байв. Хятадын түүхэнд уйгурын өвөг дээдсийг НТӨ III зууны үеэс Дин-Лин гэж нэрлэж байсан ба НТ IV зууны үеэс дили, тэлэ гэж нэрлэх болсон байна. Тэд өндөр дугуйтай тэрэг хэрэглэх учир гаогюй (өндөр дугуйтан) ч гэдэг байв. V зууны үеэс тэднийг Хуйхэ, Ойхор, Уйгур гэх нэрээр түүхэнд тэмдэглэх болжээ. Тэд эрт үеэс Хүннү, Сянби, Тоба, Жужан, Түрэг нартай айлсан оршиж тэдэнтэй байлдах, найрамдах, эрхшээлд нь орох зэргээр тусгаар улс болохын төлөө тэмцсээр ирсэн байна. VII зууны эцэс, VIII зууны эхээр аймгийн зонхилогч, тэргүүлэгчдийн эрх нь үе залгамжлан дамжих болжээ.

*Уйгурын үед холбогдох хүн чулууны тархалт*





*Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын  
Цагаан хөшөөтийн уйгурын үед  
холбогдох хүн чулуу*

VIII зууны дөчөөд оныг хүртэл уйгурууд Түрэгийн хаант улсын мэдэлд байсан ба зонхилгогч нь Пэйло байв. 744 онд Пэйло биеэ Куль Билгэ хэмээх цолтой хаан болгон өргөмжилж бослогыг удирдан түрэгүүдтэй тэмцжээ. Ингээд 745 онд уйгурууд Түрэгийн хаант улсыг бүрмөсөн бут цохин мөхөөсөн байна. Ийнхүү Уйгур улс байгуулагдав. Тэд газар нутгаа тэлж VIII зууны үед Алтайн уулсаас Хянган, говиос Саяны уулын хоорондох нутгийг эзлэх

болсон бөгөөд 751 онд Орхоны хөндийд Балыклык (Хар балгас) гэдэг хот байгуулан улсын нийслэл болгожээ.

Уйгурчуудад холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйлд хот суурин, тахил тайлгын онгон, хүн чулуу, адгуус амьтны дүрс, бичиг үсгийн дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, булш оршуулгын дурсгал багтана.

Монгол нутаг илэрч олдсон хүн чулуун хөшөөдийн ихэнхи нь хийсэн арга барил, загвар, дүрслэл хийгээд дүрсэлж гаргасан эд юмсын хувьд эртний Түрэгийн үед холбогдож байгаа нь нотлогдсон. Хэдий тийм боловч эдгээрийн дотор үндсэн шинж тэмдгүүдээр өмнөх үеийн нийтлэг загвараас эрс ялгаатай цөөн тооны хүн чулуун хөшөө бий.





*Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын төв дэх уйгурын үед холбогдох хүн чулуу*

Ийм өвөрмөц хэлбэр дүрслэлийн хүн чулуун хөшөө манай орны баруун бүс нутаг буюу Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Бага хайрга, Улаан дэлийн үзүүр, Битүү болон Баяннуур сумын Цагаан хөшөөт, Ногооннуур сумын төвд буй зэрэг хүн чулуун хөшөөдийг нэрлэж болно. Энэ төрлийн хүн чулуун хөшөөдөд дүрслэн гаргасан эд зүйлс гэвэл, олонхи нь хоёр чихэвчийг нь дээш сөхөж өмссөн өвөрмөц хэлбэрийн малгайтай, гарт барьсан савны хэлбэр нь ердөө л ганц төрөл байхаас гадна түүнийгээ хоёр гараараа гэдэсний өмнө барьсан, эр хүнийг дүрсэлсэн хөшөөнд ганц бүдүүн гээг болон олон унжлага зүүлт бүхий цулгуй бүс заавал байдаг зэрэг шинж болно. Зарим судлаачид энэ төрлийн дурсгалын он цаг, учир холбогдол нарийн

гүйцэд тогтоогдоогүй байгаа ч бүтэц, зохион байгуулалт зэрэг шинж тэмдгээр нь VIII-X зууны үед холбогдуулан үздэг.

Эдгээр хүн чулуудаас жишээ болгон Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын төв дээр зэрэгцэн орших хоёр хөшөөг бүрэн танилцуулья.

Энэхүү хоёр хүн чулууг сумын төвөөс урагш орших Ямаат улаан хэмээх уулнаас авчирсан хэмээн нутгийнхан хэлэлцдэг. 1-р хүн чулууг цайвар саарал боржингоор босоо хүний дүрстэй хийжээ. Чихэвчийг сөхсөн дүгрэг малгайтай, өргөн нүүр, урт шувтан эрүүтэй, хоёр үзүүр нь дэрвийсэн хөмсөгтэй ба хөмсөг, хамрыг нэг үргэлж



*Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын төв дэх  
уйгурын үед холбогдох хүн чулуу*

товгороор гаргаж давхар аньсагатай зуван том нүд, жижиг ам дүрсэлжээ. Хоёр гараар хэвлийн өмнө шулуун амсар, цүлхэн бөөр, босоо ёроолтой ваар барьжээ. Чихэндээ бөөрөнхий унжлагатай онгин хэлбэрийн ээмэг зүүсэн байна. Бүс зүүлт байхгүй. Газраас цухуйх өндөр 174 см, нүүрийн өргөн 54 см, мөрний өргөн 59 см, зузаан 38 см. Харин 2-р хүн чулуу нь улбар шар өнгийн боржингоор хийсэн босоо хүний дүрс юм. Өргөн нүүр шувтан эрүүтэй, өмнөөс нь харахад бортого хэлбэрийн малгай өмссөн ба цээжинд нь доош унжсан хоёр хөх гаргаснаас үзэхэд эмэгтэй хүний дүрс ажээ.

Хоёр гараа хэвлийн өмнө авч ямар нэгэн сав барьж байсан бололтой. Энэ хавь нь холтрон унасан тул савны хэлбэр тодорхойгүй. Газраас цухуйх өндөр 140 см, нүүрийн өргөн 55 см, мөрний өргөн 59 см, зузаан 37 см.

Эдгээр хүн чулууны хийц дүрслэл болон дэргэд нь байх байгууламжийн хэлбэр дүрс түрэгийн хүн чулууныхаас эрс ялгарч

байна. Харин газар зүйн байршлын хувьд, түрэгийн хүн чулуу элбэг тархсан Баруун Монгол, Алтайн уулсаар байх ба Уйгур улсын төв байсан Монголын төв нутагт огт тааралддаггүй байна.

Мөн Уйгурын хүн чулуун хөшөөдийн тархац байршил нь Монгол Алтай болон Тувагийн нутагт л олдож байснаас бус Уйгурын хаант улсын ноёрхол тогтож байсан бусад газар нутгаас цөөн тоотой олджээ. Иймээс энэ төрлийн дурсгалыг улам нарийвчлан судлаж он цаг тогтоох найдвартай баримт хэрэглэгдэхүүнийг илрүүлэх шаардлагатай юм.

Эрдэм шинжилгээний ном зохиолд ийм төрлийн хүн чулуун хөшөө Алтай, Казахстан, Дорнод Туркестан, Долоон усны газар зэрэгт байдаг гэсэн зүйл байх боловч одоогоор бидний мэдэлд эдгээр нутагт илэрч судлагдсан хүн чулуун хөшөөдийн дотор яг ийм дүрслэлтэй хүн чулуун хөшөө мөн гэсэн хэрэглэгдэхүүн алга байна.

### ***Хятаны үеийн хүн чулуун хөшөө***

Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг нь Хятан улс бөгөөд тэдэнтэй уг удмын холбоотой аймгууд одоогийн Хятадын Гирин муж, Ляохэ буюу Шар мөрний орчим нутаглаж байжээ. Манжуурын төв ба өмнөд хэсэг (Гирин, Ляонин муж, Өвөрмонголын нутаг) нь эртнээс монгол буюу манж зүрчид гаралтай ард түмний мандан бадарч улсаа байгуулж явсан нутаг юм.

Эртний Хятадын сурвалж бичигт Хятан нарыг хүннүгээс буюу дунхугаас гаралтай гэдгээс өөр нарийн тодорхой зүйл байхгүй. Түүнчилэн хятан, монголчуудын хэл, зан заншил нь онцын ялгаагүй гэж үздэг байна. Хятаны үг, нэр томъёог үзэхэд монгол үг их тохиолддог.

Хятан нар VI зууны үед Солонгосын Гаоли (Корё) улстай нягт харилцаатай байсан тухай мэдээ бий. Харин VII зууны үеэс

хүчирхэгжиж үе залгамжлан захирах “Дахэ” хэмээх ноёлох овогтой болов. Энэ үед дөрвөн түмэн цэрэгтэй, Түрэгийн харьяанд байжээ. VII зууны дундуур Тан улс Түрэгийг бутцохин эзлэхэд Хятад нар Хятадын хаанд алба барьж харьяалагдах болсон боловч тэд Тан улсын харьяанаас гарахаар босч тэмцэн удаа дараа дарагдаж байжээ.



*Булган аймгийн Сэлэнгэ сумын  
Ингэттолгойн хүн чулуу*



*Хятад улстай хил залган оршин  
байсан Сүн улсын хаан Тайзуны хөрөг*

Хожим 901 онд Хятад улсын хаанаар Елюй овгийн Амбагянь тодрон гарч эрх мэдлээ бэхжүүлэн хуучин найман аймгийг үндэс болгон Хятад улсыг байгуулжээ. Хятад улсад нийт 55 аймаг улс багтсан ба тэдгээрийг өмнөд замын 16 аймаг, умарт замын 28 аймаг, гадаад 8 аймаг гэж хуваадаг. 5 нийслэлтэй, газар нутаг нь дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан суваг (Бо-гу) хүртэл өргөжсөн байна.

Хятан нарт холбогдох археологийн дурсгал дотор хот суурин, булш оршуулга, бичиг үсгийн дурсгал, хүн чулуу гэсэн зүйлс багтдаг.

Булган аймгийн Ингэт толгой сангийн аж ахуйн төвөөс зүүн тийш нэг км орчим зайтай Ингэт толгой (Энх толгой) хэмээх жижиг толгойн өвөрт нэгэн хүн чулуун хөшөө байдгийг нутгийнхан “Далхавандад” хэмээн нэрлэж хүндлэн тахисаар иржээ.

Улбар бор элсэрхэг чулуугаар босоо хүний дүртэй урласан байна. Орой дээрээ овгортой, толгойг нягт барьсан дүгрэг малгай өмссөн ба өргөн дүгрэг царайтай, том нүдтэй, нүдний дотуур давхар зураасаар хөвөөлөн дунд нь цөцгий гаргасан нь баруун нүдэнд тодорхой мэдэгдэнэ. Хамар нь нилээд урт ба үзүүр нь хугаран унажээ. Ам, уруул тодорхойгүй. Зүүн чих бүтэн байгаа нь зууван тал цагираг хэлбэртэй. Баруун гараар цээжний хажууд ваар сав барьж байсан болов уу гэлтэй, гарын үзүүр хэсэг байхгүй. Зүүн гараа нугалж хэвлийн хажууд барьсан нь бас сарвууны хэсэг нь хадгалагдсангүй. Газар шүргэсэн урт дээлтэй, энгэр заам мэдэгдэхгүй, хоолой, орчимд хувцасны зах бололтой зураас гаргажээ. Маш өргөн, нэлэмгэр ханцуйтай, энэ нь хормойтой чацуу газар шүргэсэн байна. Хэвлийгээс доош, улбар өнгийн зосон будгаар ханан хээ мэт дүрс гарган хээлжээ. Хөл дүрслээгүй ба энэ хэсгийг углуургадан зооход зориулж нарийсган зассан нь газарт зоолттой байна. Өндөр (газраас дээш) 220 см, мөрний өргөн 70 см, зузаан 30 см ажээ. Энэ хүн чулуун хөшөөний хийц хэлбэр нь Монгол нутагт элбэг таардаг VI-VIII зууны Түрэг, VIII-IX зууны Уйгур, XIII-XIV зууны Монголын хүн чулуун хөргөөс аль алианаас нь эрс өөр, өвөрмөц сонин юм. Хувцас хунар нь өмнө зүгийн Нангиад газрын бомбын шашны хувраг хүнийхтэй нэн төстэй ажээ. Энэ хүн чулууг өмнө нь эрдэм шинжилгээний ном зохиолд XIV-XV зууны Мин улсын үеийн дурсгал гэж үзсэн зүйл бий. Гэвч, Мин улсын цэрэг Монголд удаа дараа цөмрөн орж байлдаж



дайтаж байснаас бус удаан хугацаагаар эзэрхэн сууж байгаагүй, ийм дурсгал үлдээх боломж нөхцөл дутмаг хэмээн судлаачид үздэг. Харин Монгол нутагт байсан овог аймгуудын дотроос нанхиадын нөлөөг илүүтэй тусган авсан нь хятан нар бөгөөд Хятаны хаад язгууртны тахилын онгонд чулуугаар хүн амьтны дүрс урлан хийж тавьдаг заншилтай байсан зэргээс үзэхэд энэ нь X-XII зуун буюу Хятан улсын үед холбогдох дурсгал бололтой. Ингэж үзэх бас нэг шалтгаан бол, Ингэт толгойн оройд нэг сонирхолтой байгууламж байдаг нь, тэг дөрвөлжин хэлбэрээр чулуу шигтгэн суулгаж хийсэн 6,5х6,5 м хэмжээтэй, ертөнцийн зүг чигийн дагуу байрлалтай чулуун хашлага юм. Үүний голд дөрвөлжлөн хэдэн чулуу өрж суулгасан байгаа нь бүрэн бус ч ерөнхий хэлбэрээ хадгалан үлджээ. Мөн ойр орчмоос хятаны үед хэмээн тодорхойлогддог “дусал” хээтэй шавар ваар савны хагархай элбэг олддог билээ.


Мөн Алс, Дорнод, Уссури хязгаараас эртний Зөрчидийн соёлд холбогдох үүнтэй төстэй хүн чулуун хөшөө болон жижиг хүрэл баримал олддогоос гадна Монгол нутагт X-XII зууны үед тогтож байсан Хятан улсын үеийн эдийн соёлын дурсгал дотор ч ийм маягийн зүйлс цөөн боловч тохиолддог.

### ***Монголын үеийн хүн чулуун хөшөөд***


Хятан улс XII зууны үед мөхсөний дараа монгол угсааны овог аймгууд Хятадын Цагаан хэрмээс Сэлэнгийн эх хүртлэх нутгийг эзлэн оршиж байв. Тэд нийгмийн хөгжлөөр харилцан адилгүй бөгөөд оршин суух нутаг газар болон эрхлэх аж ахуйнхаа хувьд ойн болон талын нүүдэлчид гэсэн хоёр үндсэн хэсэгт зааглагдаж байсан юм. Тэд хожим нь Монгол хэмээх нэрийн дор нийлэн нэгдэж Монгол угсаатныг бүрэлдүүлсэн тэр овог аймгууд нь тухайн үед Хамаг Монгол, Хэрэйд, Найман, Мэргид, Татар, Онгуд аймаг, ханлиг болон оршиж байв.



МОНГОЛ НУТАГ ДАХЬ ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ  
Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нарт зориулсан гарын авлага



Монголын үед холбогдох газрын зураг



Ингээд XIII зууны эхээр эдгээрийн дотроос Хамаг Монголын ханлиг нэн хүчирхэгжин нийт Монгол угсаатныг нэгтгэн 1206 онд Онон мөрний эхэнд их хуралдай хийж Тэмүжинг Чингис хаан цолоор өргөмжлөн Их Монгол улсыг байгуулсан билээ. Чингис хааны зарлигаар Хар Хорумд улсын нийслэлийг байгуулж, дараах хаадын үед өргөтгөн барих ажлыг гүйцэтгэсээр иржээ.

Хар Хорум төвтэй Их Монгол улс нь Чингисийн дараах хаадын үед уугуул нутагтаа цэцэглэн мандаж өрнө дорнын олон газрыг улс төр, эдийн засаг, соёлын талаар холбон ойртуулах чухал зангилаа болж байжээ.



*Исэр сандалд суугаа чулуун хөрөг. Сүхбаатар аймгийн  
Онгон сумын Таван толгойн хүн чулуу*

Харин 1260 онд Хубилай хаан улсын нийслэлийг өмнө зүг шилжүүлж Хятад газар төвлөрөн сууж улсын нэрийг Их Юан болгон өөрчилжээ. Улмаар 1368 онд Монголчуудын байгуулсан Их Юан улс Хятадын босогчдод цохигдон мөхсөнөөр монголчууд уугуул нутагтаа төвлөрөх болсон ч өмнөх сүр хүч нь доройтон суларч өөр



*Исэр сандалд суугаа чулуун хөрөг. Сүхбаатар аймгийн  
Онгон сумын Шивээтийн хүн чулуу*

хоорондоо тэмцэн хямарсан бутралын үе эхэлжээ. Энэ байдал удтал үргэлжилсээр XVII-XVIII зууны үед монголчууд бүхэлдээ Манж Чин гүрний мэдэлд орж улс төрийн тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн юм.

Монгол гүрний үед холбогдох археологийн дурсгалд хот суурин, булш оршуулга, хүн чулуу, бичиг үсгийн дурсгал, хадны зураг зэрэг зүйлс багтана.

Монгол гүрний үеийн хүн чулуун хөшөөний ихэнхи нь Монголын зүүн өмнөд хэсгээр оршино. Сүүлийн үеийн судалгаагаар ийм төрлийн хүн чулуун хөшөө манай улсын хилээс урагш БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн нутгаар байгаа болох нь тогтоогдоод байна. Одоогоор Монгол Улсын нутаг дэвсгэрээс 8 аймгийн, 18 сумын нутагт 78 тооны хүн чулуу бүртгэгдээд байна.



*Босоо чулуун хөрөг. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Дугнар*

Энэхүү хүн чулууг судлан шинжлэх ажил 100 орчим жилийн өмнө буюу 1927 онд Оросын судлаач В.А.Казакевич Даригангын хязгаарт буй 17 хүн чулууг сурвалжлан олж, нэгбүрчлэн тодорхойлон бичээд зарим хөшөөний ур хийцийг хараад Төв Азийн хүн чулууны оргил нь болсон гайхамшигт дурсгал хэмээн дуу алдаж бичиж байжээ.

Үүнээс хойш олон орны эрдэмтэд энэ үеийн хүн чулууг судлан шинжлэж, он цагийн талаарх өөрсдийн саналыг тавьж байсан юм.

Нилээд хожим 1980 онд Оросын угсаатан зүйч Л.Л.Викторова өөрийн бүтээлдээ Дорнод Монголын тал нутагт төвлөрсөн өвөрмөц хийц загвартай эдгээр хүн чулууг XII-XIII зуунд холбогдоно хэмээн нийтлүүлсэн юм. Үүнээс 15 жилийн дараа буюу 1995 онд манай нэрт археологич Довдойн Баяр агсан

“Монголчуудын чулуун хөрөг” хэмээх бүтээлээ туурвисан нь Монгол гүрний гайхамшигт уран барималын хийц загвар, дүрсэлвэр, утга учир, он цаг зэргийг цогц байдлаар нэгтгэн авч үзсэн тулгуур судалгаа болсон билээ. Энэхүү бүтээл нь өнөө хир шинжлэх ухааны үнэ цэнээ огтхон ч алдаагүй, судлаач бидний гарын авлага, сурвалж хэвээр байна.






*Босоо чулуун хөрөг. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын  
Дугнарын хүн чулуун хөшөө*

Монгол гүрний үеийн хүн чулуун хөшөө нь хийсэн дүрслэл, дүрслэн гаргасан эд юмс, зохион байгуулалт зэрэг зүйлээрээ өөрийн гэсэн онцлог шинжийг агуулдаг. Дорнод Монголын хүн чулуун хөшөөнд дүгрэг хэлбэр гарган овоолж хийсэн булш гэмээр байгууламжийн зүүн өмнөд хэсэгт мөн зүүн өмнө зүг хандуулан байрлуулсан байх ба Түрэгийн цогцолбор дурсгалд заавал байдаг онцлог зүйлс болох шороон хэрэм, усны суваг, бичигт хөшөө, ан амьтан, цуварсан зэл чулууны аль аль нь байхгүй ажээ.





*Исэр сандалд сууж буй чулуун хөрөг.  
Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан  
сумын Сэнж мандал.*



*Өлзийт Төмөр хааны хөрөг*



*Эмэгтэй хүнийг дүрсэлсэн  
чулуун хөрөг. Хаалгат*



*Дармабалын хатан  
Тажигийн хөрөг.*



*Монголын чулуун хөрөг ба археологийн эх хэрэглэгдэхүүн*

Дорнод Монголд босоо, суугаа байдлаар урласан хүн чулуун хөшөөнд аль аль нь тохиолдох боловч дийлэнхийг түшлэгтэй сандалд суусан байдлаар дүрсэлсэн нь эдгээрийн өвөрмөц шинж бөгөөд хүний биеийн бүхэл хэсгийг аль болох бүрэн дүрслэхийг хичээсэн байдаг. Ялангуяа хөлийг нарийн нямбай сийлж гаргасан нь бусад үеийн хүн чулуун хөшөөнөөс эрс ялгардаг.

Монголын үеийн хүн чулуун хөшөөний өөр нэгэн онцлог шинж нь баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэг, эсвэл өвдөг дээрээ тавин, сандал дээр суугаа байдлаар урладаг юм. Харин баруун гарт нь сав бариулан дүрсэлдэг нь Түрэгийн болоод нийт нүүдэлчдийн хүн чулуун хөшөө бүтээх урлагийн нийтлэг заншил билээ. Монголын үеийн хүн чулуун хөргийн хэв загвар, зохиомжийн онцлог шинжүүдийг нарийвчлан авч үзвэл эр хүний хөрөг дүрсээс гадна эмэгтэй хүнийг дүрсэлсэн хөшөө байгаа бөгөөд тэдгээр нь гэзэг үс, дээл хувцас, эд хэрэглэл болон бие бялдарын ерөнхий төрхөөр хоорондоо эрс ялгаатай ажээ. Эр хүнийг бөмбөгөр оройтой, дугариг хүрээтэй малгайтай, өвөг шинжийг илтгэсэн

гээгтэй, бүс бүслэж, хавтага хутга зэрэг зүйлс зүүлгэн дүрсэлдэг бол эмэгтэйчүүдийг богтаг малгайтай, уг малгайн гоёл чимэглэлийн зүйлс, товгор хөхтэй дүрслэдэг байна. Мөн энэ үеийн чулуун хөргүүдийг ихэнхи тохиолдолд бүрэн хувцастай урладаг хэдий ч цөөн тохиолдолд дээл хувцасгүй нүцгэн цоолборлож, эр хүйсийн тэмдгийг цохон дүрсэлсэн байдаг. Үүнийг судлаачид амьд ахуй цагтаа ямар нэг хүнд ял хийсэн сурвалжит хүний хөргийг бүтээхдээ ийнхүү нүцгэн дүрсэлдэг байсан байж болох талаар өөрсдийн таамаглал дэвшүүлсэн нь бий.

Мөн дундад эртний монгол хөрөг чулуунд дүрсэлсэн эд өлгийн соёлын холбогдолтой зүйлс буюу гээг үс, малгай, дээл, бүс, гутал, хундага сав, хавтага, хутга, гоёлын ба шүтлэгийн зүйлс, сандал суудал зэргийн хэлбэр хийц маяг нь тун сонирхолтой бөгөөд ер нь хүн чулуунд дүрсэлсэн эдгээр зүйлс нь тухайн ард түмний зан заншил, угсаа гарлыг тогтооход чухал үүрэгтэй юм. Монголын үеийн хүн чулуун хөрөгт дүрсэлсэн эд зүйлс нь XIII зууны үед Монголд айлчин ирж монголчуудын зан заншил, төрх байдлын талаар тодорхой тэмдэглэн бичсэн өрнө дорнын элч жуулчдын тодорхойлолт, перс ном зохиолын чимэглэл зураг, Юан улсын нангиад зураачдын бүтээсэн монголчуудын ахуй амьдралын сэдэвт зураг, Турфанаас олдсон хана туурганы чимэглэл зураг зэргээс гадна Өмнөговь аймгийн Ноён сумын Цагаан ханангийн хадны оршуулга, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Бухын хошууны хадны оршуулга, Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой чулуун дарааст булш зэрэг археологийн малтлага судалгааны баримт хэрэглэгдэхүүнтэй яв цав тохирч байдаг билээ.

XIII-XIV зууны монголчуудын чулуун хөргийн холбогдох он цагийг Түрэгийн хаад язгууртны тахилын онгоных шиг яв цав тогтоох бичгийн баримт байхгүй ч, эдгээрт дүрсэлсэн малгай, дээл, гээг

үс, зарим гоёл чимэглэлийн зүйлс зэрэг дүрсэлвэрт үндэслэн заримынх нь цаг хугацааг нарийсган тодотгох боломжтой байдаг.

## **ЭРТНИЙ ХӨШӨӨ ДУРСГАЛ БА МОНГОЛ НУТАГ ДАХЬ ХҮН ЧУЛУУДЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ**

Балар эртний цагаас л хүн хэмээх амьтан өөрийн гэсэн гэр бүл, овог аймаг, багаж зэвсэг, оромж сууцтай байхыг хичээж, түүнийгээ бүтээн бий болгох, хадгалан хамгаалах, хөгжүүлэн уламжлахад бүхий л хүч хөдөлмөрөө зарцуулсаар хожим нь тэр нь тэдний амьдралын түүх, дурсамж, алдар гавьяа, нэр төр болон үлддэг байсан бизээ. Тиймээс ч хүн хойч үедээ өөрийн эсвэл өмнөх үеийн түүхээ үлдээн сануулах ямар нэгэн зүйлийг нийтийн өмнө бүтээн босгохыг хичээж ирсэн нь өнөөдрийн бидэнд хадгалагдан ирсэн хөшөө дурсгал, барилга байгууламж, булш бунхан юм.

Энэхүү эрт цагийн хамгийн үнэ цэнтэй, дэлхийн өнцөг булан бүрт ихэнхи тохиолдолд хоорондоо үл хамаарах байдлаар үүсэн бий болж, хөгжиж ирсэн дурсгалын нэг бол яах аргагүй хүн чулуун хөшөө юм. Хоорондоо үл хамаарах байдлаар хэмээн онцлон тэмдэглэсний учир бол НТӨ I-III зууны Өмнөд Америкийн Сан Агустины хүн чулуун хөшөөд болон Ромын эзэнт гүрний гантиг чулуун баримал, XII-XIV зууны Полинезийн арал дахь аварга хөшөөд болон Дорнод Монголын тал нутаг дахь Монгол гүрний чулуун хөрөг хоорондоо огт хамааралгүй хэдий ч алс холд орших тухайн бүс нутгийн ард түмэн нэгэн ижил хүсэл зорилго, нэгдмэл агуулгын дор нэгдэж эдгээр гайхамшигт бүтээлийг бүтээсэн гэдгийг хэлэх гэсэн санаа билээ.

Монгол орны газар нутаг өргөн уудам бөгөөд олон төрлийн байгалийн бүс бүслүүр, уул нуруудын тогтоц, том голуудын ай савд хуваагддаг нь түүхийн урт хугацаанд угсаа гарал өөртэй уугуул иргэд

тархан амьдрахын зэрэгцээ хол ойрын овог аймгууд ч нүүдэллэн ирж, уусан нийлэгжих, түрэгдэн буцаж байсан нь дамжиггүй.

Манай улсын нутаг дэвсгэрт хамгийн эртний хүн чулуу бол Хэмцэгийн соёлын (НТӨ XXVII-XXI зуун) хүрээнд хамрагдах хоёр хүн чулуу мөн бөгөөд түүнээс дунджаар 1000 гаруй жилийн дараа холбогдох хиргисүүрийн соёлынхон (НТӨ XIV-VIII зуун) баатарлаг эрсдээ зориулан бугын дүрсээр чимэглэсэн хөшөөдийг босгож, зарим нь царай зүсийг нь хүртэл сийлж эхлэв. Энэхүү хоёр дурсгал нь ойролцоогоор 3000 жилийн туршид үргэлжилсэн хүрэл зэвсгийн үед хамаарна.

Хүрэл зэвсгийн үеийн хүн чулуу (НТӨ 2600-2000 он)	2
Хүннүгийн үе (НТӨ III – НТ I зуун)	
Сяньбигийн үе (II-IV зуун)	
Жүжаны үе (IV-VI)	
Түрэгийн үеийн хүн чулуу (VI-VIII зуун)	628
Уйгурын үеийн хүн чулуу (VIII-X зуун)	12
Хятаны үеийн хүн чулуу (X-XII зуун)	1
Монголын үеийн хүн чулуу (XIII-XIV зуун)	74
	717

*Монгол нутаг дахь хүн чулууны хөгжил, тоон үзүүлэлт*

Хэмцэгийн соёлынхоны хүн чулуу хийх уламжлал магадгүй НТӨ II мянганы үед холбогдох Уулын Алтайн Караколь, Хакасын Окунев, Алтайн Елунины соёлтой холбоотой байж болох бөгөөд үүнийг Караколь, Окуневын соёлынхоны хүн дүрсэлсэн хөшөө чулуу босгодог эсвэл этгээд маягтай хүний дүрс сийлж зурдаг байсан зэрэг баримтаар урьдчилан таамаглах боломжтой юм.

Хиргисүүр-буган хөшөөний соёлынхон язгууртлаг давхарга, дайчин баатар эрсийн алдар гавьяаг мөнхлөх эсвэл овог аймгийнхаа алдар цуу, сүр хүч, газар нутгийн хил хязгаарыг тунхаглах зорилгоор нарийн бүтэц зохион байгуулалттай нүсэр чулуун байгууламж буюу хиргисүүрийг байгуулж, ур хийц бахдам, агуулга, утга, зан үйлийн хувьд далд сүрлэг хөшөөг мөн босгож байв. Энэхүү гайхамшигт цогцолбор байгууламж нь бүхэлдээ хувь хүн эсвэл бүлэг хүмүүст зориулсан тул зарим тохиолдолд хүний нүүрний дүрсийг хөшөөний орой, нүүрэн талд цоолборлосон нь археологийн эх хэрэглэгдэхүүнд бүртгэгдсэн байдаг. Иймээс бид энэхүү дурсгалыг Хүн чулуу хэмээх дурсгалын танилцуулга дотор цухас дурдаж байгаа энэ билээ.

Ийнхүү барагцаалбал буган хөшөөнөөс хойш нэг мянганы дараа Түрэг угсааны овог аймгийнхны дунд үхэгсэдэд зориулан хүн чулуун хөшөө босгодог уламжлал хүчтэй дэлгэрч эхэлсэн байдаг. Яагаад ингэж гэнэт хүчтэй тархах болсон шалтгааны талаар судлаачид нэг байр сууринд очоогүй хэвээр байна. Бидний хувьд хөрш зэргэлдээ суурьшмал иргэдийн соёлын нөлөө болон тэдний тахил тайлгын өвөрмөц ёс заншлын нийлбэрээс энэхүү дэлгэрэлт эхэлсэн болов уу хэмээн таамаглаж байна. Түрэгийн хүн чулуу нь хэлбэр хийц, загвар, дүрслэвэрийн хувьд өвөрмөц бөгөөд өөрийн гэсэн тогтсон дэг жаягтай хөгжиж ирсэн нь дараа дараагийн нүүдэлчдийн чулуун урлагийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан хэмээн үзэж болно.



Хүрэл зэвсгийн үеэс Түрэгийн үе хүртлэх мянга орчим жилийн хугацаанд нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү гүрэн байгуулагдаж, улмаар Сяньби, Жужан улс ээлж дараалан оршин тогтнож байсан хэдий ч тэдэнд хүн чулуу хийх уламжлал байсангүй. Энэхүү Түрэгийн тахил тайлгын байгууламж барьж, хүн чулуу босгодог уламжлал монгол угсааны төрт улсуудад байгаагүй нь тэдний угсаа гарал, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл өөр байсныг харуулах нэгэн баримт бололтой.


Мөн Уйгур, Хятаны үед холбогдох хүн чулуу харьцангуй цөөн, тархалтын хүрээ явцуу байгаа нь тухайн улсуудад хүн чулуу хийх уламжлал бага байсныг харуулах баримт хэдий ч энэхүү дүрслэлийн ялгамжтай талыг баримтласан ангилалыг дахин нягтлаж, байгалийн шинжлэлийн болон бусад шинжлэх ухааны дэвшилтэт аргаар он цагийг илүү тодруулах ч шаардлагатай ч байж магадгүй юм.

Ойролцоогоор 500 жилийн дараа тахилгын зан үйлд хүн чулуу босгох уламжлал Монголын эзэнт гүрний үед буюу тодруулбал Юан гүрний үед дахин сэргэжээ. Эзэнт гүрний үеийн хүн чулууны хэлбэр хийц, дүрслэвэр, утга санаа өмнөх Түрэгийн үеийн хүн чулуудаас харьцангуй ялгаатай болохыг дээр өгүүлсэн. Харин тархалтын хүрээ нь Дорнод Монголын тал нутаг буюу манай улсын зүүн урд тал руу илүү нягтралтай байх бөгөөд баруун тийшлэх тусам сийрэгжих хандлагатай. Энэхүү тархалтын нягтрал болон Юан улсын нийслэл Шанд хот хүртлэх зай, тэнд байгаа ижил хийцтэй хүн чулууд зэрэгт тулгуурлан тэдгээр нь Алтан урагийн язгууртнууд болон тухайн бүс нутгийн зонхилгоч нарт зориулсан тахилгын зан үйлийн байгууламж хэмээн судлаачид үздэг байна. Мөн ур хийц, хээ чимэглэл, дүрсэлвэр, чулууны сонголт харилцан адилгүй байгаа нь мэдээж энэ нь зэрэг зиндаа, угсаа гаралтай шууд холбоотой ажээ. Эцэст нь тэмдэглэхэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин

амьдарч байсан эртний овог аймаг, соёлын нийтлэгүүд болон төрт улсаа цогцлоон байгуулсан түрэг, монгол угсаатнууд дэлхийн соёлт ард түмнүүдийн нэгэн адил алдар цуут хаад язгууртан, баатар эрс болон онцгой нэгнийхээ дурсгалыг хүндэтгэн хөшөө дурсгалыг нь босгон үеийн үед мөнхжүүлэн үлдээж байсан нь өөр өөрийн өвөрмөц дүр төрх, ур хийц, утга агуулга бүхий гайхамшигт чулуун барималууд бэлхэнээ харуулж байна.

ТАВ.

ГЭРЭЛТ ХӨШӨӨ



## СУДАЛГААНЫ ТОЙМ

Балар эртний үед хүмүүс хоорондоо хэл яриагаар өөрсдийгөө бүрэн илэрхийлж байсан хэдий ч харин нүүр тулан харилцах боломжгүй үед бие биенээ ойлгох шаардлагын улмаас бичиг үүссэн хэмээн судлаачид үздэг байна. Бичиг үсэг үүсэхээс өмнөх үеийн хадны зургууд нь тухайн үеийн хүмүүс хэрхэн аж төрж, юу бодож сэтгэж, хүсэж мөрөөдөж байсан талаарх үнэтэй мэдээллийг агуулахын зэрэгцээ тэдний шүтлэг бишрэл, урлаг соёл, оюун санааны илэрхийлэл болон бидний үед улбаалан иржээ.

Дэлхий дээрх бичиг үсгийн үүсэл гарлыг зураг бичиг буюу пиктограф (pictography)-аас эхтэй

хэмээн үздэг. Энэ нь юмс үзэгдэл түүнийг төлөөлөн бэлгэдсэн зургаар бие биедээ ойлгуулах бичгийн тогтолцоо бөгөөд зарим тохиолдолд түүнийг дүрс бичиг хэмээдэг. Зураг бичиг нь мэдээж тодорхой бодит биет зүйлийг илэрхийлэх бүрэн боломжтой хэдий ч хийсвэр ойлголтыг тэмдэглэхэд учир дутагдалтай байжээ. Энэ



*Хүйс толгойн гэрэлт хөшөө*

бүхэн утга бичиг (ideagraphy), авианы бичиг (phonography) хэмээн хөгжлийн үе шатыг дамжин тодорхой нэгэн нутгийн аялгат суурилж, түүний түгээмэл шинжийг агуулан, зөв бичих болон дуудах дүрэм, баялаг үгийн сантай, тухайн хэлний нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аялгуугаар ярилцагч нарт ойлгомжтой, тэдний харилцааны гол хэрэглүүр болон үйлчлэх бичгийн хэл бий болсон хэмээн үздэг.



*Билгээ хааны гэрэлт хөшөө.  
Архангай аймаг, Хашаат сум,  
Хөшөө Цайдам*



*Куль-Тегин жанжны гэрэлт хөшөө.  
Архангай аймаг, Хашаат сум,  
Хөшөө Цайдам*

Бичиг үсэг нь хүн төрөлхтний түүхэнд Месопотами, Египет, Индусын соёл иргэншил, нам дор газар Месоамерик, Хятад зэрэг улсуудад дор хаяж таван газар бие даан хөгжиж байжээ. Бичиг үсгийн хамгийн эртний баримтыг НТӨ 2600 оны орчимд холбогдох Шумерын хавтан (Sumerian tablet), Шуруппак (Shuruppak) хэмээн үздэг. Харин бичгийн харилцааны хамгийн эртний хэлбэрүүд нь НТӨ 3500-3000 оны орчмын Месопотамийн өмнөд хэсэгт орших Шумерүүдээс гаралтай юм. Үүнтэй зэрэгцэн НТӨ 3200 он орчимд Египет, харин түүнээс мянга орчим жилийн дараа буюу НТӨ 2500 он орчимд Индусын соёлд бичиг үсэг бий болжээ. Харин НТӨ 1500

он орчимд Хятадад дүрс бичиг үүсэн бий болсон бол мянга гаруй жилийн дараа буюу НТӨ 250 он орчимд Төв Америкт бичиг үсэг үүссэн байна.

Манай улс дэлхий дээрх эртний бичиг соёлын өлгий нутгуудын нэг бөгөөд одоогоор брахми, согд, руни, уйгур, хятан, зерчид, монгол, нангиад, сири, араб, перс, төвөд, санскрит, дөрвөлжин, тод, манз, ланз, соёмбо, вагиндра зэрэг хорь гаруй үсэг бичгийн олон арван дурсгал илэрч түүх, хэл соёлын судлалд чухал сурвалж, эх хэрэглэгдэхүүн болсоор байгаа юм.



*Мэргэн сайд Тоньюукукын гэрэлт хөшөө. Төв аймаг, Баянцогт сум*

Олон зууны туршид монгол хэлийг бичит буулгах төрөл бүрийн системүүд зохиогдсоор ирсэн байна. Монгол хэлэнд зориулж бүтээгдсэн, хамгийн их амжилт олсон, хамгийн урт үргэлжилсэн бичиг бол яах аргагүй Монгол бичиг юм. Монгол бичиг үсэг нь уг гарлаараа эртний Финикид (Ойрхи Дорнодын) анх үүссэн финикийн бичгийн системд хамаарагдах бичиг үсгүүдийн нэг байжээ. Учир нь финикийн бичиг үсгээс арамей бичиг үсэг, түүнээс согд бичиг, түүнээс уйгур салбарлан гарч улмаар согд, уйгур бичиг үсгээс монголын уйгуржин хэмээн бичиг үсэг бий болсон түүхтэй. Монгол аймгууд уйгуржин бичгийг чухам хэдийд авч хэрэглэх болсон тухай асуудлаар эрдэмтдийн дотор олон таамаг саналууд байдаг.



Гэхдээ Монголд уйгуржин буюу монгол бичиг хэрэглэх болсон нь XIII зууны эхэн үе хэмээн ихэнхи эрдэмтэд үздэг. Энэ санал нь Мэргэн гэгээний “Алтан товч”, “Юан ши” түүхийн 124-р бүлэгт нэгэн домгийн чанартай мэдээнд тулгуурлажээ. Тэр домогт Чингис хаан Найман аймгийг байлдан дарах үеэр (1204) Таян хааны бичгийн сайд Тататунгаг хааных нь тамганы хамтаар олзлон авч бичигтэй тамганы учрыг асуун мэдээд уул тамгыг төрийн хэрэгт хэрэглэх болсон ба мөн уйгуржин бичгийг ноёд, түшмэдэд зааж сургахыг Тататунгад тушаасан гэдэг. Энэ мэдээ монгол аймгуудын дунд монгол бичиг хэрэглэх болсонтой шууд холбож үзэх нь учир дутагдалтай, харин Чингис хаан найман, уйгур айгуудын бичгийн хүмүүсийн тусламжтайгаар уйгуржин үсгийг анх нийт монгол улсын албан бичиг болгосонтой уялдуулбал илүү үнэнд нийцэх бизээ.

Мөн XIII зуунаас өмнө монгол аймгуудын дунд бичиг үсэг байгаагүй гэж үзвэл учир дутагдалтай. Ямартай ч энэ үед монгол бичиг улсын албан бичиг болох цагт уйгуржин үсгээр бичигдэж байсан бөгөөд нэгэнт хэвшсэн эртний монгол бичгийн хэл байсан нь эргэлзээгүй юм. Ийм бичгийн хэл бүрэлдэн бий болоход бичиг үсгийн түүхийн олон зуун жилийн хөгжил шаардагдах бөгөөд магадгүй согд, уйгурчууд мандан хөгжиж Монголд нөлөөтэй байсан байсан үеэс хэрэглэгдэх болсон байж болно. Харин Монгол гүрний үед уйгуржин бичиг сая улс нийтийн албан бичиг болжээ хэмээн эрдэмтэд тайлбарласан нь бий.

Энэ үйл явдлаас нилээд хожим 1269 онд Хубилай хааны зарилгаар төвөдийн Пагва лам Лодойжалцан дөрвөлжин бичгийг зохиосон байна. Дөрвөлжин бичиг хэлбэр дүрсийн хувьд төвөд үсэгт, зурлага бичлэгийн хувьд Монгол бичигт тулгуурласан 44 үсэг бүхий авианы цагаан толгойт бичиг юм. Дөрвөлжин бичиг нь Юань гүрнийг мөхөх хүртэл албан бичиг болгож хэрэглэгдэж байгаад хожим нь тодорхой

хүрээнд, тодорхой зорилготой хэрэглэгдсээр байсан юм.

1587 онд Харчины Аюуш гүүш эрт цагийн соёлын харилцаа холбоотой байсан Энэтхэг, Төв, Хятад зэрэг дорно дахины хэл соёлын нөлөөгөөр монгол хэлнээ харь үг олонтаа орж ирэх болж, тэдгээрийг тэмдэглэх үсэг хэрэгтэй болсон тул галиг үсгийн Алигали (али-эгшиг, гали-гийгүүлэгч гэсэн санскрит үг) тогтолцоог бий болгосон байна. Энэ нь 16 эгшиг, 34 гийгүүлэгч үсэгтэй байсан юм.

1648 онд Ойрадын лам Зая Бандид Намхайжамц тод бичгийг зохиов. Монгол бичгийг жинхэнэ аялгатай нь ойртуулах, мөн төвөд ба санскрит хэлний үгнүүдийг хялбар бичих зорилготой зохиогдсон хэмээн үздэг. Мөн тод бичиг хэмээн нэрлэсэн нь Монгол бичгийг илүү тодорхой, нарийн болгосонтой холбоотой ажээ. Энэхүү бичгийг 1920-иод он хүртэл Халимагууд хэрэглэж байсан бол харин одоог хүртэл Шинжааны ойрадууд хэрэглэдэг байна.

1686 онд Өндөр гэгээн Занабазар монгол, санскрит, төвөд үг бичихэд зориулан энэтхэг, ланз, нагар үсгүүдээс гаралтай 90 үсэг бүхий Соёмбо хэмээх үсгийг зохиожээ. Энэхүү үсгийг ихэвчлэн Халхын хүрээ хийдийн барилгын чимэглэлд хэрэглэж байсан байна.

1905 онд буриадын лам Агваандорж монгол, тод үсэгт тулгуурлан буриадын Вагиндра хэмээх шинэ үсгийг зохиосон байна. Вагиндра үсэг монгол болон тод бичгүүдээс үгийн эхэн, дунд, адагт орох үсгийн дүрс хэлбэр хувирахгүйгээрээ ялгаатай ажээ.

## ГЭРЭЛТ ХӨШӨӨ

Манай улсын хувьд хамгийн эртний бичгийн дурсгал буюу гэрэлт хөшөө бол Булган аймгийн Могод сумын нутаг Хүйс толгой хэмээх газрын тахилгын байгууламжид байсан бичээс юм. Энэхүү бичээс нь нийтийн тооллын 630-аад оны үед холбогдох бөгөөд Түрэгийн хаант улсын эхэн үед хааны тахилганд зориулсан бичээст Түрэгийн


хааны нэр цол гарах төдийгүй түүнээс ч өмнөх цагийн Монголын эртний төрт улс Жужаны Анахуйн хааны нэр дурдагддаг байна. Мөн Хүйс толгойн бичээс нь одоогоор монгол хэлний хамгийн эртний түүхэн баримт гэдгээрээ үнэ цэнэ бүхий гайхамшигт нэгэн дурсгал



*Мөнх хааны гэрэлт хөшөө.  
Хөвсгөл, Арбулаг*

юм. Энэхүү хөшөө нь 154 см өндөр, 41 см өргөн, 15 см зузаан хэмжээтэй, 11 мөр бичээстэй ажээ.

Түрэг бичээстэй гэрэлт хөшөөний хамгийн томоохонд 732 онд бүтээгдсэн Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамын хөндийд орших Түрэгийн нэрт жанжин, Куль-Тегин, Төв аймгийн Баянцогт сумын Баянзүрх уулын бэлд босгосон Түрэгийн хааны зөвлөх сайд Мэргэн Тоньюкук, 734 онд Хөшөө Цайдамын хөндийд Куль-Тегин жанжны гэрэлт хөшөөний дэргэд сүндэрлэсэн Билгэ хааны гэрэлт хөшөө, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь 740 он орчимд босгосон Тардуш түмний ноён Кули-Чурын гэрэлт хөшөө, 759 онд бүтээгдсэн Булган аймгийн Сайхан сумын нутаг Хиргисийн хөндий дэх Уйгурын хаан Моюун-Чурд зориулсан гэрэлт хөшөөд зэргийг нэрлэж болно. Эдгээрээс гадна Архангай аймгийн



*Хэсэг байшингийн гэрэлт хөшөө.  
Дорноговь, Их хэт*

Их Тамир сумын нутаг дахь Бугатын “Чонон хөшөө”, Увс аймгийн Түргэн сумын нутаг дахь Долоодойн түрэг, уйгур бичээст хөшөө, Өвөрхангай аймгийн Уянга сумын Онгийн түрэг бичээс, Архангай аймгийн Тариат сумын Тариатын хөшөө зэрэг олон гэрэлт хөшөөд бий.

Эдгээрээс Билгэ хааны гэрэлт хөшөөг ялимгүй дэлгэрүүлэн авч үзье. Билгэ хааны хөшөө гэж алдаршсан энэхүү дурсгал Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөгшин Орхон голын зүүн эрэг Цайдам нуурын өмнө Куль-Тегинд зориулан босгосон гэрэлт хөшөөнөөс зүүн урд 1 км зайтай оршдог. Хөшөөний өндөр нь 3,45 м, өргөн нь 1.74 м, зузаан нь 0.75 м. Куль-Тегины жанжны хөшөөнөөс ялимгүй өндөр, мөн өргөн хэдий ч арай нимгэн чулуу ашиглан хийсэн байдаг. Хөшөө гурван талдаа түрэг бичээстэй бөгөөд өргөн талын ард Тан улсын хааны бичүүлсэн хятад бичээс бий.

Билгэ хааны хөшөөний бичээсийг XIX зуунаас Н.М.Ядринцев, Г.Гейкель, В.В.Радлов нар судлан шинжилж эхэлсэн бол түрэг бичээсийг тайлж судлах ажилд В.Л.Котвич, Б.Я.Владимирцов, С.Е.Малов, Н.Оркун, Т.Текин, И.В.Стреблева, Г.Айдаров, А.Н.Кононов, С.Т.Кляшторный зэрэг олон эрдэмтэд өөрсдийн хувь нэмрийг оруулжээ.

Элтерес хааны хүү Могилян нь 683 онд төрсөн бөгөөд 716 онд Түрэгийн хаан ширээнд “Билгэ” цолтойгоор суусан юм. Билгэ хаан нь дотооддоо түрэгийн харъяанаас гарсан овог аймгуудыг ухуулан дагуулах, эс зөвшөөрснийг зэвсгийн хүчээр нэгтгэх бодлого явуулж байсан бол гадаад бодлогын хүрээнд Хятад зэрэг хөрш зэргэлдээ орнуудтай найрамдалт харилцаа тогтоон хилийн худалдаа хөгжүүлэхийг эрмэлзэж байжээ. Тэрээр төрийн бүтцийг бэхжүүлэх, эдийн засаг, соёлыг хөгжүүлэхэд ихэд хүчин зүтгэсэн тухайн үеийн улс төрийн томоохон зүтгэлтэн байсан хэмээн үздэг. Билгэ хаан 734

оны 11-р сарын 25-нд нас барж, 735 оны 6-р сарын 22-нд тахилын сүм барьж гэрэлт хөшөө босгосон байна.

Гэрэлт хөшөөний эхний хэсэгт, "... Тэнгэрээс ивээлт тэнгэрлэг Түрэгийн Билгэ хаан миний үг: Дээд хөх тэнгэр, доор бараан дэлхий үүдсэний завсар хүний хөвүүд буй болсон ажгуу гээд дээд өвөг Буман хааны байгуулсан улс, түүний алдар гавьяаг тоочин өгүүлж Могиляныг тэнгэрээс заяагдсан түрэгийн Цэцэн хааны ширээнд суухад тогуз огузыг сүсэлдэг алдарт эр бэги хараат олон бүгд хуран, баярт нүд нь хаан ширээ рүү хандан баясцаасан тэр үест хатуу засаглалыг дөрвөн зүг найман зовхисын ард түмэнд тогтоосон, Билгэ хаан 17 насандаа Тангуд руу, 18 насандаа Алты Чубад мөн Табагачийн Он ок Тутукийн таван түмэн цэрэгтэй Ыдук башид тулалдан дийлсэн, 26 насандаа Чик, 28 насандаа Кырк Аз руу довтолж улмаар улсыг хурааж авсан, 31 насандаа Карлукийн ард түмнийг эзлэн авч Тогуз Огуз нар харьяат болсон тухай, Магы Курганд өвөлжихөд зуд болсон, мөн Уйгурын Элтибер зуу хэрийн эрийг дагуулан умар зүг зугтан одсон, гучин дөрвөн настай байхад нь Огузууд, Татабичууд Табагачийн харьяат болж нэгдсэн, тэднийг дайлж эгүүлэн нэгтгэхэд нь эгэл ардууд хаан ирлээ хэмээн магтацгааж байсан" тэргүүтнийг дэлгэрэнгүй тоочин өгүүлжээ.

Бичээсийн хоёрдугаар хэсэгт, "Табагачийн морьт цэргийг тулааны эхний өдөр, явган цэргийг нь дараагийн өдөр бут цохисон тухай, 38 насныхаа өвөл нь Хятан уруу цэрэглэн, 39 насныхаа хавар нь Татабид дайлаар орсон, Кут сенүнээр удирдуулсан дөрвөн түмэн цэргийг Түнкэр ууланд бут цохисон хийгээд 19 жил хаан сууж төрийг барьсан, хаан эцэг нь нохой жилийн аравдугаар сарын зургаанд халин одсон, түүнийг гахай жилийн тавдугаар сарын хорин долоонд нутаглуулсан, уг хойллогод Лу-сүн-Тайгаар тэргүүлүүлсэн 500 эр цэрэг ирж алт мөнгө эд агуурс арвин ихээр өгсөн тухай, Могилян

Билгэ (Цэцэн) хаан хэмээн алдаршиж хаан ширээнд суусан, хаан ширээнд суухад дөрвөн зүг, найман зовхисын ард түмэн бег ноёд хуран цугларч агуу их магтаал хийсэн” тухай дурджээ.

Бичээсийн гуравдугаар хэсэгт, “Хаан эцэг нь тэнгэрийн ивээлээр хаан ширээнд сууж толгойтныг бөхийлгөж, тойгтныг сөгдүүлж дөрвөн зүг, найман зовхисын ард түмэнд хатуу чанга засгийг тогтоон Түрэг улсыг төвхнүүлсэн, улмаар насан өндөр болж өөд болсон, Табагачийн чимэглэгчид ирж хөшөөний бунханг чимэглэсэн” тухай өгүүлсэн байна.

Харин гэрэлт хөшөөний дөрөвдүгээр хэсэгт, “Билгэ хааны хөшөөний үгийг түүний ач Йолиг-Тегин нэг сар дөрвөн өдөр суун бичиж чимсэн газраа тогтоон соёрхуулснаа” товч дурдаж төгсгөсөн байна.

Гэрэлт хөшөө нь өмнө дурдсанчлан хаад, язгууртан, цэргийн жанждын суу алдарыг магтан дуулж, тэдний хийсэн үйл хэрэг, байгуулсан гавьяаг алдаршуулах зорилготой тул ерөнхий утга санаа, өгүүлэмж төстэй байдаг. Гэхдээ гэрэлт хөшөөний бичээс дэх түүхэн он цагийн дараалал, овог аймаг, улс гүрний гадаад, дотоод харилцаа, тухайн төрт улсын зохион байгуулалтын талаарх мэдээлэл нь үнэлж баршгүй чухал эх сурвалж болохын зэрэгцээ хөрш зэргэлдээ улс гүрнүүдийн бичгийн сурвалжийн мэдээ, археологийн биет олдвор, эх хэрэглэгдэхүүнийг харьцуулан дүгнэх томоохон боломж хэмээн судлаачид үздэг.

Түрэг гаралт ард түмнүүдийн босгосон гэрэлт хөшөөдөөс хойш 500 гаруй жилийн дараа Монголын Эзэнт гүрэн байгуулагдаж мөн л төрт уламжлалын дагуу суу алдарт түүхээ мөнхжүүлсэн гэрэлт хөшөөдөө босгож иржээ.

Энэхүү түүхэнд холбогдох хамгийн алдартай гэрэлт хөшөө бол Чингисийн чулууны бичиг юм. Хэдийгээр энэхүү гэрэлт хөшөө нь хойд хөршийн нутгаас илэрч, эдүгээ Санкт-Петербургийн Эрмитажид





*Амарбаясгалант хийдийн  
гэрэлт хөшөө.  
Сэлэнгэ, Баруунбүрэн*

хадгалагдаж байгаа хэдий ч Монголын уран бичлэгийн буюу калиграфийн монгол бичгээр бичиж үлдээсэн хамгийн эртний дурсгалын нэг учир энд дурдав. Гэрэлт хөшөөний бичээсийн ерөнхий утга нь, Монголчууд Хорезм улсыг байлдан дагуулсан аян дайнаас буцах замдаа Эрчис мөрний эрэгт зусаж Их Монгол улсын ноёдын хуралдай хуралдуулан өргөн дэлгэр хурим найр хийсэн аж. Хуралдайн үеэр Есүнгэ /1190-1270/ мэргэн 335 алд газарт бай харван оножээ. Түүний энэхүү хосгүй мэргэн харвасан алдрыг нь дуурсган хөшөө дурсгал босгосон нь хожмоо “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдаршсан билээ. Ингэж нэрлэх болсон учир гэвэл бичээсийн тэргүүнд Чингис хааны нэрийг мөр тэтгэн бичсэн байдагтай холбоотой. Гэрэлт хөшөөг 1224 он юмуу,

эсхүл 1225 оны үед босгосон гэж судлаачид үздэг.

“Чингисийн чулууны бичиг”-ээс 30 гаруй жилийн дараа буюу 1257 онд босгосон нэгэн гэрэлт хөшөө Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэр мөрний хойд хөвөө Алтан гадас уулын ар талд хулширсан нэгэн балгасанд байжээ. Энэхүү балгас нь хааш хаашаа 100 гаруй м хиртэй урт хашаа хэрэм байсан бололтой гүвгэр газар аж. Түүний гол дунд хааш хаашаа 30 м орчим хэмжээний дөрвөлжин хэлбэртэй томоохон орон барилгын буурь, дэрсэн дунд баганын суурь зургаан том засмал дөрвөлжин боржин болон углуургатай хүрэн боржин хэд хэд цухуйж ажиглагддаг. Балгаснаас урагш 40 м орчим зайтай

овгор дэрсэн дотроос цухуйж байсан хавтгай хөх чулууг түшлэг гэдэг байсан нь Мөнх хааны монгол, хятад бичигтэй хөшөө байжээ. Уг хөшөө сайхан цамхаг орон савын дотор оршиж байсан шинжтэй бөгөөд малтлагаар ногоон паалантай ваараар хийсэн, монгол хувцастай хүний жижиг цээжин баримал дүрс, ховилтой хөх ваар гэх мэт олон янзын ваар тоосго элбэг гарчээ.

Түүнээс гадна Мөнх хааны хөшөөний баруун өмнө

8-10 км зайтай газар хэрэм цайз бүхий том хот балгадын үлдэгдэл байдаг бөгөөд үүнийг Загзуугийн балгас буюу Эрчимийн балгас гэдэг. Иймд энэ нь хуучин монгол сурвалжид нэр гардаг Юань улсын үеийн Эрчүүгийн балгас мөн бололтой гэж үздэг. Мөнх хааны хотын буурь турийг 1953 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс томилон илгээсэн О. Намнандорж ахлагчтай орон нутаг судлах аяллынхан анх илрүүлэн олж гүймэг судлан XIII зууны үед холбогдохыг түүхэн эш баримтад тулгуурлан тодорхойлсон байна. Түүхэн тэмдэглэлээс үзэхэд XIII зууны үед Монголд айлчлан ирсэн Франц жуулчин Гильом де Рубрук Мөнх хааны ордонд буудаллаж хэсэг саатсаны эцэст арав хоног явж Хар Хорум хот хүрсэн байдаг билээ.

Судлаачид гэрэлт хөшөөний монгол бичээст "... Мөнх хаан түмэн



*Дамбадаржаа хийдийн  
гэрэлт хөшөө.*

*Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг*

түмэн насалтугай хэмээж ..." гэсэн үг буйг уншаад уг хөшөөг Мөнх хааныг амьд байх үест босгосон болохыг нотолжээ. Улмаар судлаачид хятад бичээсийг уншсанаар үүнийг 1257 онд босгосныг лавтай тод-руулсан хэмээдэг.



*Улаанбаатар, Монголын Үндэсний номын сан  
Данжуурын гэрэлт хөшөө*

Мөнх хааны гэрэлт хөшөөнөөс даруй 90 орчим жилийн дараа буюу Юань гүрний жинжин зургаадугаар он (1346 он)-д сүүлчийн хаан Тогоонтөмөрийн зарилгаар Их Монгол улсын нийслэл Хархорум хотод нэгэн гэрэлт хөшөө босгосон баримт бидний үед хүрэлцэн ирсэн юм. Гэвч энэхүү гэрэлт хөшөө бүрэн бүтэн уламжлагдаагүй бөгөөд хэд хэд хагарснаас дөрвөн хэсэг нь үлдэж хоцорсон байдаг. Эрдэмтэд Хятад Улсын түрэмгий цэрэг 1380 онд Хархорум хотыг эзлэн шатаахад уг хөшөө эвдэрсэн бололтой хэмээн үздэг байна. Гэрэлт хөшөөнд тухайн үеийн Хархорум хотод сүм хийд шинээр барьж байгуулан, түүний ач тусын талаар өгүүлсэн байдаг. Тухайн үед Хархорум хотод дээр дурдсан гэрэлт хөшөөнөөс өөр нилээд олон гэрэлт хөшөө байсан хэдий ч харамсалтай нь хожим XVI зууны сүүлчээс эхлээд Эрдэнэзуу хийд, түүний дотуур

гадуур хэрмийг барихад ашигласан байдаг. Судлаачид эдгээр барилгын материал болсон гэрэлт хөшөөний хугархай, хэлтэрхий зэргийг боломжийн хирээр нягтлан судалж, судалгааны эргэлтэнд оруулсан нь XIII-XIV зууны үеийн монголын, түүний дотор ялангуяа уугуул монгол орны соёл, нийгэм, улс төр, эдийн засгийн байдлыг судлахад чухал сурвалж хэрэглэгдэхүүн болсоор байна.

Юань гүрний сүүлийн он жилүүд болон түүнээс хойших он цагт хамаарагдах хэд хэдэн гэрэлт хөшөөд байдаг бөгөөд тэдгээрээс Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг, Бүсийн чулуунд орших Хэсэг байшингаас олдсон олон хэсэг болон хугарсан хөшөөний талаар товч өгүүлбэ.

Анх 1923 онд Оросын эрдэмтэн В.А.Казакевич, Монголын эрдэмтэн, зохиолч Д.Нацагдорж нар илрүүлэн олж, хэв хуулга авахын зэрэгцээ дурсгалыг хамгаалалтанд авах талаар санаачлага гаргаж байсан байна. Хожим 1961 онд Х.Пэрлээ бичээсийг уншиж, нийтлүүлжээ. Уг хөшөөг 1659 онд Монголын Эрдэнэ хун тайжийн хатан нэгэн тайжид зориулан босгожээ. Гэрэлт хөшөөний бичээсийн агуулга нь XVII зууны эхээр Өвөрмонголын авга, авга нар, үзэмчин хуучид, сөнид аймгийн ноёд Лигдэн хааны бүх монголыг нэгтгэх үйл ажиллагааг эсэргүүцэн халхын Сэцэн ханы нутагт нүүн ирж Хэрлэн голын дунд урсгал хавиар хэсэг хугацаанд нутаглаж байсан тухай болон XVII зууны эхээр халхын зүүн өмнө нутагт Хавтгай хэмээх тэмээн гөрөөс элбэг нутаглаж байсан учир түүнийг агнах тухай хууль тогтоож байжээ. Мөн Батмөнх даян хааны үед Монголын ноёдын хоорондын хямрал, тэмцэл хэсэг хугацаанд намдаж Хятададтай найртай харилцах болсон талаар болон Батмөнх хаан сууснаас хойш 150 гаруй жил болоод Өвөр монголд хямрал дахин хурцадсан талаар дурдсан байна. Түүнээс гадна Лэгдэн хаанаас зугтааж халхад ирсэн Хуучид аймгийн хэсэг хүмүүсийг Эрдэнэ номч, Болд нар тэргүүлж

байсан тухай дурдахын зэрэгцээ IV Далай лам Ёндонжамц нь Чингис хааны удмын Сүмэр хун тайжийн хүү бөгөөд түүний эх нь Хавтхасарын угсааны хүн байсан талаар тодорхой өгүүлсэн байна. Эцэст нь гэрэлт хөшөөг босгоход тэр үед Өвөр монгол-лоос халхад ирээд байсан хуучдын Эрдэнэ хун тайж Дэгэлэйн харьяат зургаан аймаг, мөн авга, тавнан аймгийнхан оролцсон, Эрдэнэ хун тайжийн хатан нь Анудара гэгч байсан болон ер нь гэрэлт хөшөөг босгосны учир нь түүнийг байгуулагчдын энэ ба хойд насаа бодсонтой холбоотой тухай юм.

Энэ үеийн гэрэлт хөшөөдийн дотор Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг Бүрэнхан уулын өвөр, Ийвэн голын хөндийд орших Амарбаясгалант хийдийг байгуулсан түүхийг тэмдэглэсэн 1737 онд босгосон хоёр гэрэлт хөшөөг нэрлэж болно. Эдгээр хөшөөг боржин чулуугаар үйлдсэн бөгөөд хөшөөний өндөр нь 3 метр хагас. Гэрэлт хөшөөний зарлигийн бичгийн агуулга нь Манжийн хаан цэргийн хүчээр Бээжинг эзлэж авснаар соёлыг бадруулах болсон хийгээд Халх Ойрад умар дахиныг эрхэндээ оруулсан болон Өндөр гэгээн Занабазар Энхамгалангийн 61-р он буюу 1722 оны өвөл хаанд бараалхахаар ирээд түүний хойд жил нас нөгцсөн тухай мөн уг хийдийг бариулахад хичнээн лан мөнгө орсон зэрэг тухай юм.

Мөн Улаанбаатар хотын нутаг Сэлбэ голын уулзварт буй Халхын анхны гурван хийдийн нэг Дамбадаржаалин (Шашныг бадруулагч сүм) хийд бий бөгөөд тэнд Манжийн Тэнгэр тэтгэсэн хаан Богд Жавзандамбын хоёрдугаар дүрийн шарилын суврагыг залах сүмийг Халхад байгуулах зарлиг буулгажээ. Уг зарлиг дагуу Чин ван Санзайдоржид Төвөд орны дуганы дүрмийн ёсоор газрыг үзэж байдлыг шинжилж гэрэлт үзэсгэлэнт сүм байрлуулахыг тушаажээ. Үүний дагуу сүм байгуулах газрыг "Халхын Хан уулны ойр байгч Сэлбэ нэрт газар нь олон хошууны төв дунд хэмээн сонгон авч

Тэнгэр тэтгэсний 30-р он хөхөгчин тахиа жил буюу 1765 онд сүмийг үйлтгүүлэн дуусгаж равнай өргөж Шашныг бадруулагч сүм хэмээн нэрийджээ. Энэ үйл явдалтай холбогдуулан мөн жил гэрэлт хөшөө чулуунд зарлиг сийлүүлжээ. Гэрэлт хөшөөнд сийлүүлэх зарлигийн үгийг монгол, манж, хятад, төвөд дөрвөн хэлээр бэлтгүүлж хоёр пайлуур чулууны ар өвөрт хоёр хоёроор нь тус тус сийлүүлж сүмийн гол хаалганы баруун зүүн хоёр талд байрлуулсан агаад байгалийн элэгдлээс хамгаалах зорилгоор дээр нь асар босгуулжээ.

Хамгийн хожим буюу XX зууны эхэнд холбогдох нэгэн гэрэл хөшөө бол Монгол улсын Дотоод явдлын яамны тэргүүн сайд, чин сүжигт да лам Цэрэнчимэдийн дурсгалд зориулж босгосон хөшөө юм. Энэхүү гэрэлт хөшөө Увс аймгийн Хяргас сумын нутагт бий. Монголчууд Манжийн олон жилийн дарлалаас гарч, тусгаар тогтнолоо эргүүлэн олох их тэмцлийг манлайлагчдын нэг Цэрэнчимэд байсан бөгөөд тэрбээр Монголын тусгаар тогтнолд үнэнч хүн байсан бөгөөд зөвлөх эрхтэй хоёр танхим бүхий Улсын хурал байгуулах санааг анх сэдэж Богд хаанаар зөвшөөрүүлж байжээ. Тэрээр олноо өргөгдсөн Монгол улсын баруун хязгаарыг тохинуулах сайдаар томилогдон явахдаа 1914 онд замдаа нас барсан юм.

Түүний дурсгалын гэрэлт хөшөө суурь, бичээс, малгайн гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Хөшөөний суурь нь 50 см өндөр, 88 см урт, 30 см-ийн өргөн. Сууринд суулгасан бичээс бүхий гол хэсэг 68 см урт, 23 см зузаан. Дээд малгайн хэсгийг эвэр угалзаар чимэглэсэн. Гэрэлт хөшөөний нийт өндөр нь 208 см. Худам монгол бичгээр дээрээс доош зургаан мөрөөр бичсэн бичээстэй. Уг гэрэлт хөшөөний бичээсийг сийрүүлвэл: “Их монгол улсын наран гэрэлт, түмэн наст богд эзэн хааны зарлигын сайд чин сүжигт да лам Цэрэнчимэд болбоос элдэв хэрэгт чармайн зүтгэж явсаар тулгар төр байгуулахад ихэд зүтгэн их гавъяа байгуулсан бөгөөд шашин



ба улсын төлөөнөө хичээгээд албанаа зүтгэн амь биеийг умартаж явсаар өвчнөөр үгүй болсон нь үнэхээр хөөрхий, миний дотор их л энэрэн үзэж нэхэж өргөмжлөн үнэн бишрэлт цол нэмэн шагнаж гэрэлт хөшөө чулуунд сийлгэж гавъяат сайд чиний их журмыг илэрхийлэв” хэмээсэн байдаг.

Бүүр хожим 1920-иод онд Монгол улсын Ардын гэгээрүүлэх яамны Судар бичгийн хүрээлэнгээс Өвөр Монголын Цахарын сүрэг хошууны Шашныг бадруулагч сүмд тахиж байсан монгол үсгийн Данжуур судрын бүрэн 226 боть нэг ижийг Нийслэл хүрээнд залсантай холбогдуулан босгосон нэгэн гэрэлт хөшөө босгож байжээ. Энэхүү “Наянт вангийн хөшөө” хэмээх гэрэлт хөшөөнөө хоёр талын хэлэлцэн баталсан гэрээний эхийг 1924 онд нэрт түүхч Н.Дэндэв сийлж дуусгасан байна.

Ийнхүү Монгол нутаг дээр оршин тогтнож байсан монгол, түрэг угсааны төрт улсууд нь дэлхийн соёлт ард түмнүүдийн нэгэн адил ихэс дээс, баатар эрс, түүхэн үйл явдлаа мөнхүүжлэх зорилгоор гэрэл хөшөө босгон өөрсдийн түүхээ хойч үедээ өвлүүлэн үлдээж байжээ. Энэхүү уламжлал нь Хүйс толгойн гэрэлт хөшөөнөөс ХХ зууны эхэн үеийн Да Лам Цэрэнчимэдийн гэрэлт хөшөө хүртэл тасралтгүй үргэлжилж байсан нь түүхийн биет баримтаар батлагдахын зэрэгцээ нүүдэлчдийн төрт улсууд нь бичгийн өндөр соёлтой байсныг тодотгох баримт ажээ.

## ХАД ЧУЛУУНД СИЙЛСЭН БИЧЭЭС

*Тайхар чулууны бичээс.* Архангай аймгийн Ихтамир сумын нутаг, хойд Тамир голын хөвөөнд орших Тайхар чулуунаа улаан зосон зураг хийгээд руни, согд, уйгур, монгол, дөрвөлжин, төвд, манж, тод, ланз, нангиад зэрэг арав гаруй зүйл үсэг бичгийн 200-аад дурсгалыг улаан болон хар бэхээр бичиж үлдээсэн байдаг.


1891 онд Оросын шинжлэх ухааны академиас В.В.Радловоор удирдуулж илгээсэн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан археологич Д.А.Клеменц Тайхар чулууны руни бичгээс 10 хэсэг бичээсийг хуулж авсан байна. Түүний гар хуулбарт тулгуурлаж Тайхир чулууны дээрх 10 мөр бичээсийг уншиж тайлсан судалгаагаар В.Радлов “Хойд Тамирын бичээс” нэртэйгээр 1894 онд хэвлүүлснээр шинжлэх ухааны эргэлтэд анх орсон байна.



*Архангай аймаг, Ихтамир сум,  
Тайхар чулууны Хятан бичээс*

Тиймээс гадаадын эрдэмтэд Тайхар чулууны бичээсийг Хойд Тамирын бичээс гэдэг нэрээр мэдэх болжээ. Нэрт түүхч Х.Пэрлээ гуай 1960 онд “Тайхир чулуу” хэмээх эмхтгэлдээ шинээр нэгжээд мөр илрүүлж оруулснаас гадна С.Харжаубай, О.Ф.Серткаева зэрэг судлаачид нэмж илрүүлсэн бичээсийг уншиж тайлсан судалгаагаар хэвлүүлжээ. Хожим МУИС-ийн Түрэг судлалын салбарынхан Тайхар чулууны руни бичээсийг тухайлан бүртгэсэн бөгөөд руни бичгийн 30 гаруй бичээс буйгаас ихэвчлэн хар бэхээр бичсэн, харин Тайхар чулууны дээд хэсгээр улаан бэхээр бичсэн хэд хэдэн бичээс байх ажээ. Тайхар чулуун бичээсийн агуулга нь ерөнхийдөө аян

замын тэмдэглэлийн шинж чанартай тул, зорчиж өнгөрсөн тухай, аян зам өлзийтэй байхыг ерөөл талбигсан бичээс зонхилох ба эдгээр бичээст Монголын түүхэнд нэр алдараа дурсгасан Кул-чур, Цогт тайж зэрэг түүхэн бие хүмүүсийн нэр дурдагдагаараа түүх, соёлын өндөр ач холбогдолтой сурвалж болдог байна.



*Хэнтий аймаг, Батширээт сум, Рашаан хадны "араб" бичээс*

*Рашаан хадны бичээс.* Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг, Биндэр уулын зүүн урд байрлана. Рашаан хаднаа түүхийн өөр өөр үед хамаарах хэдэн зуун тамга тэмдэг, хүн амьтны дүрс зураг нь байдаг бөгөөд хуучин чулуун зэвсгийн үед ч хамаарах зургууд бий. Мөн Рашаан хадны хэд хэдэн хаданд 10- аад төрлийн 30 гаруй бичиг үсгийн дурсгал байдгийг өмнө нь энэ дурсгалын орчимд судалгаа шинжилгээний ажил хийсэн эрдэмтэн судлаачид, хэл шинжлэлтэн нар өөрсдийн судалгааны ажилдаа түшиглэн тэмдэглэсэн байдаг. 2009-2011 онд Монгол-Ядоны хамтарсан "Их Хэнтий төсөл"-ийн хүрээнд тус дурсгалт газраас хятан, монгол,

турэг, тувд, араб, дөрвөлжин, хятад зэрэг 7 төрлийн нийт 60 гаруй бичээсийг баримтжуулан бүртгэж авсан байна.

*Сэрвэн хаалганы бичээс.* Хэнтий аймгийн Баянхутаг сумын Жаргалант багийн нутаг Хэрлэн голын урд хөндийд орших зэрэгцсэн хадтай гурван шовх уулыг Сэрвэн хаалга хэмээн нэрийднэ. Энэ уулын баруун талын шовх өндрийн энгэрт хоорондоо 10-аад м-ийн зайтай орших 2 том боржин хадны наран зүгт харсан тэгш гадаргуу дээр эртний нанхиад, зөрчид хоёр бичээс бий.

Зүүн талд нь 3.1x4.8м орчим хэмжээтэй хаднаа 9 мөр нанхиад бичээс, баруун талын 3.4x4.5м орчим хэмжээтэй өргөн хаданд 11-16 үсэгтэй 9 мөр зөрчид бичээс байна. Энэхүү эртний бичээсийг анх Х.Пэрлээ сураглан олж, Ц.Шагдарсүрэн, Б.Сумъяабаатар нар



*Хэнтий аймаг, Баянхутаг сум,  
Сэрвэн хаалганы бичээс*

хэвлэлд нийтэлжээ. Сэрвэн хаалганы бичээсийг 1986 онд Ц.Шагдарсүрэн судалж зөрчид бичээс гэж тогтоосон. 1991 онд Д.Цэвээндорж, Японы археологич Като Шимпей нарын удирдсан хээрийн шинжилгээний ангийн эрдэмтэд эдгээр бичээсийг дахин очиж судалжээ. Като Шимпей зөрчид бичээсний эхний мөрд "Их төвийн алтан улсын О-Гяо Жео-шэо" гэсэн хэргэм зэргийн нэр байна гэж уншаад "Алтан улсын түүхэнд" "Он-янг чангшиан" гэж

